




issa

EXCELLENCE IN SOCIAL SECURITY

ОЛОН УЛСЫН НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ХОЛБООНЫ УДИРДАМЖ

Нийгмийн хамгааллын хамрах хүрээг өргөтгөх захиргааны шийдлүүд

2022



Олон Улсын Нийгмийн Хамгааллын Холбоо (ОУНХХ)-ны энэхүү Удирдамж нь нийгмийн хамгааллын захиргааны чиглэлээр олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн стандартуудаас бүрдсэн бөгөөд ОУНХХ-ны Нийгмийн хамгааллын захиргаа, удирдлагыг хөгжүүлэх төвийн ажлын нэг хэсэг юм.

ОУНХХ-ны гарын авлагыг ОУНХХ-ны техникийн зөвлөл болон Ерөнхий нарийн бичгийн дарга нарын газрын мэргэжилтнүүд, Олон улсын байгууллагууд, Дэлхийн ОУНХХ-ны гишүүдийн хийсэн өргөн хүрээний зөвлөгөөний үндсэн дээр боловсруулсан болно.

ОУНХХ-ын бүх удирдамж, гарын авлагын үндсэн хэл нь Англи хэл болно. ОУНХХ-ны энэхүү удирдамж болон холбогдох эх сурвалжийн мэдээллүүдийг <www.issa.int/excellence> холбоосоор авах боломжтой.

Энэхүү удирдамжид багтсан мэдээллийг бэлтгэх, боловсруулахад нарийн хяналт тавьж ажилласан ч ОУНХХ нь орхигдсон мэдээлэл, гарсан алдаа, ерөнхийдөө энэ Удирдамжийг ашиглахтай холбогдон гарсан аливаа санхүүгийн болон бусад алдагдал, хохиролд хариуцлага хүлээхгүй болно.

Энэхүү гарын авлагыг Creative Commons Attribution-NonCommercial-NoDerivs 4.0 Unported License-ийн дагуу гаргасан болно (CC BY-NC-ND 4.0).

2022 оны шинэчилсэн хувилбар

ISBN 978-92-843-1224-5

© Олон Улсын Нийгмийн Хамгааллын Холбоо 2022

АГУУЛГА

Танилцуулга	5
ОУНХХ-ны Хамрах хүрээг өргөтгөх захиргааны шийдлүүдийн талаар Удирдамжийн зорилго.....	5
ОУНХХ-ны Хамрах хүрээг өргөтгөх захиргааны шийдлүүдийн талаар Удирдамжийн бүтэц.....	9
А. ХАМРАХ ХҮРЭЭГ ӨРГӨТГӨХ ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ШИЙДЛҮҮД	10
А.1 Хэрэгжүүлэх таатай орчныг үнэлэх, бүрдүүлэх	10
Удирдамж 1. Хэрэгжүүлэх таатай орчныг үнэлэх	11
Удирдамж 2. Хамрах хүрээг өргөтгөхөд шаардлагатай эрх мэдлийг баталгаажуулах	13
А.2 Нийгмийн хамгааллын байгууллагын бэлэн байдлыг хангах	14
Удирдамж 3. Хамрах хүрээг өргөтгөх стратеги төлөвлөгөө боловсруулах	15
Удирдамж 4. Захиргааны удирдлагад түншлэлийг хөгжүүлэх.....	17
Удирдамж 5. Төрөл бүрийн үйлчилгээ, түүнийг хүргэж байгаа барилга, байгууламжид тохирох стандартыг тогтоох	19
Удирдамж 6. Мэдээлэл, харилцаа холбооны технологийн чадавхыг бүрдүүлэх	20
Удирдамж 7. Хариуцлагатай захиргааны бүтцийг бий болгох	22
А.3 Хамрагдахад хүндрэлтэй бүлгүүдэд хүрч ажиллах, мэдээлэх, мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх	23
Удирдамж 8. Албан бус эдийн засагт ажиллагчдыг оролцуулан хамрагдахад хүндрэлтэй хүн амын бүлгүүдтэй харилцах, итгэлцлийг бий болгох харилцааны стратегийг боловсруулах ..	24
А.4 Бүртгэлийн үр дүнтэй тогтолцоог хөгжүүлэх	25
Удирдамж 9. Зорилтот бүлгийг тогтоох тогтолцоог бий болгох	26
Удирдамж 10. Бүртгэлд тавигдах мэдээллийн шаардлагыг хялбарчлах	27
Удирдамж 11. Бүртгэлийн үйл явцыг хөнгөвчлөх	28
Удирдамж 12. Мэдээллийн сангийн чанарыг сайжруулах механизм	29
А.5 Шимтгэл төвлөрүүлэх, түүний журмыг сайжруулах шийдлүүдийг зөв тодорхойлох.....	30
Удирдамж 13. Шимтгэл тооцох суурийг сонгох.....	31
Удирдамж 14. Шимтгэл төлөх тохиромжтой арга, давтамжийг хэрэгжүүлэх.....	32
Удирдамж 15. Шимтгэл төвлөрүүлэх, дагаж мөрдөх журмыг хэрэгжүүлэх зорилгоор бусад байгууллагатай хамтран ажиллах.....	34
Удирдамж 16. Сайн дураар даатгуулах, албан салбарт шилжихийг дэмжих	35
Удирдамж 17. Захиргааны алдаа, шимтгэл төлөлтөөс зайлсхийх, залилан мэхлэлтийг шийдвэрлэх идэвхтэй стратеги батлах.....	36
Удирдамж 18. Үйлчилгээг хүргэх төлөвлөгөө боловсруулах	39
Удирдамж 19. Цахим төлбөр тооцоо, онлайн үйлчилгээг оновчтой ашиглах.....	40
Удирдамж 20. Биечлэн үйлчилгээ авах болон онлайн үйлчилгээнд тохирсон бүтцийг тогтмол сайжруулах.....	42
Удирдамж 21. Тэтгэвэр, тэтгэмжийн эрхийн зохицуулалт, шилжих боломжийг сайжруулах.....	44

Удирдамж 22. Эрүүл мэндийн даатгалын онцлогт тохирсон орчны судалгааг боловсронгуй болгох	48
Удирдамж 23. Аливаа ялгаваргүйгээр нийт хүн амд зориулсан эрүүл мэндийн тусламж үйлчилгээг бий болгох	50
Удирдамж 24. Улсын хэмжээнд хүн амд хүргэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг бэхжүүлэх.....	52
Удирдамж 25. Үзүүлж буй эрүүл мэндийн тусламж үйлчилгээний үр ашгийг тогтмол үнэлэх	54
Удирдамж 26. Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн тогтвортой байдлыг хангах	56
Удирдамж 27. Эрүүл мэндийн мэдээллийн кампанит ажил зохион байгуулах, түгээх	58
Удирдамж 28. Тодорхой зохицуулалттай төлөвлөгөөний дагуу даатгалыг хамгаалах нь ...	60
Удирдамж 29. Эрүүл мэндийн бүтээгдэхүүний салбарт эрүүл мэндийн аюулгүй байдлыг сайжруулах	62
Удирдамж 30. Эрүүл мэндийн бүтээгдэхүүний зардлыг зохицуулах, хэрэглээг чанаржуулах	64
Удирдамж 32. Архаг, хүнд өвчнөөс сэргийлэх, урьдчилан сэргийлэх үзлэгийг дэмжих замаар хувь хүний эрүүл мэндийг сайжруулах	68
Удирдамж 33. Хамруулах хүн амын бүлгийг тодорхойлох.....	71
Удирдамж 34. Нийгмийн хамгааллын тэтгэмжийн бүртгэлийг бий болгох.....	73
Удирдамж 35. Албан ёсны болгох, шилжилтийн стратегийг тодорхойлох	75
Удирдамж 36. Үйлчилгээ, хөтөлбөрүүдийн эдийн засгийн загварыг тодорхойлох.....	77
Удирдамж 37. Үйлчилгээ, хөтөлбөрүүдийн байнгын нөхцөлүүдийг тогтоох	79
Удирдамж 38. Олон нийттэй харилцах стратегийг тодорхойлох.....	80
Удирдлага 39. Захиргааны үйл явцыг хялбарчлах: Бүртгэл ба хамруулалт	82
Удирдлага 40. Захиргааны үйл явцыг хялбарчлах: Шимтгэл төвлөрүүлэлт.....	84
Удирдамж 41. Захиргааны үйл явцыг хялбарчлах: Тэтгэмж хүртээх журам, арга хэрэгсэл	86

Танилцуулга

Иргэд ямар ажил эрхэлж, ямар нөхцөлд амьдарч байгаагаас үл хамаарч бүх нийтийн нийгмийн хамгааллыг хүртэх, бүрэн хамрагдах асуудал нь нийгмийн хамгааллын бүх салбарт тулгамдаж буй асуудал төдийгүй бусад чиглэлийн байгууллагуудад ч тодорхой түвшинд хамаатай асуудал тул хамтын ажиллагааг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Удирдамжид тусгасан зөвлөмжүүд нь нийгмийн хамгааллын хөтөлбөрт хамрагдахад хүндрэлтэй ("хүрэхэд хүндрэлтэй" гэж нэрлэдэг) хүн амд онцгой анхаарч, нийгмийн хамгааллын хүртээмжийг сайжруулах захиргааны шийдлүүдийг багтаасан болно. Эрүүл мэндэд нөлөөлөгч нийгэм эдийн засаг, хүрээлэн буй орчин буюу амьдрах орчныг багтаасан динамик, уян хатан, цочролд тэсвэртэй нийгмийн хамгааллын тогтолцоог бүрдүүлэх алсын хараатай стратегийн дагуу ОУНХХ нь хэд хэдэн арга хэмжээг хэрэгжүүлж нийгмийн хамгааллын хамрах хүрээг өргөтгөх зорилготой ажилладаг. Үүнд, ОУНХХ-ны Нийгмийн хамгааллын хамрах хүрээг өргөтгөх стратеги, ОУНХХ-ны Хувиараа хөдөлмөр эрхлэгчид, цагаач ажиллагчдын нийгмийн хамгааллын хамрах хүрээг өргөтгөх удирдамж болон тодорхой судалгаанууд, тухайлбал БРИКС-ийн орнуудын тайлан, Францын Нийгмийн Хамгааллын Үндэсний Сургуулиас (École nationale supérieure de sécurité sociale – EN3S) гаргасан Евроазийн цагаач ажиллагчдын эрүүл мэндийн даатгалын зохицуулалтын асуудлыг тусгасан нийгмийн хамгааллын үндсэн удирдамжийн баримт бичиг зэрэг багтана. Дэлхий даяар хэрэгжиж байгаа эрүүл мэндийг хамгаалах хөтөлбөрийн хамрах хүрээг өргөтгөх бүх туршлагауудыг шинээр гарч ирж буй болон хэрэгжиж байгаа стратегиудын аль алинд нь мэдээлэл болгон ашиглаж болдог.

Ковид-19 цар тахал нь илүү хүртээмжтэй нийгмийн хамгааллын хэрэгцээг улам бүр нэмэгдүүлсэн билээ. Нийгмийн хамгааллын өргөн хүрээний багцын нэг хэсэг болох эрүүл мэндийн даатгал нь үр өгөөжөө богино хугацаанд өгдөг тул иргэдийн анхаарлыг илүү татдаг бөгөөд ингэснээр өндөр насны болон ажилгүйдлийн эрсдэлээс хамгаалах гэх мэт бусад урт хугацааны тэтгэвэр тэтгэмжийн хөтөлбөрт хамрагдах магадлалыг нэмэгдүүлдэг байна.

ОУНХХ-ны Хамрах хүрээг өргөтгөх захиргааны шийдлүүд

ОУНХХ-ны Хамрах хүрээг өргөтгөх захиргааны шийдлүүдийн тухай удирдамж нь нийгмийн хамгааллын байгууллагууд шимтгэлд суурилсан хөтөлбөрүүдийг үр дүнтэй хэрэгжүүлэх, хамрагдахад хүндрэлтэй бүлгүүдтэй ажиллах захиргааны чадавхыг бэхжүүлэх зорилготой. Удирдамжид дурдаж байгаа хамрагдахад хүндрэлтэй бүлгүүд гэдэгт хувиараа хөдөлмөр эрхлэгчид, "орхигдсон дундаж" ажиллагчид, ихэвчлэн албан бус салбарт хөдөлмөр эрхэлдэг цагаач болон гэрийн ажиллагчид, мөн хөдөө аж ахуй, загас агнуурын салбарын ажиллагчид гэх мэт олон төрлийн ажиллагчдыг хамруулдаг.

Хамрагдахад хүндрэлтэй бүлгүүдэд хамрах хүрээг өргөтгөх өөр өөр цогц стратеги

Нийгмийн хамгааллын нийтлэг хөтөлбөрүүдийн хамрах хүрээг өргөтгөхийн тулд албан журмын шимтгэлийн хөтөлбөрүүд, татаастай шимтгэлийн хөтөлбөрүүд (жишээ нь, шимтгэлийн нэг хэсэг нь татвараас санхүүждэг), шимтгэлгүй татвараар санхүүждэг хөтөлбөрүүд, сайн дурын шимтгэлийн хөтөлбөрүүд болон биет бус тэтгэмжийн хөтөлбөрүүдийг хослуулан ашигладаг. Улс орнуудын өмнө тулгарч байгаа тодорхой сорилтууд нь тухайн улс өөрийн онцлогт тохирсон арга замыг хэрэгжүүлэхийг шаардаж байна. Шимтгэлгүй, татвараас санхүүждэг нийтлэг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд, жишээлбэл, гар утасны хөгжил нь хамрах хүрээг илүү хурдан өргөтгөхөд тусалж байгаа

бол зарим улс оронд нийгмийн хамгааллын хамрах хүрээг уламжлалт байдлаар буюу эхлээд тодорхой бүлэг ажиллагчид, ажил олгогчдод хамрагдах боломжийг олгох замаар нийгмийн хамгааллын шимтгэлийн хөтөлбөрүүдийг аажмаар нэвтрүүлэх, өргөтгөх аргыг ашиглаж байна. Өөрөөр хэлбэл, эхний ээлжид сонгогдсон бүлгүүд нь захиргааны мэдээлэлд албан ёсоор бүртгүүлэх боломжтой, тогтмол шимтгэл төлөх чадвартай хүмүүс байдаг. Үүний дараа улс орнууд хөдөлмөрийн зах зээл, нийгэм, эдийн засгийн хөгжлийн түвшинтэйгээ уялдуулан нийгмийн хамгааллын хамрах хүрээг тэлэх, гүнзгийрүүлэхэд аажмаар шилжиж байна. Үүнийг ихэвчлэн таван үе шаттай хөгжлийн арга гэж нэрлэдэг, өөрөөр хэлбэл тэтгэмжийн хангалттай, эрх тэгш байдал, хөрвөх чадвар, урт хугацааны тогтвортой байдлын асуудлыг зохих ёсоор анхаарч 1) ямар ч хуулийн зохицуулалтгүйгээс эхний хөтөлбөрийг нэвтрүүлж эхлэх, 2) хязгаарлагдмал хүний тооноос илүү олон тооны хүн хамрагдах, 3) нэг хөтөлбөрөөс илүү олон тооны эрсдэлээс хамгаалахад чиглэсэн иж бүрэн хөтөлбөрүүд рүү шилжих, 4) тэтгэмжийн суурь түвшнээс илүү өгөөмөр түвшинд хүрэх, 5) тусдаа хөтөлбөрүүдээс илүү зохицуулалттай, нэгдсэн хөтөлбөрүүдэд шилжих явдал юм.

Нийгмийн бүх гишүүдийг нийгмийн хамгааллын суурь түвшнээр хангах зорилгоор Олон Улсын Хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)-аас 2012 оны Нийгмийн хамгааллын суурь түвшний тухай 202 дугаар зөвлөмжийг баталснаар олон улсын нийгмийн хамгааллын стандартууд бэхэжсэн. Энэхүү зөвлөмжид олон улс оронд өмнө нь нийгмийн хамгаалалд хамрагддаггүй байсан нэгэн чухал бүлэг болох албан бус салбарын ажиллагчид болон тэдний гэр бүлийн гишүүдийг оролцуулан бүх хүнийг хамруулах удирдамжийг өгсөн байдаг.

Нийгмийн хамгааллын суурь түвшнийг бий болгох, хадгалах нь нийгмийн хамгааллын хамрах хүрээг өргөтгөхөд чухал ач холбогдолтой юм. ОУХБ-аас гаргасан стандартын дагуу нийгмийн хамгааллын суурь түвшин нь үндэсний хэмжээнд тодорхойлсон нийгмийн хамгааллын дараах үндсэн баталгааг хангаж байх ёстой.

- Жирэмсний амралт болон эрүүл мэндийн зайлшгүй тусламж, үйлчилгээ нь нийтлэг, бүх хүнд хүртээмжтэй байх;
- Хүүхдийн хоол тэжээл, боловсрол, халамж болон бусад шаардлагатай бараа, үйлчилгээг хүртэх боломжийг олгох суурь орлогын баталгаа;
- Хөдөлмөрийн насанд хүрсэн боловч хангалттай орлого олох боломжгүй, ялангуяа өвчин эмгэг, ажилгүйдэлд өртсөн, хүүхэд төрүүлсэн, тахир дутуу болсон хүмүүсийн суурь орлогын баталгаа;
- Өндөр насны суурь орлогын баталгаа;

Түүнчлэн, ОУХБ-ын Албан бус салбараас албан салбарт шилжих тухай 2015 оны 204 дүгээр Зөвлөмж нь албан бус эдийн засагт ажиллагчдын нийгмийн хамгаалал дутмаг байгааг онцолж, тэдний нийгмийн хамгааллыг сайжруулах, албан салбарт шилжихэд нь дэмжлэг үзүүлэх удирдамжийг өгсөн байдаг.

Эдгээр удирдамжаас санал болгосон захиргааны шийдлүүд нь олон талаараа дээрх хоёр зөвлөмжийг хэрэгжүүлэхэд тустай байдаг.

Нийгмийн хамгааллын хөтөлбөрүүд нь ихэвчлэн тодорхой, олон зорилготой байдаг (жишээлбэл, ядуурлыг бууруулах, дахин хуваарилах, хэрэглээг жигд хангах, даатгал г.м). Хөтөлбөрийг санхүүжүүлэхэд ямар санхүүжилтийн механизмыг сонгох вэ гэдэг нь эдгээр зорилгуудаас ихээхэн хамаардаг. Шимтгэлд суурилагагүй нийтлэг хөтөлбөрүүд нь

ядуурлыг бууруулахад ихээхэн эерэг нөлөө үзүүлж, олон оронд, ялангуяа эмэгтэйчүүд, эмзэг бүлгийнхний нийгмийн хамгааллын суурь түвшнийг хангаж ирсэн ч урт хугацаанд ийм хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, өргөтгөхөд төсвийн байнгын эх үүсвэр шаардлагатай байдаг. Хөдөлмөрийн насны иргэд эдийн засгийн хувьд идэвхгүй байх эсвэл тэтгэвэрт гарсны дараа буюу ажиллах хүчнээс гарсны дараа орлогын алдагдлыг нөхөх зорилготой хөтөлбөрүүдийг ихэвчлэн ажилтан, ажил олгогчийн оруулсан шимтгэлээр санхүүжүүлдэг. Шимтгэлд суурилсан хөтөлбөрөөс олгодог тэтгэвэр, тэтгэмжийн түвшин нь ажилтны өмнөх орлогын түвшинтэй холбоотой байх хүлээлт байдаг. Тухайлбал, эдийн засгийн нөхцөл байдлаас хамаарч энэ түвшин нь тэтгэмжийн хэмжээ хэр хангалттай байхыг тодорхойлдог (хэрэглээг жигд хуваарилах зарчим).

Иргэдийн амьжиргааны түвшин дээшилж, тэдний хүлээлт нэмэгдэхийн хэрээр өрхийн орлого, төсвийн орон зай, чадавх сайжирсан тохиолдолд нийгмийн хамгааллын хамрах хүрээ, тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ нэмэгдэх боломжтой. Нийгмийн хамгааллын үндэсний тогтолцоог бүрдүүлдэг нийгмийн даатгалын хөтөлбөрүүдийн олон зорилгуудыг тогтвортой хэрэгжүүлэхийн тулд шимтгэлд суурилсан болон суурилаагүй санхүүжилтийн механизмыг хослуулан ашиглах, ажилтан, ажил олгогчид, шимтгэлтэй болон шимтгэлгүй аль аль хөтөлбөрт хамрагдсан хүн амд үзүүлэх урамшуулал болон тодорхой хязгаарлалтыг харгалзан үзэх нь чухал юм.

Ийм хөтөлбөрүүдийн удирдлагуудад үүсэж байгаа боломж, чиг үүргүүд нь ижил төстэй байдаг. Захиргааны удирдлагыг сайжруулахын тулд бүртгэлийн механизм, мэдээлэл боловсруулалт, харилцаа холбоо, үйлчилгээг хүргэх, тэтгэвэр, тэтгэмжийг олгох, маргаан шийдвэрлэх үйл явцыг харьцуулахдаа ижил төстэй байдлыг ашиглах, боломжтой бол тохирох бизнесийн арга барилыг хэрэгжүүлэхэд анхаарах хэрэгтэй. Цаашилбал, хөтөлбөрөөс олгох тэтгэвэр, тэтгэмж нь иргэдийн уг хөтөлбөрт хамрагдах сонирхлыг татах хэмжээнд байх ёстой.

Шимтгэлд суурилсан хөтөлбөрүүдийг өргөтгөхөд тулгарч буй гол бэрхшээлүүд

Шимтгэлд суурилсан хөтөлбөрүүдийн тэргүүлэх чиглэл нь чанартай, боломжийн үнэтэй эрүүл мэндийн даатгалд хүн амыг үр дүнтэй хамруулах явдал юм. Нийгмийн хамгааллын байгууллагуудын туршлагаас харахад шимтгэлд суурилсан хөтөлбөрүүд нь албан салбарт ажиллаж байгаа ажилтнуудад өндөр насны, хөгжлийн бэрхшээл, тэжээгчээ алдсаны, үүний дараа ажлын байрны гэмтэл, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх хөтөлбөрүүд гэсэн дарааллаар түгээмэл хэрэгждэг байна. Өндөр хөгжилтэй эдийн засагтай орнуудын хувьд ч шимтгэлд суурилсан урт хугацааны эрүүл мэндийн хөтөлбөр ховор байдаг боловч хүн амын хөгшрөлтийг харгалзан үзвэл дунд хугацаанд дээрх асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байгаа нь эргэлзээгүй юм. Ажилгүйдлийн даатгалын хөтөлбөрүүд улам түгээмэл болж байгаа ч дэлхийн нийт улс орны талаас бага хувьд нь хэрэгжиж байна. Олон оронд өвдсөн, амаржсаны болон гэр бүлийн халамжийн мөнгөн тэтгэмжийг ажил олгогч, ажиллагчдын шимтгэлээр санхүүжүүлдэг.

Хамрах хүрээг өргөтгөх, албан салбарт шилжүүлэхэд дэмжлэг үзүүлэхийн тулд шимтгэлд суурилсан хөтөлбөрүүдийн загвар, удирдлага нь хамрагдахад хүндрэлтэй (эсвэл хүрэхэд хүндрэлтэй) бүлгүүдийн онцлог нөхцөлийг харгалзан үзэх шаардлагатай. Үүнд:

- *Ажил болон ажлын газраа байнга солих.* Нийгмийн хамгааллын захиргааны удирдлагын хувьд ажил, ажлын байр ийнхүү тогтмол солигдох нь иргэний бүртгэл, мэдээлэл хөтлөх, шимтгэл төвлөрүүлэх, түүнчлэн нийгмийн бүлэг, бүс нутгаар

тусдаа хэрэгждэг хөтөлбөрүүдэд тэтгэвэр, тэтгэмжийн давхцалыг арилгахад үр дүнтэй зохицуулалт, мэдээлэл солилцоо, харилцаа холбоо (ICT)-ны дэмжлэг байхгүй тохиолдолд хүндрэл учруулдаг. Ийм нөхцөлд олон хөтөлбөрт зэрэг бүртгүүлэх, тэтгэмжийг давхардуулан олгох зэрэг нь шударга байдлын асуудал, хөтөлбөрийн зардал нэмэгдэх бэрхшээлийг үүсгэдэг. Тиймээс өөр өөр хөтөлбөрүүдийн хоорондын өргөн хүрээний, сайжруулсан зохицуулалт шаардлагатай байдаг.

- *Бага, хэлбэлзэл бүхий шимтгэл төлөх чадвар.* Ийм нөхцөл нь шимтгэл, тэтгэмжийг тооцох суурь хэмжээг тодорхойлоход хүндрэл учруулж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ зэрэг гол чиглэлд, тэр байтугай тэтгэвэр гэх мэт урт хугацааны тэтгэмжийн хувьд ч шимтгэлийг бүрэн, тогтмол төлөхөд хүндрэл учруулдаг. Шимтгэлийн түвшний асуудал, түүнээс үүдэлтэй тэтгэмжийн бүтэц нь бага, тогтмол биш (улирлын чанартай) орлоготой ажилтнуудын шимтгэлийн чадавхыг нэмэгдүүлэх аргыг эрэлхийлэх ёстой. Шимтгэл төлөхөд дэмжлэг үзүүлэх зорилгоор шимтгэлийн татаас зэрэг урамшуулал олгож болдог.
- *Ажил олгогч, ажилтны албан ёсны харилцаа байхгүй.* Ажил олгогчид нийгмийн даатгалын байгууллагатай албан ёсны харилцаатай байж, ажилтнуудаа бүртгүүлэх, өөрийн болон ажилтнуудынхаа шимтгэлийг цаг тухайд нь, бүрэн төлөх талаар хуулиар үүрэг хүлээдэг. Нийгмийн хамгааллын байгууллагын өмнө тулгамдаж буй асуудал бол албан салбарт идэвхтэй оролцдоггүй, хувиараа хөдөлмөр эрхэлдэг ажилтнуудыг дэмжих захиргааны оновчтой шийдлийг боловсруулах, захиргааны үйл явцыг хялбарчлах, бүртгэл, хамрагдалт, шимтгэл төлөхөд учирч буй хүнд суртлыг багасгах явдал юм.
- *Бичиг үсгийн боловсролын түвшин доогуур.* Хүрэхэд хүндрэлтэй хүн ам нь ихэвчлэн бичиг үсэг тайлагдаагүй эсвэл үндэсний хэлээр ярьдаггүй, жишээлбэл, цагаач ажилтнууд байдаг. Тэд орчин үеийн интернэтэд суурилсан төхөөрөмжүүдийг ашиглах чадваргүй эсвэл тэдгээр нь байхгүй байж болно.
- *Албан эдийн засгийн салбарын ажилтнуудтай харьцуулахад зохион байгуулалтын түвшин доогуур.* Хамрагдахад хүндрэлтэй ажилтнууд албан эдийн засгийн салбарт ажилладаг ажилтнуудтай харьцуулахад сул зохион байгуулалттай байдаг. Хоршоолол, загасчдын холбоо, цагаач ажиллагчдын байгууллага зэрэг үйлдвэрчний эвлэл, мэргэжлийн холбоод байгаа тохиолдолд Нийгмийн даатгалын байгууллага нь эдгээр байгууллагатай хамгийн түрүүнд хамтран ажиллаж, ажилтнуудыг бүртгэх, шимтгэл цуглуулах замаар албан ёсны болгох гүүр болж ажиллах ёстой.
- *Захиргааны саад бэрхшээл.* Бичиг баримтгүй, албан ёсны хэл, уламжлалт харилцааны хэрэгслээр харилцахад бэрхшээлтэй, алслагдсан газар байдаг, гэрийн үйлчлэгч гэх мэт ялгаварлан гадуурхалт, доромжлолд өртөх магадлалтай тодорхой бүлэг хүмүүс болон банк санхүүгийн үйлчилгээнд хамрагдах боломж хомс байдал нь захиргааны зардлыг өндөр болгодог зарим хүндрэл бэрхшээлүүд юм. Тэгэхээр орчин үеийн харилцаа холбооны сувгууд, сайн тоноглогдсон хөдөлгөөнт оффисууд, олон нийтийн байгууллагуудаар дамжуулан хүртээмжийг сайжруулах тохиромжтой, хэмнэлттэй арга хэрэгслийг ашиглах нь тулгамдаж байгаа асуудал юм.

ОУНХХ-ны Хамрах хүрээг өргөтгөх захиргааны шийдлүүд

Удирдамж дараах гурван хэсгээс бүрдэж байна.

А хэсэг, Хамрах хүрээг өргөтгөх захиргааны ерөнхий аргууд- хүн амын бүлгүүд, нийгмийн хамгааллын хөтөлбөрүүдээс үл хамаарч хамрах хүрээг үр дүнтэй өргөтгөх удирдамжийг өгөх.

Б хэсэг, Эрүүл мэндийн үйлчилгээний хамрах хүрээг тогтвортой байлгах, хүн амын дунд итгэлийг бий болгох зохицуулалтын стратегийг тодорхойлох- урт хугацааны, оролцогч бүх талуудад хүлээн зөвшөөрөгдөхүйц үр дүнтэй зохицуулалтын төлөвлөгөөг бий болгох, байгаа өгөгдлүүдэд үндэслэн арга хэмжээг хэрэгжүүлэх арга хэрэгслийн талаар санал дэвшүүлэх.

В хэсэг, "Орхигдсон дундаж" -ийг авч үзэх- энэхүү сорилттой бүлэгт нийгмийн хамгааллын хамрах хүрээг өргөтгөх, албан салбарт шилжүүлэх арга замуудыг авч үзэх.

Дээр дурдсан хэсэг тус бүрд захиргааны шийдлүүдийн элементүүдийг хэрхэн ашиглаж байгаагаар нь удирдамжуудыг бүлэглэсэн болно. Тэдгээрийг дараах байдлаар үзүүлэв.

Удирдамж. Удирдамжуудыг аль болох ойлгомжтой байхаар тодорхойлох.

Бүтэц. Энд удирдамжийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, үндсэн зарчмыг дэлгэрүүлэхэд туслах бүтцийг санал болгох юм. Бүтэц нь удирдах зөвлөл, удирдлагын багаас тогтоосон зорилго, хүрээг заана.

Механизм. Удирдамжийг хэрэгжүүлэх янз бүрийн арга замууд байх болно. Удирдамжид мөн техникийн лавлагаа болон сайн туршлагын жишээнүүдийн холбоос багтсан болно.

А. ХАМРАХ ХҮРЭЭГ ӨРГӨТГӨХ ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ШИЙДЛҮҮД

Энэ хэсэгт хүн амын бүлэг, нийгмийн хамгааллын хөтөлбөрүүдээс үл хамаарч нийгмийн хамгааллын хамрах хүрээг өргөтгөхөд чиглэсэн захиргааны ерөнхий арга барилын талаар удирдамжийг өгөх болно. Үүнд, хүрэхэд хүндрэлтэй бүлгийн хамрах хүрээг өргөтгөхөд тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхэд нийгмийн хамгааллын байгууллагуудын анхаарах ёстой гол асуудлуудыг тусгасан болно.

Энэ хэсэг нь зургаан хэсгээс бүрдэж байна:

А.1 Хэсэг, Хэрэгжүүлэх таатай орчныг бүрдүүлэх боломжийг үнэлэх, бүрдүүлэх- таатай орчныг бүрдүүлэхэд шаардлагатай гадаад хүчин зүйлүүдийг хэмжих аргуудыг авч үзэх.

А.2 Хэсэг, Нийгмийн хамгааллын байгууллагын бэлэн байдлыг хангах- Нийгмийн хамгааллын байгууллагуудын хамрагдахад хүндрэлтэй бүлгийг хамруулах чиглэлээр гол чадавхыг тодорхойлох.

А.3 Хэсэг, Хамрагдахад хүндрэлтэй бүлгүүдэд хүрч ажиллах, мэдээлэх, мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх- хөтөлбөрийн онцлог, нийгмийн хамгааллын ашиг тусыг хамрагдахад хүндрэлтэй бүлгүүдэд тэдгээрийн онцлогт тохирсон байдлаар хүргэх.

А.4 Хэсэг, Бүртгэлийн үр дүнтэй тогтолцоог хөгжүүлэх – хөтөлбөрт хэрхэн бүртгүүлэх талаар мэдээлэлгүй хүн амыг тодорхойлж, бүртгэх удирдамжийг өгөх.

А.5 Хэсэг, Шимтгэл төвлөрүүлэх, түүний журмыг сайжруулах шийдлүүдийг зөв тодорхойлох - шимтгэлийг тооцох, түүнийг цуглуулах арга, үйл явц нь хамрагдахад хүндрэлтэй бүлгүүдийн тодорхой хэрэгцээ, нөхцөл байдалд тохирсон эсэхийг шалгах.

А.6 Хэсэг, Үйлчилгээ, тэтгэвэр, тэтгэмжийг цаг тухайд нь, үнэн зөв, үр дүнтэй хүргэх - Нийгмийн хамгааллын байгууллагууд хамрагдахад хүндрэлтэй бүлгүүдийн тодорхой хэрэгцээ, нөхцөл байдалд тохирсон тэтгэмж, үйлчилгээг хэрхэн үр дүнтэйгээр хүргэх талаар удирдамж өгөх.

А.1 Хэрэгжүүлэх таатай орчныг үнэлэх, бүрдүүлэх

Хамрах хүрээг өргөтгөхөд шаардлагатай хууль эрх зүйн орчныг бүрдүүлэхэд нийгмийн хамгааллын байгууллагууд идэвхтэй оролцох шаардлагатай байдаг.

Удирдамж 1. Хэрэгжүүлэх таатай орчныг үнэлэх

Нийгмийн даатгалын байгууллага нь нийгмийн хамгаалалд хамрагдахад хүндрэлтэй бүлгүүдэд хамрах хүрээг өргөтгөх таатай орчны стратегийн ач холбогдлыг мэддэг байх нь чухал. Улмаар хамрах хүрээг өргөтгөхөд ашиглаж болох элементүүд болон багасгах шаардлагатай сул талууд тодорхойлогдох болно.

Бүтэц

- Таатай орчин нь ажилтнуудыг албан бус эдийн засгаас албан эдийн засаг руу шилжүүлэхэд туслах хууль эрх зүйн болон институтийн тогтолцооноос бүрддэг. Тухайлбал:
 - Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн хууль тогтоомж, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөр эрхлэлтийн баталгаа, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, ажлын байран дахь хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах талаар суурь хууль тогтоомжийг батлах, эдгээр хууль тогтоомж, зохицуулалтын хэрэгжилтийн түвшин;
 - Иргэний бүртгэл болон статистикийн суурь мэдээллийн тогтолцоо, бизнесийн бүртгэлийн үр дүнтэй үйлчилгээ;
 - Нийгмийн хамгааллын шимтгэл төлөгч болон ашиг хүртэгчдэд мобайл банк, санхүүгийн үйлчилгээ үзүүлэх боломжтой санхүү, харилцаа холбооны дэд бүтцийг бий болгох.

Механизм

- Нийгмийн хамгааллын удирдлагын зүгээс нийгмийн хамгаалалд хамрагдаагүй янз бүрийн бүлгүүдийн нийгэм-эдийн засгийн онцлог, хэрэгцээг ойлгохын тулд судалгаа, зөвлөгөөн, оролцоог хангах ажлыг зохион байгуулж, улам бүр төрөлжиж буй хөдөлмөрийн зах зээлд хамрах хүрээг өргөтгөхөд тулгарч буй саад бэрхшээл, сорилтуудыг тодорхойлох ёстой.
- Удирдлага нь хамрах хүрээг үр дүнтэй өргөтгөхөд саад болж буй хууль эрх зүйн болон захиргааны асуудлуудыг гүнзгийрүүлэн судалж, тэдгээрийг багасгах, арилгах олон хувилбаруудыг санал болгох ёстой.
- Нийгмийн даатгалын байгууллага нь хамрах хүрээ, тэтгэмжийг хэрэгжүүлэхэд гарч байгаа алдаа дутагдлыг тодорхойлох, хамрагдахад хүндрэлтэй бүлэгтэй ажиллахад нийгмийн хамгааллын байгууллагуудад тулгарч буй асуудлуудыг тодорхойлохын тулд одоо хэрэгжиж байгаа хуулийн заалтуудын зураглалыг гаргах ёстой.
- Нийгмийн даатгалын байгууллагаас одоо байгаа орчин нөхцөл нь хамрах хүрээг өргөтгөхөд хэрхэн дэмжлэг үзүүлж байгааг үнэлэх ёстой. Дутагдал, цоорхой байгаа тохиолдолд зохих эрх бүхий байгууллага, оролцогч талуудад түүнийг бууруулах нотолгоонд суурилсан бодит арга хэмжээний зөвлөгөөг өгөх ёстой. Бодлогын хувилбаруудыг боловсруулахад тус дөхөм болох үүднээс энэхүү зөвлөгөөг холбогдох захиргааны мэдээлэл, олон янзын хувилбаруудаар тооцсон актуар шинжилгээнд тулгуурласан байх ёстой.

- Нийгмийн хамгааллын удирдлагын зүгээс аль болох ажилтан, ажил олгогчдын байгууллага, боломжит бусад байгууллагын төлөөллийг зөвлөлдөх уулзалт, тандан судалгаанд оролцуулах ёстой.
- Нийгмийн хамгааллын удирдлага нь ажилтнуудыг албан эдийн засгийн салбарт шилжихэд дэмжлэг үзүүлэх засгийн газрын бусад хүчин чармайлтыг хэрэгжүүлэхэд хэрхэн хөшүүрэг болж, харилцан уялдаатай зохицуулах чадавхаа үнэлэх ёстой.

Удирдамж 2. Хамрах хүрээг өргөтгөхөд шаардлагатай эрх мэдлийг баталгаажуулах

Нийгмийн даатгалын байгууллага нь шинэлэг захиргааны шийдлүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай эрх мэдлийг баталгаажуулсан байх шаардлагатай.

Бүтэц

- Нийгмийн даатгалын удирдлага нь хамрах хүрээг өргөтгөх, ажилтнуудыг алба салбарт шилжүүлэх үндэсний болон олон улсын сүүлийн үеийн сайн туршлагын жишээг дагаж мөрдөх ёстой.
- Нийгмийн даатгалын удирдлага нь хамрах хүрээг өргөтгөхөд туслах захиргааны олон шийдлүүдийн стратегийн ач холбогдлыг мэдэж байх ёстой, үүнд:
 - Үндэсний бүртгэлийн системд суурилсан хөтөлбөрт хамрагдах хялбаршуулсан үйл явцтай, өргөдөл гаргахгүй, автоматаар болон олноороо хамтран хөтөлбөрт хамрагдах боломжтой байх;
 - Шимтгэлийг хялбаршуулсан журмаар авах;
 - Тэтгэмжийг хялбаршуулсан, олон төрлийн систем ашиглан төлөх;
 - Захиргааны зорилгоор бусад агентлагтай мэдээлэл солилцох эрх мэдэлтэй байх;
 - Татварын болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран бүртгэл, шимтгэл төвлөрүүлэлт, тэтгэмж олголтыг хийх, залилан мэхлэлтийг илрүүлэх зэрэг хөтөлбөрийн олон арга хэмжээг хэрэгжүүлэх талаар гуравдагч этгээдтэй тохиролцох эрх мэдэл.

Механизм

- Нийгмийн даатгалын байгууллага нь захиргааны шинэ, сайн туршлагыг судалж, хэрэгжүүлэхэд саад болох эрх мэдлийн цоорхойг сайн олж тогтоох ёстой.
- Инновац гэдэгт хөтөлбөрийн санхүүжилтийн механизм, тэтгэмж төлөх төлбөрийн хуваарь, тэтгэмжийн багцууд, сайн дурын гишүүнчлэл, олон нийтэд түшиглэсэн үйлчилгээ, бусад төрлийн хөтөлбөрүүдтэй хамтран ажиллах, эсвэл удирдлагын зардлыг бууруулж, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн мэдээлэл, харилцаа холбооны технологи (МХХТ)-д суурилсан хялбаршуулсан бизнес аргачлалыг хэрэгжүүлэх зэрэг багтаж болно.
- Нийгмийн даатгалын байгууллага нь хөтөлбөрийг хэрэгжүүлэхээс өмнө учирч болох эрсдэл, сорилт, боломж, аюулын талаар дүн шинжилгээ хийх зорилгоор шинэ шийдэл, аргачлалыг бага хүрээнд туршиж болно.

A.2 Нийгмийн хамгааллын байгууллагын бэлэн байдлыг хангах

Нийгмийн даатгалын байгууллагууд хамрах хүрээг өргөтгөх чиглэлээр ажиллахад зарим дотоод болон гадаад гол чадавх байх шаардлагатай. Ихэнх тохиолдолд хамрах хүрээг өргөтгөх нь янз бүрийн байгууллагын оролцогчдын хамтын ажиллагааг шаарддаг хэвтээ чиглэлд хэрэгждэг ажил юм.

Удирдамж 3. Хамрах хүрээг өргөтгөх стратеги төлөвлөгөө боловсруулах

Нийгмийн даатгалын байгууллага нь бусад холбогдох эрх бүхий байгууллагын удирдлага, дэмжлэгтэйгээр нийгмийн хамгааллын урт хугацааны төлөвлөгөөг боловсруулдаг. Уг төлөвлөгөөг боловсруулахад холбогдох талуудын оролцоог хангах нь асуудлыг эрт илрүүлэхэд туслах төдийгүй хэрэгжүүлэх үе шатанд бусад оролцогчдын дэмжлэгийг авах шаардлагатай.

Бүтэц

- Нийгмийн даатгалын удирдлага нь нийгмийн хамгааллын хамрах хүрээг өргөтгөх зорилго, үе шатыг тусгасан урт хугацааны төлөвлөгөө боловсруулах ёстой.
- Төлөвлөгөөнд гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүд болон хүчин зүйлийн хувьсагчдыг тодорхойлж, бэлэн байгаа захиргааны мэдээлэл, урьдчилсан тооцоог ашиглан суурь үзүүлэлтийг тогтоох ёстой. Хэрэгжүүлэх таатай орчны төлөв байдлыг харгалзан бодит зорилтуудыг тавих нь зүйтэй. Дутагдлыг илрүүлж, тэдгээрийг арилгах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах, арга хэмжээ бүрийг өртөгжүүлсэн байх ёстой. Эрсдэлийг үнэлж, түүнийг бууруулах арга хэмжээг боловсруулах шаардлагатай.
- Төлөвлөгөөний хэрэгжилтийн ахиц дэвшлийг үнэлэхийн тулд төлөвлөгөөг тогтмол хянаж байх ёстой бөгөөд явцын дунд засах, залруулах арга хэмжээ авах боломжтой байх ёстой.

Механизм

- Оролцогч талуудтай үр дүнтэй түншлэлийг бий болгох нь сайн төлөвлөгөө боловсруулах амжилтын гол хүчин зүйл юм. Ийм оролцогч талуудад төрийн бусад хэлтэс, агентлагууд (татварын алба г.м), бусад түвшний засгийн газар, ажиллагчид, ажил олгогчдын байгууллага, ашгийн бус байгууллагууд, түүнчлэн гишүүд нь албан бус ажиллагчид болон хүрэхэд хүндрэлтэй албан салбарын ажиллагчидтай харилцдаг мэргэжлийн байгууллагууд багтаж болох бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй.
- Төлөвлөгөө нь дараах асуудлыг мөн агуулж болно:
 - Байгууллагын чиг үүргийн дагуу хамрагдах зорилтот хүн амыг тодорхой тодорхойлох. Зорилтот бүлгүүдийн орлого, шилжилт хөдөлгөөн, газарзүйн байршил, нийгэм-соёлын онцлог, хэл, бичгийн хязгаарлалт, нийгмийн хамгааллын хэрэгцээ, шимтгэл төлөх хүсэл эрмэлзэл, үйлчилгээний талаар хүлээлт, түүнчлэн эдгээр асуудлыг шийдвэрлэх захиргааны (шаардлагатай бол бодлогын) шийдлүүдийг тусгах.
 - Нэмж хамрагдах хүмүүсийн тоо болон бүлгүүдийн хэрэгцээнд нийцсэн шинэ тэтгэмжийн асуудлыг багтаасан хамрах хүрээг өргөтгөх зорилго, зорилтууд, үе шатуудыг тодорхой, хэмжигдэхүйц, хүрч болохуйц, ач холбогдолтой, тодорхой цаг хугацаанд хэрэгжих (SMART) байдлаар тодорхойлох. Эдгээр зорилго, зорилтыг үндэсний, бүс нутаг, хотын гэх мэт түвшний оролцогч талуудын төлөвлөгөөнд тусгаж, тодорхой үүрэг, хариуцлагыг тусгах ёстой;
 - Хамрагдахад хүндрэлтэй бүлгүүдэд хүрч ажиллах, урамшуулах бодит

бодлогын дэмжлэг, захиргааны шийдлүүдийг багтаах. Үүнд, бүртгэл, шимтгэл төвлөрүүлэх, тэтгэмж олгох гэх мэт захиргааны ажлыг хэрэгжүүлэхийн тулд МХХТ-ийг ашиглан зардлын хэмнэлттэй үйлчилгээг хөгжүүлэх, үйлчлүүлэгчидтэй харилцах гэрээт төвүүдийн сүлжээг бий болгох гэх мэт багтана;

- Боловсон хүчнийг сургах, сонгон шалгаруулах, төрийн болон төрийн бус байгууллага (ТББ)-уудтай хамтран ажиллах, үйл ажиллагааны стандарт, МХХТ-ийн ашиглалт, хөтөлбөрт хамрагдагчид, олон нийттэй харилцах гэх мэт чиглэлээр дунд болон урт хугацааны стратеги;
- Хамрагдахад хүндрэлтэй бүлгүүд, албан ба албан бус эдийн засгийн хөтөлбөрүүд, хоёр болон олон талт хэлэлцээрийн дагуу хэрэгжиж байгаа үндэсний болон гадаадын хөтөлбөрүүдийн хоорондын зохицуулалт, уялдаа холбоог аажмаар сайжруулах;
- Олон нийтийн мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх, хэрэгжилтийг сайжруулах кампанит ажил, хүний нөөцийн хөгжлийн (HRD) санаачилга, олон улсын хөгжлийн тусламж гэх мэт стратегийн хэрэгжилтийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх бусад арга хэмжээ.
- Хувийн мэдээллийг удирдах, тэтгэмж олгох чиглэлээр одоо байгаа хөтөлбөрүүдийн мэдээлэл, туршлагыг ашиглах хэрэгтэй. Нийгмийн даатгалын байгууллага нь нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн байгууллага, яамдын хооронд ихэвчлэн байгуулдаг хоёр болон олон талт нийгмийн хамгааллын гэрээгээр тодорхой төрлийн ажиллагчид (цагаач болон тэдний гэр бүл г.м)-ыг хамруулах, шимтгэл төвлөрүүлэхтэй холбоотой захиргааны зохицуулалтыг авч үзэж болно.
- Нийгмийн даатгалын Байгууллагын төлөвлөгөө нь нийгмийн хамгааллын суурь хөтөлбөрүүдийг бий болгоход чиглэсэн үндэсний яриа хэлэлцээрийн нэг хэсэг бөгөөд энэ төлөвлөгөөг гаргахад ажиллагчид, ажил олгогчдын байгууллага, иргэний нийгмийн төлөөлөл, холбогдох НҮБ-ын агентлагууд болон хөгжлийн түншүүд зэрэг бүх оролцогч талууд бодит хувь нэмэр оруулах хэмжээнд идэвхтэй оролцох ёстой. Нийгмийн даатгалын удирдлагуудын зүгээс хамрах хүрээг өргөтгөх стратеги болон замын зургийг гаргахад туслах мэргэжлийн шинжээч, экспертүүдийг татан оролцуулж болно.

Удирдамж 4. Захиргааны удирдлагад түншлэлийг хөгжүүлэх

Нийгмийн даатгалын байгууллага нь хөтөлбөрийн ашиг хүртэгчдэд хүрэх, захиргааны зардлыг бууруулах, үйлчилгээний чанар, шударга байдлыг нэмэгдүүлэх зорилгоор бусад байгууллагуудтай түншлэлийг хөгжүүлэх шаардлагатай.

Бүтэц

- Нийгмийн даатгалын байгууллага нь бусад салбарын түншүүдтэй, тухайлбал, татвар, нутгийн захиргаа, ашгийн болон ашгийн бус байгууллагууд, мэргэжлийн холбоод зэрэг хамрагдахад хүндрэлтэй бүлгүүдтэй харилцдаг бусад байгууллагуудтай зардлын үр ашигтай түншлэлийг бий болгох ёстой.
- Мэдээллийн нууцлалыг хамгаалах нь нэн чухал тул мэдээллийг хамгаалах зохих механизмуудыг боловсруулах, хэрэгжүүлэх, хянах шаардлагатай.

Механизм

- Нийгмийн даатгалын байгууллага нь бусад байгууллага, засгийн газрын агентлагуудтай харилцаж байгаа зохицуулалтын механизмыг үнэлэх ёстой.
- Хүн амын бусад бүлэгт ижил төстэй үйлчилгээ үзүүлдэг нийгмийн даатгалын байгууллагууд нь хамгийн эхний түншүүд юм. Нийгмийн даатгалын удирдлагын зүгээс дахин давтагдахгүй бүртгэлийн дугаар (жишээлбэл, шимтгэлд суурилсан болон суурилагагүй хөтөлбөрийн нийгмийн даатгалын дугаар)-ыг бүртгэлдээ хамтдаа ашиглах, өөр өөр төрлийн нийгмийн даатгалын шимтгэл төвлөрүүлэлт хийх гэх мэт тодорхой үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хүчин чармайлтаа нэгтгэхийг хичээх ёстой.
- Нутгийн захиргаа нь олон нийтэд суурилсан түншлэл, нутгийн хүн амын хэрэгцээний талаарх мэдээллийг авч болох өөр нэг чухал түнш юм.
- Олон нийтийн байгууллагуудтай хамтран ажиллах нь хамрагдахад хүндрэлтэй бүлгүүдэд хүрч, шинэ хөтөлбөр(үүд)-ийн талаар мэдээллийг түгээхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Боломжит түншүүд гэдэгт нийгмийн судалгааны байгууллагууд, шашны бүлгүүд, үйлдвэрчний эвлэл, мэргэжлийн холбоод зэрэг хамрагдахад хүндрэлтэй бүлэгтэй шууд харьцаж, үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудыг багтааж болно.
- Олон нийтэд түшиглэсэн даатгалын хөтөлбөрүүд, хамтын сангийн тогтолцоо, бичил даатгал зэрэгтэй хамтран ажиллах нь стратегийн ач холбогдолтой байж болох юм. Учир нь, ийм тогтолцоо, хөтөлбөрүүд нь ихэвчлэн олон тооны хамрагдахад хүндрэлтэй бүлэгтэй ажилдаг, түүнчлэн хүн амын тодорхой бүлгүүдийн хэрэгцээ, нөхцөл байдалд илүү сайн зохицсон захиргааны уян хатан зохицуулалттай байдаг.
- Банк, шуудан, харилцаа холбоо, даатгал болон дэлгүүр, эмийн сан (сайн сүлжээ, уян хатан цагийн хуваарь) зэрэг ашгийн байгууллагууд нь захиргааны зарим үйл ажиллагааг хэрэгжүүлж, үр дүнтэй үйлчилгээ үзүүлэхэд тусалж чадна. Ийм зохицуулалтыг ашиглах нь бүх мөнгөн гүйлгээг зориулалтын дагуу хийж байгаа эсэхэд аудитын хяналттай байхын тулд үйл ажиллагааны загварыг нарийн гаргаж,

найдвартай дотоод хяналттай байхыг шаарддаг. Ялангуяа хувийн хэвшлийн түншүүд, төрийн бус байгууллагууд (ТББ)-тай хамтрах үед хувь хүний нууцыг хамгаалах нь нэн чухал юм.

- Бүртгэл, төвлөрүүлсэн шимтгэлийг шилжүүлэх, нийгмийн даатгалын сангийн хөрөнгө оруулалт, тэтгэмжийн төлбөр зэрэг үндсэн үйл ажиллагааны талаар мэдээллийг зөвхөн заасан зориулалтаар ашиглах, Нийгмийн даатгалын байгууллагад цаг тухайд нь найдвартай дамжуулахыг баталгаажуулахын тулд Үйлчилгээний түвшний гэрээ (ҮТГ) байгуулах шаардлагатай.
- Нийгмийн даатгалын байгууллага нь бусад нийгмийн хамгааллын байгууллагуудын чиг үүрэг, хариуцлагын үнэлгээг үе үе хийж, захиргааны аль чиг үүргийг үндэсний, бүс нутаг, орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх, алийг нь нийгмийн хамгааллын хүрээнд байлгах, алийг нь түншүүдтэй хуваалцах эсвэл аутсорсинг хийх талаар үндэслэлтэй шийдвэр гаргах ёстой.

Удирдамж 5. Төрөл бүрийн үйлчилгээ, түүнийг хүргэж байгаа барилга, байгууламжид тохирох стандартыг тогтоох

Нийгмийн даатгалын байгууллага нь хамрагдахад хүндрэлтэй бүлгүүдэд санал болгож буй үйлчилгээнд зориулсан хэмжихэд хялбар стандартыг тогтоох шаардлагатай.

Бүтэц

- Нийгмийн даатгалын удирдлага нь үйлчилгээ, түүнийг хүргэж байгаа барилга, байгууламжид стандарт тогтоох үйл ажиллагааг дэмжих ёстой бөгөөд энэ нь мэргэжлийн түвшинд шилжих, үйлчилгээг цахимжуулах, түншлэлийн стратеги зэргийн хамтаар хамрагдахад хэцүү бүлгүүдэд нийгмийн хамгааллыг хүргэх ажлыг ихээхэн хурдасгах болно.

Механизм

- Үйлчилгээний стандартад үйлчилгээний зарчим, тогтолцооны баталгаа, үйлчилгээг хэрхэн хүргэх, түүний хяналтад тавих шаардлага болон үнэлгээ, сайжруулалтад тавигдах үндсэн шаардлага зэрэг асуудлуудыг хамруулж болно. Ийм стандартуудыг Нийгмийн даатгалын удирдлагын зүгээс үе үе хянаж, шинэчилж байх шаардлагатай бөгөөд тэдгээр стандартууд нь гүйцэтгэсэн ажлын тоо хэмжээ, чанар, цаг хугацааны шаардлагын хувьд хэмжихэд хялбар үзүүлэлтүүдийг агуулсан байх ёстой.
- Барилга, байгууламжийн стандартууд нь засаг захиргааны янз бүрийн түвшний үйлчилгээ үзүүлэх төвүүдэд барилгын ерөнхий шаардлага, барилгын болон талбайн хэмжээ, дотоод функц, тоног төхөөрөмж зэрэгт тавигдах шаардлагыг тогтоодог.
- Удирдлага нь өөр өөр үйлчилгээ, байгууламжид тохирох стандартыг тогтоохдоо ОУНХХ-ны Үйлчилгээний чанарын тухай Удирдамж болон Сайн туршлагын мэдээллийн сангаас лавлаж болно.

Удирдамж 6. Мэдээлэл, харилцаа холбооны технологийн чадавхыг бүрдүүлэх

Нийгмийн даатгалын байгууллага нь дэд бүтэц, программ хангамж, мэргэжлийн боловсон хүчний багийг багтаасан мэдээлэл, харилцаа холбооны технологи (МХХТ)-ийн зохистой чадавхыг хөгжүүлэх шаардлагатай.

Бүтэц

- Бодит цагийн мэдээллийг цуглуулах, нэгтгэх, мэдээллийн найдвартай, үнэн зөв байдлыг хангахын зэрэгцээ захиргааны ачааллыг мэдэгдэхүйц бууруулж, улмаар хөтөлбөрт хамрагдсан иргэдэд бусад дэмжлэгийг үзүүлэх цагийг бий болгох чухал ач холбогдолтой МХХТ-ийн чадавхыг бүрдүүлэх талаар удирдлагын зүгээс ихээхэн анхаарах ёстой. МХХТ-ийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө нь технологийн өөрчлөлттэй хөл нийлүүлсэн, тандан судалгаанд үндэслэсэн, бүх зардлыг тооцсон, системийн харилцан уялдаатай ажиллагааг дэмжсэн байх ёстой. Үйлчилгээг цахимжуулах, хэрэглээнд нэвтрүүлэх нь ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт шаарддаг.
- Нийгмийн даатгалын удирдлага нь эрүүл мэндийн цахим үйлчилгээг ашиглахдаа болгоомжтой хандах ёстой бөгөөд дээд түвшний аюулгүй, найдвартай, хүлээн зөвшөөрөгдөх байдлыг хангасан нөхцөлд зөвхөн мэргэжлийн эмчийн үзлэг, хэрэглэгчдийн ашиглалт, оролцоог хангасан үйлчилгээг үзүүлэх ёстой. Удирдлагын зүгээс "цахим хуваагдал"-тай холбоотой цахим үйлчилгээнд нэвтрэхэд үүсдэг асуудлыг шийдвэрлэхийн тулд цогц арга хэмжээ авах ёстой.

Механизм

- Нийгмийн даатгалын байгууллагын удирдлага нь хамрагдахад хүндрэлтэй бүлгүүдэд нийгмийн хамгааллын зохих үйлчилгээг МХХТ-ийг ашиглан хүргэх боломж, чадавхыг тодорхойлж, шинэ технологи нэвтрүүлэх төлөвлөгөө гаргах ёстой. Үүнтэй холбоотой хамгийн чухал технологи бол гар утас, хувь хүний цахим мэдээлэл, нууцлал, аюулгүй байдал, харилцан уялдаатай ажиллах чадвар, мэдээллийн сангийн удирдлага юм.
- Удирдлага нь нийгмийн даатгалын байгууллагын мэдээллийн аюулгүй байдлын бэлэн байдлыг хангаж, технологийн шинэчлэл, мэдээллийн системийн мэдрэмж, бодит болон болзошгүй дотоод, гадаад аюулын талаар мэдлэг, ойлголтыг шинэчлэхийн тулд аюулгүй байдал журмыг тогтмол сайжруулж байх ёстой.
- Нийгмийн даатгалын байгууллага нь харилцаа холбоо, банкны тогтолцооны ашиглалтыг сайжруулахаас гадна үр шим хүртэгчдийг хаана ч, хэзээ ч, зохих арга хэрэгслээр шимтгэл төлөх, тэтгэмж авах боломжоор хангахын тулд иргэдтэй харилцах газар, хэлтсийн сүлжээтэй байх ёстой.
- Удирдлага нь иргэд мэдээлэл авах, бүртгүүлэх, шимтгэл төлөх, тэтгэмж авах, гомдол гаргах зэрэг захиргааны ихэнх чиг үүргийг биелүүлэх боломжийг газар, хэлтсүүдэд олгох ёстой. Үүнийг эрх мэдэл хуваарилах зарчмаар зохицуулж, системтэй хэрэгжүүлэхийн тулд МХХТ-ийг ашиглах, нэг цэгийн үйлчилгээ буюу нэг цонхны үйлчилгээ рүү шилжих нь зүйтэй.

- МХХТ-ийн чадавх багатай боловч хамрах хүрээг хурдан өргөтгөх шаардлагатай байгаа байгууллагуудын хувьд дунд болон урт хугацааны МХХТ-ийн чадавхыг бэхжүүлэх төлөвлөгөөг боловсруулж, ийм чадвартай салбар агентлагуудтай түншлэл тогтооход ихээхэн анхаарах ёстой.
- Дижитал эрүүл мэндийн хэрэгслүүдийг (телемедицин, e-health г.м) нийгмийн болон бүс нутгийн ялгааг бууруулах, оролцоог дэмжих зорилгоор үе шаттайгаар, хамтын ажиллагааны үндсэн дээр хөгжүүлэх ёстой.
- Удирдлага нь ОУНХХ-ны Мэдээлэл, харилцаа холбооны технологийн удирдамж ба ОУНХХ-ны МХХТ-ийн зохистой чадавхыг хөгжүүлэх мэдээллийн сангийн тухай Сайн туршлагыг судалж болно.

Удирдамж 7. Хариуцлагатай захиргааны бүтцийг бий болгох

Нийгмийн даатгалын байгууллага нь хамрагдахад хүндрэлтэй бүлгүүдийн хэрэгцээ, нөхцөл байдалд тохирсон, үр ашигтай зохион байгуулалтын бүтцийг бий болгох шаардлагатай.

Бүтэц

- Шаардлагатай тохиолдолд удирдлага нь хамрах хүрээг өргөтгөхөд тулгарч буй бэрхшээлийг шийдвэрлэхэд хэрэгтэй захиргааны гол үйл явцуудад (бүртгэл, шимтгэл төвлөрүүлэлт, тэтгэмж олгох г.м) чиглэгдсэн мэргэшсэн нэгжүүдийг зохион байгуулалтын бүтцэд нэгтгэх ёстой.
- Удирдлага нь хамрагдах ёстой хүн амтай нийгмийн яриа хэлэлцээрийг тогтмол явуулж, тэдний хэрэгцээг тодорхойлохын тулд орон нутгийн талууд, олон нийтийн байгууллагуудад тулгуурлан ажиллах ёстой.

Механизм

- Удирдлага нь хамрагдахад хүндрэлтэй бүлгүүдэд зориулсан хөтөлбөрийг удирдахад захиргааны журам болон мэдээллийн урсгалыг багтаасан үр дүнтэй бизнесийн загварыг боловсруулах ёстой.
- Удирдлага нь нийгмийн даатгалын байгууллагыг үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудтай хийх Үйлчилгээний түвшний гэрээ (ҮТГ)-г хэрэгжүүлэх, хянах чадавхтай эсэхийг үнэлэх ёстой.
- Мэдээллийн солилцоо нэмэгдсэнээр мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдлыг хамгаалах шинэчилсэн засаглал, хяналтын механизмыг шаардаж магадгүй юм.
- Удирдлага нь эрүүл мэндийн тогтолцоонд одоогоор хамрагдаагүй бүлгүүдэд хөтөлбөрт хамрагдахын ашиг тусын талаарх ойлголтыг нэмэгдүүлэх эрүүл мэндийн тохирсон багцыг боловсруулахад дэмжлэг үзүүлж, эдгээр бүлгийн онцлог, хэрэгцээ (хөдөөгийн ажиллагч, гэрийн ажиллагч, хувиараа хөдөлмөр эрхлэгчид)-г харгалзан үзсэн удирдлагын журмыг батлах ёстой. Үүний нэгэн адил удирдлага нь албан бус салбарын ажиллагчдыг албан салбарт шилжихэд дэмжлэг үзүүлэх ёстой.

A.3 Хамрагдахад хүндрэлтэй бүлгүүдэд хүрч ажиллах, мэдээлэх, мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх

Олон нийттэй харилцах харилцаа нь зорилтот бүлэгт үр дүнтэй хүрэх, хэрэгжиж буй хөтөлбөрүүдийн талаар мэдээллийг түгээх, нийгмийн хамгааллын үр өгөөжийг тэдэнд, тэдний гэр бүл болон нийгэмд ойлгуулах гол түлхүүр юм.

Удирдамж 8. Албан бус эдийн засагт ажиллагчдыг оролцуулан хамрагдахад хүндрэлтэй хүн амын бүлгүүдтэй харилцах, итгэлцлийг бий болгох харилцааны стратегийг боловсруулах

Нийгмийн даатгалын байгууллага нь бүлгүүдийн хэрэгцээ, онцлог, орон нутгийн нөхцөл байдлыг харгалзан тэдэнд хүрч ажиллах стратеги боловсруулах шаардлагатай.

Бүтэц

- Нийгмийн даатгалын байгууллага нь зорилтот бүлгийн хүн амын онцлог шинж, тэдэнд хүрэхэд тулгарч буй бэрхшээл, боломжуудын талаар нарийн дүн шинжилгээ хийж, хамрах хүрээг өргөтгөх, албан салбарт шилжүүлэх чиглэлээр олон нийттэй харилцах харилцааны стратегийг боловсруулж хэрэгжүүлэх ёстой.

Механизм

- Удирдлага нь мэдээллийн дүн шинжилгээ, фокус групп, олон нийтийн санаа бодлыг судлах зэргээр хүн амыг сайтар ойлгож, түүнтэй харилцах хамгийн сайн арга замыг тодорхойлох ёстой. Ингэхдээ хамрагдахад хүндрэлтэй бүлгүүдийн талаар найдвартай мэдээллийн эх сурвалжийг тодорхойлох (санал асуулга, ярилцлага, түүвэр судалгаа г.м), тэдний тодорхой нөхцөл байдал, хэрэгцээг бодитойгоор үнэлж, тэдэнтэй хэрхэн харилцах боломжтой арга барилыг тогтооно.
- Удирдлага нь нийгмийн хамгааллын хөтөлбөр бүрийн онцлог, иргэдэд ашигтай байдлыг харуулсан мэдлэг, ойлголт түгээх материалыг энгийн бөгөөд товч байдлаар боловсруулах ёстой.
- Мэдлэг, ойлголт түгээх материалын агуулга нь хэлний болон соёлын ялгааг харгалзан үзэж, хамрагдахад хүндрэлтэй бүлгүүдэд хөтөлбөрт хамрагдах бодит ашиг тус, бүртгүүлэхэд хялбар байдал, тусгай урамшуулал, хамрагдах шалгуур, санал гомдол гаргах гэх мэт асуудлуудыг зөв тусгасан байх ёстой.
- Удирдлага нь төрийн бусад байгууллагууд, түншлэгч байгууллагуудтай хамтран ажиллаж, нийгмийн маркетингийн кампанит ажил явуулах замаар хамрагдахад хүндрэлтэй бүлгүүд, эдгээр бүлгүүдийн ажил олгогчдын мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх хэрэгтэй.
- Удирдлага нь кампанит ажил бүрийн хүлээгдэж буй үр дүн, агуулга, хэвлэл мэдээллийн хэлбэр, олон нийттэй харилцах арга барилыг тодорхойлох ёстой. Сурталчилгааны тусгай кампанит ажлын үр дүн нь тодорхой хугацаанд зорилтот бүлгийн иргэдийн хөтөлбөрт хамрагдах бүртгэл нэмэгдэх гэх мэт үйл ажиллагааны үр нөлөөгөөр хэмжигдэхүйц байх ёстой.
- Удирдлага нь мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ ОУНХХ-ны “Шимтгэл төвлөрүүлэх, түүнийг хэрэгжүүлэх журмын тухай удирдамжийн F хэсэг, Мэдлэг ойлголт, дагаж мөрдөх соёлыг төлөвшүүлэх”, мөн “Нийгмийн хамгааллын байгууллагуудын олон нийттэй харилцах харилцааны тухай Удирдамж” -ийг мөрдлөг болгож болно.
- Нийгмийн даатгалын байгууллага нь үндэсний хэмжээний томоохон кампанит ажил эсвэл нийтлэг нийгмийн даатгалын бүртгэлийг эхлүүлж болно.
- Нийгмийн даатгалын байгууллага нь нийгмийн хамгааллыг сурталчлах чиглэлээр бусад төрийн байгууллагуудтай хамтран ажиллаж болно.

A.4 Бүртгэлийн үр дүнтэй тогтолцоог хөгжүүлэх

Хамрагдахад хүндрэлтэй бүлгүүдэд хүрч ажиллах гэдэг нь засгийн газрын үйл ажиллагааны талаар мэдлэг, ойлголтгүй хүн амыг тодорхойлж, бүртгэх явдал юм.

Удирдамж 9. Зорилтот бүлгийг тогтоох тогтолцоог бий болгох

Нийгмийн даатгалын байгууллага нь дотоод хүчин чармайлтаар эсвэл бусад байгууллагатай хамтран зорилтот хүн амыг тодорхойлох стратеги боловсруулах шаардлагатай.

Бүтэц

- Удирдлага нь одоо байгаа иргэний бүртгэл, мэдээллийн нэгдсэн тогтолцоо (ИБМНТ)-г судалж, хамрагдахад хүндрэлтэй бүлгүүдийг хамруулахад энэ тогтолцоог бүрэн ашиглах ёстой.
- Хэрэв ийм тогтолцоо байхгүй бол нийгмийн хамгааллын бусад байгууллагуудтай хамтран зорилтот бүлгийг тогтоох тогтолцоог бий болгох талаар Удирдах зөвлөлөөс Нийгмийн даатгалын Удирдлагад даалгах ёстой.
- Нөхцөл байдлаас шалтгаалан Удирдах зөвлөл нь Засгийн газраас үндэсний ИБМНТ-г хэрэгжүүлэхийг уриалж болно.
- Удирдлага нь нийгмийн хамгааллын бусад байгууллагууд болон холбогдох эрх бүхий байгууллагуудтай хамтран улсын хэмжээнд нийгмийн хамгааллын дугаар (нийгмийн даатгалын нэгдсэн ухаалаг карт гэх мэт)-ыг олон удаа бүртгэхээс зайлсхийх, мэдээллийн бүрэн байдлыг хангах зорилгоор ашиглах ёстой.

Механизм

- Олон талт хэрэглээтэй, мэдээллийг хурдан шуурхай авч болох Иргэний бүртгэл, мэдээллийн нэгдсэн тогтолцоо (ИБМНТ) хараахан бүрдээгүй, ялангуяа бүртгэлгүй төрөлт, бичиг баримтгүй ажиллагчид ихтэй улс орнуудад Удирдах зөвлөл нь нийгмийн хамгааллын хамрах хүрээг хамрагдахад хүндрэлтэй бүлгүүдэд өргөтгөх баттай суурийг тавьж чадах ИБМНТ-г хэрэгжүүлэх саналыг Засгийн газарт дэвшүүлж болно.
- ИБМНТ хараахан бүрдээгүй улс орнуудад нийгмийн хамгааллын байгууллагууд болон бусад холбогдох эрх бүхий байгууллага (зорилтот бүлэг тодорхойлох, иргэний бүртгэл, татвар, аж ахуйн нэгжийн бүртгэл, аюулгүй байдал г.м)-уудын хооронд үр ашигтай зохицуулалт, хамтын ажиллагааг идэвхжүүлэхийн тулд үндэсний платформ (жишээ нь, бүх нийгмийн хамгааллын байгууллагууд хамтран боловсруулсан нийгмийн даатгалын карт г.м) бий болгох ёстой. Ийм хүчин чармайлт нь хөтөлбөрт бүртгүүлэгчдийн мэдээллийг хооронд нь холбох боломжийг олгож, цуглуулсан мэдээлэл үнэн зөв байх болно. Гэхдээ бусад байгууллагуудтай мэдээлэл хуваалцахдаа зөвшөөрөгдсөн параметрийн хүрээнд хийхийг анхаарах хэрэгтэй.
- ИБМНТ хэрэгжиж байгаа боловч нийгмийн хамгааллын хөтөлбөрүүдийн хэрэгцээг хангахгүй байгаа (мэдээллийн хамгаалалт, хамрах хүрээ, хүртээмжийн хувьд) улс орнуудад байж болох өөр шийдэл нь нийгмийн хамгаалал, татварын байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд нийт хүн амыг хамарсан нийгмийн хамгааллын болон татварын нэгдсэн систем бий болгох явдал юм. Ийм картыг иргэний үнэмлэх болгон ашиглахаас гадна нийгмийн хамгаалал, гамшгаас аврах зэрэг олон төрлийн үйлчилгээ авах, улмаар захиргааны үйл явцыг хялбарчлах, шударга байдлыг сайжруулахад ашиглаж болно.

Удирдамж 10. Бүртгэлд тавигдах мэдээллийн шаардлагыг хялбарчлах

Нийгмийн даатгалын байгууллага нь мэдээллийн шаардлагыг хялбарчилж, зорилтот бүлгүүдийн бүртгэлийг хөнгөвчлөх шаардлагатай.

Бүтэц

- Удирдлага нь Иргэний бүртгэл, мэдээллийн нэгдсэн тогтолцоо (ИБМНТ) зэрэг мэдээллийн нөөцийг ашиглан бүртгэлд тавигдах мэдээллийн шаардлагыг хялбарчлах, багасгах болон бичиг баримтыг дахин дахин бүрдүүлэх шаардлагагүй болгох боломжтой.

Механизм

- Удирдлага нь шаардлагатай бичиг баримтын тоог аль болох багасгах, энгийн хэллэг ашиглах, маягтыг аль болох урьдчилан бөглөх замаар захиргааны үйл явц, маягтуудыг хялбарчлах ёстой. Захиргааны бүх шаардлага, бүртгэлийн маягтыг вэб сайтаас авах боломжтой байх ёстой.
- Удирдлага нь хамрагдахад хүндрэлтэй бүлгийн талаар мэдээлэл цуглуулж байгаа бүх байгууллагуудыг тодорхойлж, эдгээр бүлгийн талаар мэдээлэл цуглуулах нийтлэг мета өгөгдөл, хэв маягийг тодорхойлж, олон зорилгоор хамтран мэдээлэл цуглуулах ажлыг дэмжих ёстой.
- Удирдлага нь татвар, статистикийн байгууллагатай хамтран аж ахуйн нэгж, айл өрх, хувь хүмүүсээс мэдээлэл цуглуулах нэгдсэн стандартыг боловсруулахад хамтран ажиллах ёстой.
- Удирдах зөвлөл болон удирдлага нь НД байгууллагыг өөрийн болон бусад холбогдох байгууллагуудын мэдээллийн сангийн уялдаа холбоог бий болгож, мэдээллийг харилцан шалгаж, давхардлыг бууруулах чиглэлээр ажиллуулах ёстой.
- Удирдлага нь улсын хэмжээнд цахим үнэмлэх, цахим гарын үсэг, салбарын бүртгэл, өөр өөр төрлийн төхөөрөмжүүдийг нэгтгэх стандартыг агуулсан нэгдсэн мэдээллийн технологийн платформыг бий болгож, хэзээ ч, хаанаас ч үйлчилгээг авах боломжтой хувь хүнийг таних биометрийн технологид хөрөнгө оруулах ёстой.

Удирдамж 11. Бүртгэлийн үйл явцыг хөнгөвчлөх

Нийгмийн даатгалын байгууллага хамрагдахад хүндрэлтэй бүлгүүдийг бүртгэх ажлыг хөнгөвчлөх зохих арга хэмжээг авах шаардлагатай.

Бүтэц

- Нийгмийн даатгалын байгууллага нь салбарын болон бусад эрх бүхий байгууллага, түншлэгч талууд (Удирдамж 4, Захиргааны удирдлагад түншлэлийг хөгжүүлэх)-тай хамрагдахад хүндрэлтэй бүлгүүдийн бүртгэлийг хийхэд хамтран ажиллах шаардлагатай.
- Нийгмийн даатгалын байгууллага нь бүртгэлийн түвшнийг нэмэгдүүлэхийн тулд урамшуулал ашиглаж болно.

Механизм

- Ажил олгогч, ажилтан албан ёсны харилцаатай бол ажил олгогчид нь шаардлага хангасан ажилтнуудыг онлайнаар илгээх боломжтой нэгдсэн бүртгэл, мэдүүлгийн маягтаар дамжуулан шинэ хөтөлбөрт автоматаар бүртгүүлэх үүрэгтэй байх ёстой.
- Ажил олгогч, ажилтны албан ёсны харилцаа байхгүй тохиолдолд тухайн нутгийн захиргааны байгууллага, үйлдвэрчний эвлэл, хамрагдахад хүндрэлтэй бүлгүүдийн холбоо, мэргэжлийн холбоод, шашны байгууллага, шуудан, банк, нийгмийн маркетингийн агентлаг эсвэл бусад түнш байгууллагатай хамтран хувь хүн, өрх, засаг захиргааны нэгжид суурилсан хялбаршуулсан бүртгэлийн үйл ажиллагааг явуулах ёстой. Ийм тохиолдолд бүртгэлийн явцын харилцан уялдаатай байдлыг хангахын тулд сайн боловсруулсан үйл ажиллагааны журамтай байх ёстой.
- Боломжтой бол Нийгмийн даатгалын байгууллагын зүгээс иргэдийг автоматаар бүртгэх системийг хэрэгжүүлэх талаар бодох хэрэгтэй. Энэ тохиолдолд тухайн хүн анхдагчаар хөтөлбөрт хамрагдсан байна.
- Боломжтой бол удирдлага нь тодорхой мэргэжил, бүс нутгийн ажиллагчдыг үйлдвэрчний эвлэл, мэргэжлийн холбоод, эсвэл ийм ажлыг гүйцэтгэхэд тохиромжтой гэж үзсэн бусад байгууллагаар дамжуулан хамтын бүртгэлд хамруулах талаар бодолцох ёстой.
- Хөдөө, алслагдсан, хүн ам сийрэг суурьшсан газруудад нийгмийн хамгааллын бүртгэл, шимтгэл төвлөрүүлэхэд туслах зорилгоор явуулын оффисын сүлжээг нэвтрүүлэх эсвэл төрийн байгууллагын өөр сүлжээг ашиглах талаар бодох хэрэгтэй.
- Барилга, уул уурхай зэрэг олон тооны гадаад, дотоодын цагаач ажиллагчдыг ашигладаг зарим үйлдвэрлэлийн хувьд Нийгмийн даатгалын байгууллага нь бизнесийн болон үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг ажил олгогчдод төслийн өртөг эсвэл ашгийн зохих хувийг нийгмийн даатгалд төвлөрүүлэх, ялангуяа ажил олгогчоос санхүүжүүлдэг үйлдвэрлэлийн ослын даатгалд олгох үүрэгтэй холбохын тулд засгийн газрын дэмжлэг авах асуудлыг авч үзэх хэрэгтэй.

Удирдамж 12. Мэдээллийн сангийн чанарыг сайжруулах механизм

Нийгмийн даатгалын байгууллага нь иж бүрэн захиргааны үйл явцыг хангахын тулд мэдээллийн сангийн чанарыг сайжруулах механизмыг бий болгох шаардлагатай.

Бүтэц

- Нийгмийн даатгалын байгууллага нь МХХТ-д суурилсан мэдээллийн сангийн чанарыг сайжруулах төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх ёстой.
- Нийгмийн даатгалын удирдлага нь хөтөлбөрт хамрагдаж байгаа иргэн бүрд дахин давтагдахгүй дугаарыг үүсгэх, тэдний нийт төлсөн шимтгэл, авсан тэтгэмжийг бүртгэх зорилгоор шаардлагатай бүх мэдээллийг мэдээллийн санд хадгалж, шинэчилж байх ёстой.

Механизм

- Дахин давтагдахгүй дугаар гэдэгт Нийгмийн даатгалын байгууллага болон холбогдох талууд боломжтой гэж үзвэл үндэсний нийгмийн хамгааллын дугаар, татвар, нийгмийн хамгааллын нэгдсэн дансны дугаар эсвэл иргэний үнэмлэхийн дугаар байж болно.
- Бүртгэлийн мэдээлэл оруулах системийг бий болгохдоо үнэн зөв, цаг үеэ олсон, харьцуулах боломжтой, тогтвортой, хэрэглээнд ээлтэй, хүртээмжтэй байдал, зардлын үр ашиг зэрэг олон хүчин зүйлийг харгалзан үзэх шаардлагатай.
- Удирдлага нь шаардлагатай мэдээллүүд, мэдээллийн систем болон программ хангамжийн нэгдмэл загвар, одоогийн мэдээллийн сантай харьцуулан шалгах зэрэг бүртгэлийн мэдээллийг цуглуулах, шинэчлэх бүх үйл явцыг хамарсан чанарын сайжруулалтыг хэрэгжүүлж, мэдээлэл цуглуулах, мэдээллийн чанарын хяналтыг гүйцэтгэх ажилтнуудыг мэргэжлийн түвшинд сургах ёстой.
- Мэдээллийн сангийн түүхэн өгөгдлүүдийг харьцуулах, ижил хувьсагчтай бусад өгөгдөлтэй харьцуулах (lateral comparison of data, t-test, Mann-Whitney U test), өгөгдлийн стандарт хазайлт, хамаарлын буюу хэрэглэгчийн хэрэгцээг хэр хангаж байгаа талаар шинжилгээ (relevance analysis) гэх мэтээр өгөгдлийн чанарыг үнэн зөв үнэлэхийн тулд өгөгдлийн чанарын үнэлгээний тогтолцоог бий болгох хэрэгтэй.
- Бүх хууль эрх зүй, зохицуулалтын шаардлага, хатуу дотоод хяналтыг хангасан тохиолдолд бүртгэлийн мэдээлэл цуглуулж байгаа бусад эрх бүхий байгууллагуудтай хамтран өөр өөр мэдээллийн санг харьцуулах замаар мэдээллийг шалгаж болно. Энэ механизмыг нийгмийн хамгааллын хөтөлбөрүүдэд давхардал үүсэхээс сэргийлэх, шударга байдлыг бэхжүүлэхэд ашигладаг.

А.5 Шимтгэл төвлөрүүлэх, түүний журмыг сайжруулах шийдлүүдийг зөв тодорхойлох

Шимтгэл төлөхтэй холбоотой журам нь сайн дурын болон төрөөс татаастай нийтлэг хөтөлбөр гэх мэт бүх төрлийн шимтгэлийн тогтолцооны хувьд чухал ач холбогдолтой бөгөөд энэ нь хамрагдах шалгуурууд, тэтгэмжийн хуримтлалын санхүүжилтийг зохицуулдаг.

Удирдамж 13. Шимтгэл тооцох суурийг сонгох

Нийгмийн даатгалын байгууллага нь шимтгэл тооцох суурь, түүний хувь хэмжээг ил тод, хамрагдахад хүндрэлтэй иргэдийн хэрэгцээнд нийцүүлэн тогтоох шаардлагатай.

Бүтэц

- Удирдлага нь шимтгэлийг тооцох суурийг сонгож, төлөх шимтгэлийн хувь хэмжээг тогтоох ёстой.

Механизм

- Даатгалд хамрагдахад хүндрэлтэй иргэдийн орлого нь бага, хэлбэлзэлтэй, урьдчилан таамаглах боломжгүй байдаг тул Удирдлага нь шимтгэл тооцох суурийг янз бүрийн үндэслэлээс тогтоох ёстой. Үүнд:
 - Нийгмийн даатгалын шимтгэл тооцох орлогын дундаж хэмжээ;
 - Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ;
 - Нийгмийн бүлгүүдийн дундаж орлого;
 - Хөтөлбөрийн өөрийн өртөг, эсвэл түүний гарцын үнэ цэнэ.
- Сайн дураар шимтгэл төлөх тэтгэврийн даатгалын хөтөлбөрийн хувьд орлогын чадавхыг харгалзсан сонголттой нэмэлт шимтгэлийн шатлалыг авч үзэж болно. Ийм тохиолдолд шимтгэл төлөгчид ямар шимтгэл төлснөөр ямар тэтгэвэр авч болохоо мэддэг байхын тулд зохих арга хэмжээ авах хэрэгтэй.
- Шимтгэл төвлөрүүлэх, түүнийг хэрэгжүүлэх журмыг сайжруулах стратегийг тодорхойлохдоо удирдлага нь энэхүү стратегийн гол бүрэлдэхүүн хэсгүүдийг багтаасан ОУНХХ-ны Шимтгэл төвлөрүүлэх, түүнийг хэрэгжүүлэх журмын тухай удирдамжийг ашиглахыг зөвлөж байна.

Удирдамж 14. Шимтгэл төлөх тохиромжтой арга, давтамжийг хэрэгжүүлэх

Нийгмийн даатгалын байгууллага нь цахим төлбөр тооцоонд суурилсан зорилтот бүлгийн хэрэгцээ, чадавхыг харгалзан шимтгэл төлөх хамгийн тохиромжтой арга, давтамжийг ашиглах шаардлагатай.

Бүтэц

- Удирдлага нь шимтгэл төлөлтийг хэрэгжүүлэх, үр дүнтэй түншлэлийн хөтөлбөрөөр дамжуулан цахим үйлчилгээний үр ашгийг нэмэгдүүлэх төлөвлөгөө боловсруулах шаардлагатай (Удирдамж 6, МХХТ-ийн хангалттай чадавхыг бий болгох; Удирдамж 19, Цахим төлбөр, үйлчилгээг оновчтой ашиглах).
- Удирдлага шимтгэл төвлөрүүлэх үр ашгийг нэмэгдүүлэхийн тулд шимтгэл төлөх уян хатан давтамж, янз бүрийн аргыг нэвтрүүлж болно.

Механизм

- Нийгмийн даатгалын хөтөлбөрийн төрөл, хүн амын тодорхой бүлэг, эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан шимтгэлийг сар, улирал, хагас жил, жилээр (жишээлбэл, өмнөх жилийн дундаж орлогын тодорхой хувийг үндэслэн) төлж болно.
- Ажил олгогчоор дамжуулан даатгалд хамрагдсан ажиллагчдын шимтгэлийг ажил олгогч нь цалингийн сангаас суутгаж, ажил олгогчийн шимтгэлийн хамт даатгалын шимтгэл төвлөрүүлэх эрх бүхий байгууллагад шууд төлөх үүрэгтэй.
- Нийгмийн даатгалын байгууллагад шууд даатгагдсан хүмүүсийн хувьд тэдний хэрэгцээнд тохирсон, үр ашигтай дэмжлэг үзүүлэх, Нийгмийн даатгалын байгууллагатай харилцахад нь уян хатан байдал, сонголт хийх боломжийг олгох шийдлүүдийг гаргах ёстой. Жишээлбэл, тэд нийгмийн хамгааллын байгууллагын хамгийн ойрын салбар, хамтран ажиллагч байгууллага (олон нийтэд суурилсан хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний байгууллагууд г.м)-ууд, автомат банкны шилжүүлэг, банкны өөртөө үйлчлэх төлбөрийн машинууд, онлайн эсвэл гар утсаар дамжуулан шимтгэлээ төлөх сонголттой байж болно.
- МХХТ-ийн тусламжтайгаар удирдах зөвлөл болон удирдлага нь шимтгэл төлөгчдийн нэгдсэн бүртгэлийн системийг бий болгох талаар анхаарах хэрэгтэй. Энэ нь шимтгэл төлөхөөс зайлсхийх, давхар бүртгүүлэх зэрэг зөрчлийг илрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Нийгмийн даатгалын шимтгэлийн цахим төлбөрийн систем нь ажил олгогч болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн аль алины шимтгэл төлөх боломжийг хөнгөвчлөх боломжтой байдаг.
- Захиргааны болон техникийн чадавх сул байгаа асуудлыг шийдвэрлэхийн тулд удирдлагаас дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж болно:
 - Шимтгэлийн хэмжээг урьдчилан тооцоолох, шимтгэл төлөгчдөд тавих захиргааны шаардлагыг хялбарчлах;

- Нийгмийн хамгаалал болон татварын байгууллагын хооронд байгуулсан хэлэлцээрийн дагуу нэгдсэн системд шилжсэн орнуудын хувьд орлогын татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг нэг төлбөр тооцоонд нэгтгэх; Өөр өөр орлоготой зорилтот бүлгүүдэд зориулсан шимтгэлийн янз бүрийн хэмжээг тогтоох;
- Дундаж төсөөллийн орлогыг ашиглах.
- Шимтгэл төвлөрүүлэх цахим төлбөрийн систем нь дараах загварт суурилсан байж болно:
 - Гар утасны технологид суурилсан цахим болон хөдөлгөөнт мөнгө;
 - Ухаалаг карт дээр суурилсан дебит/урьдчилсан төлбөрт зээлийн картын данс;
 - Банкны системтэй харилцаж шимтгэл төвлөрүүлэхэд интернэт, гар утасны технологийг ашигладаг цахим банк, үйлчлүүлэгчийг таних систем.

Удирдамж 15. Шимтгэл төвлөрүүлэх, дагаж мөрдөх журмыг хэрэгжүүлэх зорилгоор бусад байгууллагатай хамтран ажиллах

Нийгмийн даатгалын байгууллага нь үйл ажиллагааны үйл явцыг сайжруулах чиглэлээр бусад байгууллагуудтай хамтран ажиллаж, шимтгэл төвлөрүүлэх, хамрагдахад хүндрэлтэй бүлгүүдэд журмыг мөрдүүлэх зорилгоор хамтран ажиллах шаардлагатай.

Бүтэц

- Удирдах зөвлөл болон Удирдлага нь шимтгэл төвлөрүүлэх, журмын үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой мэдээлэл солилцох гэрээ байгуулах эрх Нийгмийн даатгалын байгууллагад байгаа эсэхийг тодорхой болгох ёстой.
- Удирдлага нь шимтгэл төвлөрүүлэх, дагаж мөрдөх журмын хэрэгжилтийг хангахын тулд орон нутгийн засаг захиргаа, хөдөлмөрийн хяналтын байгууллагатай хамтран ажиллахад анхаарах ёстой.
- Удирдах зөвлөл болон Удирдлага нь бусад байгууллагатай хамтран ажиллах, мэдээлэл солилцох үйл ажиллагааны цар хүрээ, хэрэгжүүлэх механизмыг тодорхойлохдоо мэдээллийн нууцлалын зохицуулалтыг харгалзан үзэх ёстой.
- Удирдлага нь холбогдох байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан Үйлчилгээний гэрээ (ҮГ)-г тодорхойлж, гарын үсэг зурж, хяналт тавих ёстой.
- Дээрх арга хэмжээ нь ОУНХХ-ны Шимтгэл төвлөрүүлэх, дагаж мөрдөх журмын тухай Удирдамжид зөвлөсний дагуу нийт шимтгэл төвлөрүүлэх, журмыг хэрэгжүүлэхэд чиглэсэн системтэй хамтын ажиллагаа, мэдээлэл солилцооны нэг хэсэг байх ёстой.

Механизм

- Журмыг хэрэгжүүлэх, шимтгэл төвлөрүүлэх чиглэлээр бусад байгууллагуудтай хэрэгжүүлэх хамтын ажиллагаанд дараах зүйлс багтана:
 - Шимтгэл төлөгчдийн талаар холбогдох болон бусад мэдээлэлтэй харьцуулан шалгасан мэдээллийг олж авахын тулд мэдээлэл солилцох;
 - Арилжаа, санхүүгийн (банк) болон харилцаа холбооны түншүүдээр дамжуулан шимтгэлийн төлбөрийг хүлээн авах.
- Удирдлага нь Шимтгэл төвлөрүүлэх, журмыг хэрэгжүүлэх захиргааны удирдлагад түншлэлийг ашиглах тухай Удирдамж 4-г ашиглах боломжтой.
- Удирдлага нь бусад байгууллагуудтай хамтран ажиллахдаа сайн менежментийн туршлагатай, аудитын хяналт нь бат бөх, сайн хөгжсөн байх үед л шимтгэл төвлөрүүлэх тухай хэлэлцээр хийх талаар бодож үзэх ёстой.
- Нутгийн захиргааны байгууллагыг орон нутгийн түвшинд шимтгэл төвлөрүүлэх, тэтгэвэр, тэтгэмж олгох үйлчилгээг үзүүлэхэд татан оролцуулж болно.

Удирдамж 16. Сайн дураар даатгуулах, албан салбарт шилжихийг дэмжих

Нийгмийн даатгалын байгууллага нь хөндлөнгийн оролцоо багатайгаар хамрагдалтыг дэмжих бодлогын арга хэмжээнд захиргааны шийдлүүдийг багтаадаг.

Бүтэц

- Удирдлага нь хамрагдахад хүндрэлтэй бүлгүүдийг сайн дураар даатгуулахыг дэмжих практик бөгөөд шинэлэг арга хэмжээ авахыг эрмэлзэх ёстой.
- Эдгээр бодлого, стратеги нь сайн дурын даатгалыг хэрэгжүүлэхэд гарах эрсдэлийн менежмент болон нийгмийн даатгалын шимтгэлийн хамрах хүрээг өргөжүүлэх, албан салбарт шилжихэд дэмжлэг үзүүлэх талаар нийгмийн даатгалын байгууллагын стратегитай уялдах ёстой.

Механизм

- Удирдлага нь даатгуулсан даатгуулагчдад өөрийн төлсөн шимтгэлийг хүссэн үедээ онлайнаар үзэх боломжийг олгох ёстой.
- Санхүүгийн олон зориулалттай нийгмийн даатгалын нэгдсэн карт нь сайн дурын даатгалыг нэмэгдүүлэх үр дүнтэй хэрэгсэл байж болох юм.
- Удирдлага нь үндсэн бус үйл ажиллагаа (цэвэрлэгээ, хамгаалалтын үйлчилгээ г.м)-г гэрээлэгч байгууллагаар гүйцэтгүүлэхдээ гэрээт ажиллагчдын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийг хамгаалж, хууль тогтоомжийн дагуу нийгмийн баталгааг хангах асуудлыг гэрээний зайлшгүй хэсэг болгон тусгаж, хамрагдахад хүндрэлтэй бүлгүүдийн нийгмийн хамгааллыг нэмэгдүүлэх сайн үлгэр жишээг үзүүлэх ёстой.
- Удирдлага нь шимтгэл төлөх журмыг дагаж мөрдөөгүй тохиолдолд хэрхэх талаар журамд ил тод тусгах ёстой. Шимтгэл төлөөгүйгээс болж түр зуур эрхээ алдах үед энэ нь онцгой чухал юм. Нийгмийн даатгалын байгууллага нь аж ахуйн нэгжид тусгай зөвшөөрөл олгох, сунгах асуудлыг нийгмийн даатгалын бүртгэл, шимтгэл төлөлттэй уялдуулах зэрэг бодлогын тусгай заалтуудыг хэрэгжүүлэх саналыг эрх бүхий байгууллагад тавьж болно. Энэ механизм нь ажиллагчдыг албан салбарт шилжихэд хувь нэмэр болдог байна. Бодлогын бусад дараах хөшүүрэг нь хамрагдалтыг дэмжиж, шимтгэлээ тасралтгүй төлөх хөшүүрэг болж өгдөг нь тогтоогдсон байна. Жишээлбэл:
 - Зарим бага орлоготой нийгмийн бүлгийн тэтгэвэр, тэтгэмжийн шимтгэлийн бус элементийг нэмэх;
 - Бусад эрсдэлийг даатгах үнэ төлбөргүй нэмэлт даатгал;
 - Нэрийн дансанд хуримтлагдсан хадгаламжийн инфляцын нөлөөгөөр буурахгүй хүүгийн баталгаатай хувь хэмжээ.

Удирдамж 17. Захиргааны алдаа, шимтгэл төлөлтөөс зайлсхийх, залилан мэхлэлтийг шийдвэрлэх идэвхтэй стратеги батлах

Нийгмийн даатгалын байгууллага нь захиргааны үйл явц, боловсон хүчин (дотоод болон гадаад), мэдээлэл, технологид анхаарсан ерөнхий стратегийн нэг хэсэг болгон хамрагдахад хүндрэлтэй бүлгүүдэд зориулж захиргааны алдааны эрсдэлийн менежмент, шимтгэл төлөлтөөс зайлсхийх, залилангийн хяналтыг хэрэгжүүлэх стратегийг тодорхойлдог.

Бүтэц

- Удирдлага нь хамрагдахад хүндрэлтэй бүлгүүдэд зориулсан шимтгэл төлөлтийн эрсдэлийг системтэйгээр тодорхойлох, үнэлэх, зэрэглэл тогтоох эрсдэлийн удирдлагын журмыг батлах ёстой.
- Удирдлага нь эдгээр бүлгүүдийн журмыг дагаж мөрдөх эрсдэлийг удирдах арга хэмжээ, зорилгодоо хүрэхийг үнэлэхийн тулд гүйцэтгэлийн тодорхой шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох ёстой.
- Эдгээр арга хэмжээг боловсруулахдаа ОУНХХ-ны Шимтгэл төвлөрүүлэлт, түүний журмын тухай Удирдамжийн D хэсэгтэй нийцүүлэх нь зүйтэй.

Механизм

- Удирдлага нь шимтгэл төвлөрүүлэх үйл явцын эхний үе шатуудаас эхлэн захиргааны алдаа, залилан мэхлэлтээс урьдчилан сэргийлэх, бууруулахын тулд урьдчилсан тооцоолол хийж, хувь хүний мэдээлэл, өгөгдлийг эрт баталгаажуулах ёстой.
- Мэдээллийг давхар шалгах зорилгоор Засгийн газрын бусад агентлагуудтай гэрээ, хэлэлцээрийн үндсэн дээр хамтран ажиллах ёстой.
- Татварын байгууллага болон иргэний бүртгэлийн газартай хамтран ажиллах нь бүртгэл, мэдээлэл хөтлөлтийг сайжруулахаас гадна мэдээллээ дутуу өгөх, тэтгэврийн хуурамч нэхэмжлэл (тэтгэвэр авагч нас барсны дараа тэтгэврийг үргэлжлүүлэн авах г.м)-ийн асуудлыг илрүүлэх боломжтой.
- Орлогыг дутуу мэдүүлсэн асуудлыг шийдвэрлэхийн тулд удирдлага дараах арга хэмжээг авч болно:
 - Тооцооллын цалинг бүх даатгуулагчдын шимтгэл тооцох суурь болгон ашиглаж болох бөгөөд салбар, бүс нутаг, салбарын дундаж эсвэл хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс хамааруулан цалинг тодорхойлно;
 - Даатгуулагчийн орлогоос хамаарахгүйгээр шимтгэлийн хэмжээг тогтоож болно.

Энэ нь төвөг багатай арга барилын хувьд орлоготой холбоотой шимтгэлээс татгалздаг боловч бага орлоготой хүмүүсийн хувьд төлөхөд хэцүү байх магадлалтай босго түвшнийг бий болгож болзошгүй;

- Шимтгэлийн хэмжээг өөр сууриас тооцож болно. Жишээлбэл, шимтгэл нь ажилласан цаг, эзэмшиж буй хөрөнгө эсвэл хэмжихэд хялбар, шалгах боломжтой өөр хувьсагч дээр үндэслэсэн байж болно;
- Орлогоо бүрэн мэдүүлсний урамшууллыг хэрэгжүүлж болдог. Ингэхдээ даатгуулагчид ирээдүйд хүртэх тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг ихэвчлэн харуулдаг;
- Орлогын дутуу мэдүүлэлтийг зогсоохын тулд илүү хатуу шийтгэл ногдуулж болом юм. Тийм шийтгэлийн үр нөлөө нь хяналтын хийх тоо, торгуулийн түвшнээс ихээхэн хамаарна.
- Цагаач ажиллагчдын хувьд Нийгмийн даатгалын байгууллагаас тусгай арга хэмжээ авах шаардлагатай байж болно. Жишээлбэл:
 - Даатгалд хамрагдах хүчин чармайлтыг дэмжихийн тулд сонирхогч талууд болон цагаач ажиллагчдын байгууллагуудтай нягт хамтран ажиллах;
 - Цагаач ажиллагчдад тохирсон харилцаа холбооны сувгаар тэдний хэлээр мэдээллийг хүргэх;
 - Цагаач ажиллагчдыг ажилд авдаг ажил олгогчдын төвлөрөл бүхий эдийн засгийн тодорхой салбаруудад анхаарлаа хандуулах.

А.6. Үйлчилгээ, тэтгэвэр, тэтгэмжийг цаг тухайд нь, үнэн зөв, үр дүнтэй хүргэх

Нийгмийн хамгааллын байгууллагууд нь хамрагдахад хүндрэлтэй бүлгүүдийн хэрэгцээ, нөхцөл байдалд тохирсон тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээг үр дүнтэй хүргэх ёстой.

Удирдамж 18. Үйлчилгээг хүргэх төлөвлөгөө боловсруулах

Нийгмийн даатгалын байгууллага нь нөөц бололцоотойгоо уялдсан иргэн төвтэй үйлчилгээний төлөвлөгөөг боловсруулж, сайжруулах замын зураглалыг гаргах шаардлагатай.

Бүтэц

- Нийгмийн даатгалын байгууллагын үйлчилгээ үзүүлэх төлөвлөгөө нь хүрсэн ололт амжилтдаа тулгуурлан, нөөц бололцоогоо хэрхэн үр дүнтэй ашиглаж, хамрах хүрээг өргөтгөх зорилго, зорилтуудыг хэрхэн хэрэгжүүлэх талаар тодорхой тайлбарласан байх ёстой.

Механизм

- Нийгмийн даатгалын байгууллага нь цахим платформд тулгуурласан иргэн төвтэй аргачлалыг үйлчилгээндээ ашиглаж, хүртээмжийг нэмэх, давхардлыг бууруулах, мэдээллийг хурдан шуурхай өгөх, захиргааны зардал, ачааллыг бууруулах зорилготой байх ёстой. Үүний зэрэгцээ онлайн үйлчилгээнд хамрагдах боломжгүй, компьютерын мэдлэггүй, онлайн үйлчилгээг ашиглахад бэрхшээлтэй хүмүүст биечлэн үзүүлэх үйлчилгээ нээлттэй байх ёстой.
- Удирдлага нь шуудан, вэб хуудас, гар утас, өөрөө үйлчлэх машин, биечлэн үйлчилгээ авах зэрэг сувгуудаар дамжуулан үйлчилгээний хүртээмжийг оновчтой болгож, иргэдэд чиглэсэн цогц цэс (Удирдамж 20-г үзнэ үү)-тэй байх ёстой бөгөөд шаардлагатай бол захиргааны журмуудыг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах ёстой.
- Удирдлага нь хүлээн авсан үйлчилгээний чанарын талаар санал бодлоо илэрхийлэх боломжийг хэрэглэгчдэд олгох ёстой. Нийгмийн даатгалын байгууллагын ажилтнуудыг бизнес үйл явц, үйлчилгээний чанарыг сайжруулах талаар санал бодлоо чөлөөтэй илэрхийлэхийг дэмжих хэрэгтэй.
- Удирдлага нь босоо удирдлагын зарчимд тулгуурлан үйлчилгээний бүтэц (улс, бүс нутаг, орон нутгийн түвшин), үүрэг, хариуцлагыг харгалзан үйлчилгээ үзүүлэх төлөвлөгөөг боловсруулах ёстой. Энэхүү төлөвлөгөөнд зардлыг бууруулах, давхардлаас зайлсхийх, хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор бусад байгууллага, институцууд (жишээлбэл, орон нутгийн удирдлага, олон нийтэд түшиглэсэн хөтөлбөр г.м) - ыг татан оролцуулж болно.
- Захиргааны мэдээлэлд дүн шинжилгээ хийж, сайжруулах шаардлагатай хэсгийг тодорхойлох шаардлагатай. Жишээлбэл, зарим төрлийн шийдвэрийн талаар гомдол их байх нь бодлого, үйл явц, сургалт, харилцааны зарим дутагдал байгааг илтгэж болно.

Удирдамж 19. Цахим төлбөр тооцоо, онлайн үйлчилгээг оновчтой ашиглах

Нийгмийн даатгалын байгууллага нь цахим төлбөр тооцоо, онлайн үйлчилгээг нэвтрүүлж, техникийн боломж, зорилтот бүлгийн онцлогт үндэслэн тэтгэвэр, тэтгэмж олгох, шимтгэл төвлөрүүлэх ухаалаг, хэмнэлттэй арга замыг хэрэгжүүлдэг агентлаг болж амжилтаа ахиулах ёстой.

Бүтэц

- Байгууллага нь үйлчлүүлэгчтэй хоёр талын харилцаа холбоог хөнгөвчлөх онлайн үйлчилгээг бий болгох ёстой. Эдгээр үйлчилгээг мэдээллийн нууцлал, хувь хүнийг таних нэвтрэлт, МХХТ-ийн аюулгүй байдлын зохицуулалтыг харгалзан төлөвлөх ёстой.
- Ийм арга хэмжээ авахдаа ОУНХХ-ны Үйлчилгээний чанарын тухай удирдамж, ОУНХХ-ны Мэдээлэл, харилцаа холбооны технологийн тухай удирдамж болон ОУНХХ-ны Нийгмийн хамгааллын байгууллагуудын харилцааны тухай удирдамжийг мөрдлөг болгож, дараах асуудлууд дээр голлон анхаарах ёстой:
- Цахим үйлчилгээг хэрэгжүүлэхдээ хэрэглэгчдийн хэрэгцээ, шаардлага, техникийн хязгаарлалт (жишээлбэл, зарим бүс нутагт өргөн зурвасын сүлжээгүй г.м)-ыг харгалзан үзэх;
- Системийн хуваагдлаас зайлсхийхийн тулд нэгдсэн мэдээлэл, баталгаажуулалт, тооцооллын системийг ашиглах;
- Цахим үйлчилгээг үр дүнтэй ашиглахад дэмжлэг үзүүлэх зорилгоор МХХТ-ийн тохиромжтой ажиллагаа (жишээ нь, 24/7-оор 365 өдөр ажиллах) болон тусламж авах үйлчилгээг практикт нэвтрүүлэх.

Механизм

- Удирдлага нь цахим төлбөр тооцоонд хялбаршуулсан журам ашиглах, гүйлгээний зардлыг бууруулах, алдаанаас урьдчилан сэргийлэх, бэлэн мөнгө ашиглахгүй тул хамгаалалт, аюулгүй байдлыг харгалзан үзэх ёстой.
- Цахим төлбөр тооцоо нь шимтгэл төвлөрүүлэх байгууллага, шимтгэл төлөгчид, төлбөрийн хэрэгсэл (гар утас, нэг цэгийн үйлчилгээ г.м), хэрэглүүр (ухаалаг карт, SIM карт г.м), нэвтрэлтийн аргууд (PIN, бүртгэгдсэн утасны дугаар г.м), гүйлгээг хийх мэдээлэл холбооны хэрэгсэл, өгөгдлийн дэд бүтэц, төлбөрийн системийн үйл ажиллагаа зэргийг багтаасан ерөнхий загварыг дагаж мөрдөх ёстой.
- Тэтгэвэр, тэтгэмжийг олгох, үйлчилгээ үзүүлэх онлайн систем нь наад зах нь дараах функцуудыг агуулна:
 - Тэтгэвэр, тэтгэмж авагчдад төлсөн шимтгэл болон тэтгэвэр, тэтгэмж авах эрхийн талаар мэдээлэл өгөх;
 - Төрөл бүрийн маягт, тодорхойлолт хэвлэх (виз мэдүүлэх зорилгоор тэтгэврийн орлогын тодорхойлолт авах г.м);

- Эмнэлгийн даатгалын нөхөн төлбөрийг эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч болон нийгмийн даатгалын байгууллага хооронд шийдвэрлэх, даатгуулагч зардлын зөвхөн өөрийн хариуцах хувийг төлөх;
 - Нийгмийн даатгалын цахим банк нь зөвхөн ажил олгогч, даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийг төлөхөөс гадна нийгмийн хамгааллын бусад тэтгэвэр, тэтгэмжийг олгох боломжоор хангаж, хөнгөвчлөх;
 - Тэтгэврийн тогтмол эрхээ баталгаажуулсан биометрийн баталгаажуулалтыг онлайнаар илгээх.
- Банк, санхүүгийн үйлчилгээнд хамрагдах боломж хязгаарлагдмал эсвэл огт хүртээмжгүй ашиг хүртэгчдийн хувьд удирдлага дараах хувилбаруудыг авч үзэж болно:
 - Хөдөлгөөнт оффисууд, нэгдмэл, сайн үйлчилгээ үзүүлэх чадвартай үйлчилгээний сүлжээ;
 - Урьдчилсан төлбөрт дебит карт эсвэл цахим шилжүүлгийн данс үүсгэх;
 - Шимтгэл цуглуулж, тэтгэвэр, тэтгэмж төлөх зорилгоор харилцаа холбооны компаниудтай хамтран ажиллах.

Удирдамж 20. Биечлэн үйлчилгээ авах болон онлайн үйлчилгээнд тохирсон бүтцийг тогтмол сайжруулах

Нийгмийн даатгалын байгууллага нь хамрагдахад хүндрэлтэй бүлгийн тусгай хэрэгцээг хангах үйлчилгээ үзүүлэх бүтцийг байнга сайжруулж, боловсронгуй болгож байдаг.

Бүтэц

- Удирдлага нь байгууллагын давуу тал болон босоо удирдлагын зарчмуудад тулгуурлан үр ашиг, нөлөөг нэмэгдүүлэхийн тулд дотооддоо гүйцэтгэх чиг үүрэг болон түншлэгч байгууллагуудын гүйцэтгэх чиг үүргийг тодорхой зааж өгөх ёстой.
- Удирдлага нь газар зүйн байрлал, хүн амын бүтэц, соёл, хэлний ялгаа болон МХХТ-ийг харгалзан түншлэгч байгууллагуудтай хамтран сайн зохион байгуулалттай үйлчилгээний бүтцийг бий болгох ёстой.

Механизм

- Удирдлага нь захиргааны ихэнх ажлыг нэгдмэл байдлаар хэрэгжүүлэх чадвартай, иргэдтэй харилцах хангалттай тооны боловсон хүчнийг татах, сургах, хадгалах арга хэмжээ авах ёстой.
- Удирдлага нь үйл ажиллагааны дүрмийг таниулах, байгууллагын талаар мэдлэг олж авах, байнга суралцах эрмэлзлийг бий болгох зорилгоор иргэдтэй харилцах ажилтнуудад зориулсан удирдлагын арга хэрэгсэл, үйл явцыг бий болгох ёстой.
- Удирдлага сонгосон байршлууд дахь туршлагуудаа нэгтгэж, тэтгэвэр, тэтгэмж авах нарийн төвөгтэй үйл явцыг онлайнаар шийдвэрлэх боломжтой техникийн дэмжлэг үзүүлэх хүчирхэг нэгжүүдийг байгуулах замаар шинжээчдийн төвийг бий болгоход анхаарах хэрэгтэй. Энэ нь ажилтнуудын цагийг чөлөөлж, биечлэн үйлчилгээ хүссэн хүмүүст илүү сайн үйлчилгээ үзүүлэх боломжийг олгодог.
- Удирдлага нь алслагдсан бүс нутагт амьдардаг, биечлэн үйлчилгээ авах шаардлагатай хүмүүст анхан шатны нэгж дээрх оффисоос утасны болон видео үйлчилгээг хөгжүүлж, сайжруулж болно. Үүний тулд нийгмийн сүлжээгээр үзүүлж буй үнэгүй чатын үйлчилгээ зэрэг хамгийн сүүлийн үеийн харилцаа холбооны хэрэгслийг бүрэн ашиглах ёстой. Яагаад гэвэл тэдгээр нь анхан шатны нэгж (оффис) хүртэл хол зайд аялах шаардлагатай байж болзошгүй алслагдсан бүс нутгийн хүмүүст найдвартай, зардал багатай үйлчлэх боломжийг олгодог. Эдгээр нээлттэй платформ дээр зөвхөн нууц бус мэдээллийг солилцох ёстой.
- Хязгаарлагдмал дэд бүтэцтэй, хүн ам сийрэг суурьшсан газруудад зорилтот бүлгүүдэд хүрэхийн тулд явуулын оффис байгуулахад анхаарч болно.
- Удирдлага нь хүн амын нягтаршил ихтэй бүс нутагт зорилтот бүлгүүдэд хялбар хүртээмжтэй үйлчилгээг хүргэхийн тулд тэдэнд ойрхон газар (зорилтот бүлгийн амьдардаг эсвэл ажилладаг газарт ойрхон байрлах худалдааны төв, оффис г.м)-т олон төрлийн төрийн үйлчилгээг хүргэх нэг цэгийн үйлчилгээг бий болгож болно.
- Удирдлага нь боловсон хүчний чадавхыг сайжруулах зорилгоор өөрийн сургалтын төв ("онлайн" байж болно)-ийг байгуулах эсвэл бусад сургалтын байгууллагын

бүтцэд нэгтгэн оруулах ёстой.

- Нийгмийн даатгалын байгууллага нь өөрөө эсвэл бусад байгууллагаас үйлчилдэг үйлчилгээний төвд иргэдийг татах боломжийг олгодог “нийгмийн хамгааллын үйлчилгээний дугуйлан”-г ашиглах талаар бодож болно. Тодорхой үйлчилгээ үзүүлэхэд цаг хугацааны хязгаарлалт тогтоож, эдгээр хязгаарыг байнга шинэчилж байх ёстой. Иргэдтэй харилцах ажилтнуудын гүйцэтгэлийн үнэлгээ нь үйлчлүүлэгчдийн байнгын санал гомдолтой нягт холбоотой байх ёстой. Хэрэглэгчид аль болох онлайн үйлчилгээг ашиглахыг дэмжих ёстой. Биет дэд бүтцийг онлайн үйлчилгээ, утасны үнэгүй тусламжийн утас, түншлэгч байгууллагын бүтэцтэй хослуулснаар хамрагдахад хүндрэлтэй бүлгүүдэд хүрч, тэдний нийгмийн хамгааллын өөрчлөгдөж буй хэрэгцээг хангахад улам дөхөм болж байдаг.

Удирдамж 21. Тэтгэвэр, тэтгэмжийн эрхийн зохицуулалт, шилжих боломжийг сайжруулах

Нийгмийн даатгалын байгууллага нь үндэсний хууль тогтоомжийн хүрээнд өөр өөр хөтөлбөрүүд хооронд болон нийгмийн хамгааллын чиглэлээр хоёр ба олон талт гэрээ байгуулсан өөр өөр улс орнуудын хоорондын тэтгэвэр, тэтгэмжийн зохицуулалт, шилжих боломжийг нэвтрүүлэх, тогтмол сайжруулах урт хугацааны стратегийг батлах ёстой.

Бүтэц

- Нийгмийн даатгалын байгууллага тэтгэвэр, тэтгэмжийн эрхийн шилжилт, зохицуулалтыг чанартай үйлчилгээний нэг чухал элемент гэж үзэх ёстой. Ялангуяа өөр өөр мэргэжил, байршил, албан ба албан бус эдийн засгийн үйл ажиллагаа, эсвэл өөр өөр улс орнуудын хооронд шилжиж ажиллах хандлагатай байдаг хамрагдахад хүндрэлтэй бүлгүүдийн хувьд энэ нь чухал юм.
- Нийгмийн даатгалын байгууллага нь нийгмийн хамгааллын дутуу хамрагдалт, эсвэл цагаач ажиллагчид өөрийн болон хүлээн авагч орондоо аль алинд нь шимтгэл төлөх үүрэг хүлээдэг давхардлаас зайлсхийхийн тулд хоёр болон олон талт нийгмийн хамгааллын гэрээ байгуулахыг эрмэлзэх ёстой.
- Нийгмийн даатгалын байгууллага нь өөрийн улсын бусад хөтөлбөрүүдийн хоорондын зохицуулалт, хоёр болон олон талт нийгмийн хамгааллын гэрээ хэлэлцээрийг хийхэд хариуцсан яаманд захиргааны дэмжлэг үзүүлэх дотоод нэгжийг томилох буюу байгуулах ёстой.

Механизм

- Нийгмийн даатгалын байгууллага нь нийгмийн хамгааллыг хөгжүүлэх урт хугацааны стратеги боловсруулахад тэтгэвэр, тэтгэмжийг шилжүүлэх, өөр өөр хөтөлбөрүүдийн хоорондын уялдаа холбоог хангах чиглэлээр нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хүчин чармайлтад дэмжлэг үзүүлэх ёстой.
- Нийгмийн даатгалын байгууллага нь нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагыг гадаад улстай хоёр болон олон талт нийгмийн хамгааллын гэрээ байгуулахад захиргааны дэмжлэг үзүүлэх ёстой.
- Нийгмийн даатгалын байгууллага нь шинэ хөтөлбөрийг батлахдаа бусад хөтөлбөртэй уялдуулах, нэгтгэх ажлыг хөнгөвчлөхийн тулд шимтгэл болон тэтгэвэр, тэтгэмжийн аль болох ижил төстэй бүтцийг ашиглах ёстой.
- Нийгмийн даатгалын байгууллага нь харилцан уялдаатай ажиллагаа, нийгмийн хамгааллын тогтолцоог үр дүнтэй зохицуулахад шаардлагатай нэгдсэн бүртгэл, хэрэгслийг боловсруулж хэрэгжүүлэхэд хялбар байх үүднээс МХХТ-ийн нөөцөө үндэсний бусад хөтөлбөрүүдтэй хуваалцах ёстой.
- Удирдлага нь захиргааны үйл ажиллагааг стандартчилах болон автоматжуулсан дүн шинжилгээ, бизнесийн дүрэм, хяналт, шалгалтыг системд багтаах, эдгээр

үйл ажиллагааг хялбархан давтан гүйцэтгэх, өргөжүүлэх боломжтой байх бизнес загварыг бий болгох ёстой.

- Бизнесийн үйл явцыг сайтар хянаж, давтагдаж байгаа үйл явцыг мэдээллийн системд суурилсан стандартчилсан дүрмээр автоматжуулах хэрэгтэй. Энэ нь залилан мэхлэлт болон захиргааны алдааг эрс багасгаж, шударга байдлыг сайжруулж, байгууллагын ил тод байдал, сайн засаглалыг нэмэгдүүлэх болно. Ингэснээр үйлчилгээг өргөжүүлж, олон тооны боломжит үйлчлүүлэгчдийг хамруулах боломжтой юм.

В. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ, ХҮН АМЫН ДУНД ИТГЭХ ИТГЭЛИЙГ БИЙ БОЛГОХ ЗОХИЦУУЛАЛТЫН СТРАТЕГИЙГ ТОДОРХОЙЛОХ НЬ

Өнөө үед олон улс орнууд орнууд Бүх нийтийн эрүүл мэндийн даатгалын (БНЭМД) тогтолцоог бий болгох замаар Тогтвортой Хөгжлийн Зорилтуудыг биелүүлэхээр хичээж байна. БНЭМД нь хүмүүсийн шимтгэл төлөх чадвараас үл хамааран анхан шатны, чанартай, хүртээмжтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хөгжүүлэхээр зорьж байгаа юм.

Хамрах хүрээг нэмэгдүүлэх хөндлөн болон босоо арга нь олон талын оролцогчдыг (төр, олон нийтийн нийгмийн хамгаалал, нийгмийн тусламжийн байгууллагууд, нийгмийн түншүүд, иргэний нийгэм, хувиар даатгалын үйлчилгээ үзүүлэгчид) хамарсан нийгмийн яриа хэлэлцээр, нэгдсэн стратегийн тасралтгүй үйл явцаар дамжуулан хүн амын дунд итгэлцлийг бий болгох шаардлагатай ба бүх насны хүмүүсийг хамруулахын тулд эрүүл мэнд, эдийн засаг, нийгмийн өөрчлөлтийг харгалзан үзэхээс гадна эрхийн тасралтгүй байдлыг хангана. Үнэхээр ч олон нийтийн итгэл үнэмшил өндөр байх нь шимтгэл төлөлтийг илүү эергээр хүлээж авахад маш чухал нөлөөлөгч ба нийгмийн эрүүл мэндийн бодлогын дэмжлэгийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Даатгал нь улам бүр нэмэгдэж буй байгаль орчны хамааралтай хязгаарлалтыг харгалзан үзэж, хямралыг даван туулах чадвартай байх ёстой.

Цаашлаад эрүүл мэндийн хямралаас үүдэлтэй томоохон нөлөөллүүд, түүний зохицуулалтын нарийн төвөгтэй байдлаас шалтгаалан тал бүрийн оролцогчдоос илгээж буй санааг боловсруулахын тулд эрүүл мэндийн хяналтын ямар нэг бүтэц бүхий тогтолцоог бий болгох нь чухал юм. Үндэсний эсвэл олон улсын олон талт мэдлэг ур чадварыг хөгжүүлэх нь зарим тохиолдолд даатгалын менежерүүдийн үүргийг төрийн байгууллагууд хариуцаж, уламжлалт журмаас (амны хаалт нийлүүлэх, вакцинжуулалт, тэтгэмжийг зохицуулах гэх мэт) хазайж, шуурхай хариу үйлдэл үзүүлэхэд хүргэдэг.

Эрүүл мэндийн даатгал нь нийгмийн хамгаалалд хүрэх гарц болдог ба тэтгэмжтэй төстэй мэт санагдах ч хүн амын дунд тэтгэвэрээс илүү бодитой харагддаг. Иймд эрүүл мэндийн даатгалд хамрагдаж хэвшээгүй салбарын хүн амын бүлгийн хэрэгцээг илүү сайн ойлгосны үндсэн дээр (орон нутгийн ажилчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бус ажилчид) тэднийг бүртгүүлэх нь эцсийн дүндээ нийгмийн хамгааллыг нь нэмэгдүүлэхэд туслах сайн арга зам юм.

Энэ хүрээнд хууль эрх зүй, төсвийн хүрээ, санхүүжилтийн олон талт байдлаас эхлээд зарлагын хяналт, сайн засаглал, залилантай тэмцэх зэрэг зохицуулалтын механизмуудыг дайчлан даатгалыг тогтвортой байлгах, хамгаалах шаардлагатай байна.


Даатгал нь үндсэндээ санхүүгийн шинжтэй байдаг бусад эрсдэлээс илүүтэйгээр эрүүл мэндийн даатгалыг зохицуулахад эрүүл мэндийн тусламж үйлчилгээний журам, бараа бүтээгдэхүүний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, архаг хууч өвчин, хүн амын хөгшрөлттэй холбоотойгоор зардал тогтмол нэмэгдэж байгаа нөхцөлд тогтолцооны санхүүгийн тогтвортой байдлыг хангах, инновацыг дэмжих, тахал өвчинтэй холбоотой тохиолдлуудыг удирдах зэргийг оролцуулах шаардлагатай байдаг. Эдгээр олон тооны зорилтууд нь зөвхөн эрүүл мэндийн зардлыг хянахаас илүүтэйгээр эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эрэлт, нийлүүлэлтийн хоорондын тэнцвэрийг байнга тогтоож

байх зохицуулалтын бодлогын хэрэгцээг бий болгодог. Ийм учраас эрүүл мэндийн даатгалын салбарын зарим зохицуулалтын стратегийн онцлог шинж чанарыг харгалзан үзэхэд зарим шинэ зорилтот удирдамжуудын хэрэгцээ үүссэн нь тодорхой байна.

Эдгээр нь улс орнуудад санхүүгийн болон нийгмийн томоохон саад бэрхшээл учруулахгүйгээр бүх иргэддээ өндөр чанар бүхий тусламж үйлчилгээ үзүүлэхэд дэмжлэг болох болно.

Энэхүү зохицуулалтын тойм нь өөр өөр зохицуулалтын үүргүүд, оролцогчид болон үйл ажиллагааг харуулж байна (Зураг 1). Оролцогч талууд нь төрөл бүрийн үйл явцын туршид, ялангуяа хамтын стратегийг нэгтгэх, хэрэгжүүлэх, үнэлэхэд (эрүүл мэндийн мэргэжилтнүүд, улс төрчид, зорилтот бүлгүүд болон тус салбарын бусад оролцогчдын хооронд) чухал үүрэг гүйцэтгэдэг.

Зураг 1. Зохицуулалтад оролцогчид болон арга хэрэгслүүд



Удирдамж 22. Эрүүл мэндийн даатгалын онцлогт тохирсон орчны судалгааг боловсронгуй болгох

Нийгмийн хамгааллын байгууллага нь ирээдүйд эрүүл мэндийн бүтээгдэхүүн, тусламж үйлчилгээг хүн амын бодит хэрэгцээнд нийцүүлэх зорилгоор эрүүл мэнд, эдийн засаг, нийгмийн нөхцөл байдлыг үнэлэх арга хэрэгслийг дайчлан ажилладаг. Эрүүл мэндийн даатгалд хамруулах ажлыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд таатай орчны талаар үнэн зөв мэдээлэлтэй байх шаардлагатай.

Бүтэц

- Эрүүл мэндийн даатгалын хөтөлбөрийг хэрэгжүүлэх таатай орчныг бүрдүүлнэ гэдэг нь:
 - Хүн амын дунд түгээмэл тохиолддог өвчлөлийн талаар (хүйс, нас, бүс нутгаар нас баралт/хамгийн түгээмэл эмгэгээр өвчлөлт) зэрэг аль болох их тархвар судлалын мэдээлэл цуглуулах;
 - Хүн амд тусламж, үйлчилгээ үзүүлдэг байгууллага, мэргэжилтнүүдийн дэлгэрэнгүй жагсаалтыг гаргах, мөн хамаарах тохиолдолд иргэдэд үзүүлж буй тусламж үйлчилгээний багцыг бүрдүүлнэ.
- Хүрээлэн буй орчны өөрчлөлт, халдварт өвчин, хүнсний аюулгүй байдал, зохистой хөдөлмөр эрхлэлт зэрэг нь даатгалын түвшин ба авч хэрэгжүүлж буй арга хэмжээнд нөлөөлдөг учир эрүүл мэндэд нөлөөлөгч томоохон хүчин зүйлсэд дүн шинжилгээ хийх нь байгууллагын үүрэг юм.
- Байгууллага нь мэдээлэл цуглуулдаг, мөн тэдгээрийг ашигладаг төрөл бүрийн оролцогч талуудын үүргийг нарийн тодотгож өгснөөр найдвартай, өгөөжтэй ашиглаж болохуйц үр дүнд хүрнэ.

Механизм

- Нийгмийн даатгалын байгууллага нь эрүүл мэндийн талаарх хөшүүрэг болж өгөхүйц мэдээллийг эрэмбэлэн жагсаалт гаргана. Жишээлбэл, тус жагсаалтад дараах зүйлсийг багтаасан байна:
 - Эрүүл мэндийн зардалд ба/эсвэл хөдөлмөрийн чадвар алдагдахад ихээхэн нөлөөлсөн өвчин, осол;
 - Тархалт ихтэй өвчнүүд;
 - Амьдралын хэв маягтай холбоотой өвчлөл (чихрийн шижин, бодисын солилцооны өвчин) болон хууч, архаг өвчин.
- Нийгмийн даатгалын байгууллага нь даатгал нэвтрүүлэхдээ мэдээлэл хамгаалах тухай хуулийн дагуу зөвшөөрөгдсөн бүх арга хэрэгслийг ашиглан хүн амын эрүүл мэндийн байдлыг тодорхойлогч үзүүлэлтүүдийг цуглуулна:
 - Иргэний бүртгэл;
 - Мэдэгдэх шаардлагатай өвчний бүртгэл;

- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчдэд байгаа бүртгэлүүд: клиник, эмнэлэг, эмч, эмийн сан;
- Орон нутгийн түвшинд хийсэн судалгаа: тосгон, сүм, нэгдэл, эвлэл болон нийгэмлэг.
- Нийгмийн даатгалын байгууллага нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчдийн зураглалыг бүс нутгаар нь ангилан гаргаж болно:
 - Эмнэлэг (орны тоо, төрөл, чиглэл), клиник, эмийн сан;
 - Уламжлалт анагаах ухааны болон эрүүл мэндийн мэргэжилтнүүд;
 - Бүх нийтийн эрүүл мэндийн төвүүд болон ажилчид.
- Байгууллага нь хувийн мэдээллийг хуваалцахдаа болон ашиглахдаа мэдээллийн аюулгүй байдлыг хангах үүднээс зохистой ажиллагааны дүрэм гэх мэт зохих процедурыг боловсруулна:
 - Эрүүл мэндийн, нийгмийн болон хувийн мэдээллийг ашиглахдаа нууцлалыг хадгалах;
 - Мэдээллийг дамжуулах, байршуулах үеийн аюулгүй байдал;
 - Бүх нийтийн эрүүл мэндийн даатгалын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх зорилгоор мэдээллийн хүртээмж, ашиглалтын зорилгыг тодорхойлох;
 - Хувийн нууцлал бүхий мэдээлэлд нэвтрэх эрхийг хязгаарлах;
 - Мэргэжлийн болон эрүүл мэндийн нууцлалыг тогтооно.

Удирдамж 23. Аливаа ялгаваргүйгээр нийт хүн амд зориулсан эрүүл мэндийн тусламж үйлчилгээг бий болгох

Нийгмийн даатгалын байгууллага нь үйлчилгээг хэрхэн үзүүлэх, төлбөр төлөх арга зам, өвчтөний эрүүл мэндийн зардлыг даах нөхцөлийг боловсруулах замаар хүн амын бодит хэрэгцээнд нийцэх эрүүл мэндийн тогтолцоог хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Бүтэц

- Эрүүл мэндийн даатгалыг бий болгох, өргөжүүлэх гол хүчин зүйл бол эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хэмжээг хангалттай болгох явдал юм. Энэ нь нэг талаасаа эрүүл мэндийн байгууллагуудын тоог хүрэлцээтэй болгоход хөрөнгө оруулах (шинэ технологийн үндсэнд бий болсон боломжуудыг мөн харгалзан үзэх), нөгөө талаас үр дүнтэй, аюулгүй эрүүл мэндийн тусламж үйлчилгээг зөв цагт нь тохирох мэргэжилтнүүд үзүүлдэг байх бололцоог хангана гэсэн үг юм.
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний багцын чанар, тоо хэмжээг цаашид ч хадгалах нь чухал байдаг. Зардал/үр ашгийн харьцааг (эрүүл мэндийн үр ашгийг) хамгийн өгөөжтэй байлгахын тулд байнгын үнэлгээнд хамрагдана.
- Улс орон бүрийн нэвтрүүлсэн бараа, үйлчилгээ нь бэлэн байдал, хүртээмж, таарамж, чанар зэрэг шалгууруудыг хангасан байх ёстой.
- Эдгээр зорилтуудад хүрэхийн тулд оролцогч бүх талуудын (төр, шинжлэх ухааны байгууллагууд, хамтын сангууд, хувийн даатгалын компаниуд, төрийн болон хувийн эрүүл мэндийн байгууллагууд, даатгуулагчдын төлөөлөл, эрүүл мэндийн мэргэжилтнүүд) оролцоо шаардлагатай байдаг. Тус бүрийн үүрэг нь тухайн улсын үзүүлдэг эрүүл мэндийн үйлчилгээний онцлогоос хамааран өөр өөр байна.

Механизм

- Байгууллага нь оролцогч талуудаас мэдээлэл авах замаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах шаардлагатай –жишээлбэл үр дүн, аюулгүй байдал эсвэл тусламж үйлчилгээг цаг алдалгүй хүргэх– тэргүүлэх чиглэлүүдийн жагсаалтыг гаргана.
- Тусламж үйлчилгээг хүн амын хэрэгцээ, ялангуяа эрүүл мэндийн байгууллагуудын тоо, онцлог шинж, эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн тоо, төрөлд нийцүүлэх шаардлагатай.
- Дараа нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний багцын чанарыг сайжруулахад хэд хэдэн механизмыг ашиглаж болно:
 - Мэргэжилтнүүдэд хоёр үндсэн чиглэлээр дадлага туршлагаа дээшлүүлэхэд нь туслах зорилго бүхий зохистой арга ажиллагаа болон тусламж үйлчилгээний зөв ашиглалтын талаар зөвлөмж хүргүүлэх:
 - Өвчтөнд үзүүлдэг эрүүл мэндийн үйлчилгээний үр ашиг-эрсдэлийн тэнцвэр (үйлчилгээ, эмчилгээ, үзлэг, мэс ажилбар). Эрүүл мэндийн үйлчилгээ нь өвчтөний эрүүл мэндэд ашиг тусаа өгөхийн зэрэгцээ эрсдэл дагуулах магадлалтай;

- Өвчтөнд үзүүлдэг эрүүл мэндийн үйлчилгээний үр ашиг. Зорилго нь өвчтөний эрүүл мэндэд хамгийн ашигтай үр дүнг хамгийн бага зардлаар хэрхэн үзүүлэхийг олох юм;
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг найдвартай үзүүлэх, өвчтөний аюулгүй байдлыг хангах удирдамж, зөвлөмжүүдийг дараах хүчин зүйлсээс хамааруулан бэлтгэнэ:
 - Эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн мэргэжлийн ур чадвар;
 - Техник хэрэгслийн чанар;
 - Тусламж үйлчилгээ ба эмчилгээний чанар;
- Тухайн бүс нутаг дахь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зохион байгуулалтыг оновчтой болгоход чиглэсэн үзүүлэлт, зөвлөмжүүдийг дараах байдлаар өгөх:
 - Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх хуваарилалтыг эрүүл мэндийн хэрэгцээнд нийцүүлэх, ингэснээр цаашлаад зураглал, дараа нь төлөвлөгөө гаргах боломжтой;
 - Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний багц нь удаан ашиглагдахуйц, зохицуулалт сайтай, мөн эрүүл мэндийн мэргэжилтнүүд мэдээлэл солилцох боломжтой байх. Өвчтөний бүртгэлийг хуваалцах зэрэг арга хэрэгслээр дамжуулан эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн хоорондын уялдаа холбоог эрэлхийлж, эрүүл мэндийн давтан үзлэгийг сайжруулах, ашиггүй эсвэл шаардлагагүй эмчилгээний явцаас зайлсхийх;
- Урамшуулал цалинг тусламж үйлчилгээний чанартай холбох. Дараах арга замуудын аль нэгээр тус холбоосыг үүсгэж болно:
 - Чанарыг дэлгэрүүлэх зорилгоор жишээ болгон өмнө нь дурдсан зохистой арга ажиллагаа болон тусламж үйлчилгээний зөв ашиглалтыг дагаж мөрдсөн байдал зэргийг урамшуулал олгох шалгуурт багтаах;
 - Олон нийтийн эрүүл мэнд (сэргийлэх үзлэгийн хувь, вакцинжуулалтын хувь) эсвэл тусламж үйлчилгээний уялдаа (өвчтөний бүртгэл хөтлөх) зэрэгт тавьсан зорилтыг биелүүлсэн бол нэмэлт урамшуулал олгох;
- Хүн амын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн, үйлчилгээний үр нөлөөг үндэслэж нөхөн төлбөрт эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тодорхойлох. Даатгуулагчийн төлөх мөнгөн дүнг их эсвэл бага байлгах нөхөн төлбөрт үйлчилгээнүүд рүү өвчтөнүүдийг олон арга замаар чиглүүлэх боломжтой. Үүнийг нөхөн төлбөрийн ялгаатай хувь хэмжээг танилцуулах замаар хийж болох ба нөхөн төлбөрийн ялгаатай хувь хэмжээ нь дараах зүйлсээс хамаарна:
 - Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний үр ашгийн түвшин (жишээлбэл, ерөнхий эмийн хэрэглээ зэргийг дэмжих);
 - Тусламж үйлчилгээний дараалал дагаж мөрдөгдсөн эсэх; зохион байгуулагддаг урьдчилан сэргийлэлтэд хамрагдсан эсэх.

Удирдамж 24. Улсын хэмжээнд хүн амд хүргэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг бэхжүүлэх

Нийгмийн даатгалын байгууллага нь эрх мэдлийнхээ хүрээнд бусад оролцогч талуудтай хамтран хүн амын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний байнгын хүртээмжийг хямралын үед ч сайжруулахыг эрэлхийлэх ёстой. Энэхүү зорилгод хүрэхэд санхүүгийн, нутаг дэвсгэрийн, нийгмийн болон цаг хугацаа зэрэгтэй холбоотой дөрвөн үндсэн саад учирдаг.

Бүтэц

- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг бодитоор хүртээмжтэй болгох нь амин чухал юм. Зарим бүлгүүдэд тулгардаг саад бэрхшээл нь тэдний эрүүл мэндийн тусламж үйлчилгээнээс татгалзах томоохон шалтгаан болдог.

Механизм

- Байгууллага нь бусад оролцогч талуудтай хамтран эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг бэхжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө гаргана. Энэхүү төлөвлөгөөг уялдаа холбоотой, үр ашигтай болгохын тулд санхүү, нийгэм, газарзүйн зэрэг хүмүүсийг тусламж үйлчилгээнээс татгалзахад хүргэж буй шалтгаануудыг бүс нутгаар нь нарийвчлан авч үзсэн судалгаанд үндэслэнэ. Төлөвлөгөө нь:
 - Даатгуулагчдын эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах санхүүгийн боломжийг хангана. Тодорхой бүлгүүдэд (ахмад настнууд, урт хугацаагаар өвчтэй, бага орлоготой гэх мэт) тулгарч буй санхүүгийн бэрхшээлийг шийдвэрлэх, ядууралд өртөхөөс сэргийлэх хэд хэдэн механизм байдаг:
 - Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг бүхэлд нь буюу хэсэгчлэн үнэ төлбөргүй эсвэл хөнгөлөлттэй үнээр үзүүлэх;
 - Эрүүл мэндийн даатгалд хамрагдахад бүрэн буюу хэсэгчилсэн санхүүгийн дэмжлэг үзүүлэх;
 - Богино хугацаанд дайчлах боломжтой эрүүл мэндийн тусламж үйлчилгээг нутаг дэвсгэрийн хэмжээнд хангах. Нийгэм-эдийн засаг, хүн ам зүй, эрүүл мэндийн онцлогоос шалтгаалан эрүүл мэндийн хэрэгцээ нь бүс нутгаас хамаарч өөр өөр байдаг. Газарзүйн саад бэрхшээлийг арилгах хэд хэдэн механизм байдаг:
 - Мэргэшсэн эрүүл мэндийн хөдөлгөөнт нэгжүүд;
 - Онлайн болон утсаар зөвлөгөө өгөх зэрэг алсын зайн эмнэлгийн үйлчилгээ;
 - Нүүлгэн шилжүүлэх үйлчилгээ;
 - Тусламж үйлчилгээний сүлжээг байгуулах;
 - Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хомсдолоос зайлсхийхийн тулд тодорхой бүс нутагт эрүүл мэндийн мэргэжилтнүүдийг татан ажиллуулах санхүүгийн болон материаллаг дэмжлэг;

- Даатгуулагчдын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нийгмийн хүртээмжийг хангах.

Даатгуулагчид тусламж үйлчилгээ авахдаа эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хэрхэн зохион байгуулагддагийг бүрэн ойлгодоггүй. Тэдний ойлголтод нас, хүйс, мэргэжил, гэр бүлийн байдал зэрэг нийгмийн тодорхойлогч хүчин зүйлс нөлөөлж болно. Нийгмийн саад бэрхшээлийг арилгах хэд хэдэн механизм байдаг:

- Нэг өвчтөнд өөр өөр эрүүл мэндийн мэргэжилтнүүдээс үзүүлэх тусламж үйлчилгээний хоорондын уялдаа холбоо бүхий тусламж үйлчилгээний дарааллыг бий болгох;
- Олгогдсон эрх болон урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл олгох;
- Эрүүл мэндийг дэмжих, мэдээллийг түгээхэд туслалцаа үзүүлэх нийгмийн бүлгийн оролцогчид.

Удирдамж 25. Үзүүлж буй эрүүл мэндийн тусламж үйлчилгээний үр ашгийг тогтмол үнэлэх

Эдийн засгийн болон үйлчилгээний чанарыг баталгаажуулах зорилгоор үзүүлж буй эрүүл мэндийн тусламж үйлчилгээг байнга үнэлж байх нь чухал юм. Эрүүл мэндийн зардлыг хангалтгүй, шаардлагагүй, чанаргүй тусламж үйлчилгээнд зарцуулах нь их байдаг. Үзүүлж буй тусламж үйлчилгээний үр ашгийг стратегиар дамжуулан хангах шаардлагатай.

Бүтэц

- Мэргэшсэн байгууллага ба эрүүл мэндийн мэргэжилтнүүдтэй зөвшилцөн тогтоож, удирдамж болгон боловсруулсны дагуу үр ашгийг эрүүл мэнд-эдийн засгийн нарийн үзүүлэлтээр хэмжиж, тодорхойлох ёстой. Энэхүү хэмжилтийн гүйцэтгэлийг тогтмол хийж, үр дүнг нь эрүүл мэндийн салбарт бүхэлд нь хүргэнэ.
- Үр ашиггүй байдлын гол эх үүсвэрийг шийдвэрлэх замаар эрүүл мэндийн салбарт стратеги бүхий худалдан авалтыг дэмжинэ.
- Тусламж үйлчилгээг тохирох байгууллагаар дамжуулан үзүүлж, хэвтэн эмчлүүлэх болон амбулаторийн тусламж үйлчилгээний тэнцвэрийг зөв олох, мэргэжилтнүүдийн хоорондын уялдаа холбоог бэхжүүлэх нь чухал юм.
- Тусламж үйлчилгээний багцыг тодорхойлох, хянахад болон Эрүүл Мэндийн Технологийн Үнэлгээний (ЭМТУ) үүргийг тодорхойлохдоо нарийвчлалын зохих түвшнийг олох шаардлагатай.
- Эрүүл мэндийн бүтээгдэхүүн, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний интервенцийн үргүй зардлаас зайлсхийх, зарцуулалтыг хэрхэн оновчтой болгох талаар хууль ёсны оролцогчдыг тодорхойлж, сургана.
- Анагаах ухааны хувьд үндэслэлгүй эсвэл хэт их хэрэглэгддэг процедурууд, шинжлэх ухааны зөвлөмжтэй нийцээгүй тохиолдлууд, мөн зөвхөн эдийн засгийн байдалд үндэслэн хийсэн сонголтууд зэргийн бүртгэлийг хөтөлнө.

Механизм

- Эрүүл мэндийн мэргэжилтнүүд болон эрүүл мэндийн сангийн менежерүүдийн дунд үр ашигч соёлыг төлөвшүүлэх, солилцоог хөнгөвчлөх, практикийн бенчмаркуудыг тодорхойлох, сангийн менежерүүдийг сургах зорилгоор мэргэжилтнүүдийн хооронд уулзалт зохион байгуулна.
- Мэргэжилтнүүдэд хариуцуулан хүлээлгэж болох нарийн тодорхой шалгуур үзүүлэлтүүдийг ашиглан тоон болон чанарын зорилтуудыг тогтооно.
- Тодорхой интервенц эсвэл үйлчилгээг авахын өмнө урьдчилан зөвшөөрөл авах шаардлагыг тавина.
- Эрүүл мэндийн анхан шатны тусламжийн ерөнхий төрөлд хамааралтай хамтын хэрэглээний бараа бүтээгдэхүүн болон үзүүлэх үйлчилгээг зэрэгт дэмжлэг үзүүлнэ.

- Тусламж үйлчилгээний багцад багтсан процедур болон тусламж үйлчилгээний эдийн засаг, шинжлэх ухааны ач холбогдлын талаар тогтмол үнэлгээ хийх ёстой.
- Тусламж үйлчилгээний зөрүүг тогтоохын тулд эрүүл мэндийн байгууллага болон тусламж үйлчилгээнүүдийг нийгмийн хамгааллын бусад байгууллагуудтай харьцуулж бенчмаркинг хийнэ.
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний аль хэлбэрийг хамруулж, алийг нь хасахыг тодорхойлохын тулд тусламж үйлчилгээний багцын тогтмол үнэлэлт дүгнэлтийг институтчилэн, ил тод мэдээлнэ.

Удирдамж 26. Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн тогтвортой байдлыг хангах

Нийгмийн даатгалын байгууллага нь эрх мэдлийнхээ хүрээнд бусад оролцогч талуудтай хамтран (Зураг 1-ийг үзнэ үү) тогтвортой санхүүжилтийг ашиглах, хамгийн их үр ашиг бүхий эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд нөөцийг хуваарилах замаар эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн тогтвортой байдлыг хангахад хувь нэмэр оруулна.

Бүтэц

- Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээ үзүүлэгч бүх оролцогч талуудтай хамтран тогтвортой санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх, зохицуулах нь уялдаа холбоог хангах, санхүүгийн алдагдлаас урьдчилан сэргийлэхэд шаардлагатай урьдач нөхцөл болох ба санхүүгийн алдагдал нь өвчтөний эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нөхөн төлбөр, эрүүл мэндийн тогтолцооны (эрүүл мэндийн байгууллагууд, түүнчлэн хөдөлмөр эрхлэгч болон хувиараа хөдөлмөр эрхлэгч эрүүл мэндийн мэргэжилтнүүд) хэвийн үйл ажиллагаанд шаардлагатай нөөцийг хуваарилахад сөргөөр нөлөөлнө.
- Үзүүлж буй эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хөрөнгө оруулалтыг дэмжих эх үүсвэрийг хуваарилах арга замыг тодорхойлох, түүнийг үр ашигтай зарцуулах (зардал/үр ашиг), мөн цаг хугацааны явцад эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн тогтвортой байдлыг хянах арга замуудыг төлөвлөх нь чухал юм.
- Нийгмийн даатгалын байгууллага нь Нийгмийн Хамгааллын Актуарийн Ажлын талаарх ОУНХХ-ОУХБ-ын Удирдамж дээрх зөвлөмжүүдийг баримтлан санхүүгийн тогтвортой байдлыг магадлах үйлчилгээг үнэлүүлэхдээ актуарийн алба нэгжийг татан оролцуулах шаардлагатай.

Механизм

Эрүүл мэндийн даатгалын тогтвортой санхүүжилтийн загварыг тодорхойлох нь

- Даатгалд хамрагдах боломжтой хүмүүсийн тоо, тэдний эрүүл мэндийн байдал, эрүүл мэндийн зардлын хөдөлгөөн, эпидемиологийн хүчин зүйлс, эрүүл мэндийн даатгалыг санхүүжүүлэгчдийн тоо болон шинж чанар, мөн санхүүжилтийн эх үүсвэр тус бүрээс хамааран урьдчилан тооцоолсон санхүүгийн орлогын хөдөлгөөн гэх мэт хувьсагчдад үндэслэн зарлага, орлогын хувилбаруудыг гаргаж үр нөлөө, эдийн засгийн үндэслэлийн судалгааг хэд хэдэн удаа хийнэ.
- Санхүүжилтийн эх үүсвэрийг (татвар, нийгмийн даатгалын шимтгэл, эрүүл мэндийн үйлчилгээний шууд төлбөр) эрүүл мэндийн даатгалын шинж чанар (даатгал эсвэл тусламжийн үйлчилгээ; хувиараа хөдөлмөр эрхлэгч ажилчид эсвэл ажилчид), эдийн засгийн хэтийн төлөв байдал (өсөлт, ажилгүйдлийн түвшин) болон хүн ам зүйн хэтийн төлөв зэрэг шалгуурын дагуу тодорхойлно.
- Өөр өөр хамтрагч талуудын оролцоотойгоор ил тод байдал, сайн засаглалын баталгааг хангах санхүүгийн удирдлагын нэгдсэн тогтолцоог бий болгоно.
- Дараах зүйлсэд онцгой анхаарал хандуулах шаардлагатай:

- Эрүүл мэндийн даатгалыг хэд хэдэн эх үүсвэрээс болон олон талын оролцогч талууд (гол төлөв даатгуулагчид, иргэд, аж ахуйн нэгжүүд) санхүүжүүлэх боломжтой тул олон нийтийн дэмжлэг, итгэлийг нэмэгдүүлэхийн тулд шимтгэл төлөлт шударга байх нь чухал;
- Эрүүл мэндийн даатгалын санхүүжилт нь хөдөлмөрийн зардлыг нэмэгдүүлэх замаар хөдөлмөр эрхлэлт, өрсөлдөх чадварт нөлөөлж болох тул эдийн засгийн хэлбэлзэл багатай – жишээлбэл, нийгмийн даатгалын шимтгэлийн оронд татвар – мөн орлогын бүх хэлбэрийг (хөдөлмөрийн болон санхүүгийн орлогыг оруулаад) харгалзан үзэх санхүүгийн эх үүсвэр дээр тогтож болно.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний үр ашгийг дээшлүүлэх нөөцийн хуваарилалтын аргуудыг дэмжих

- Нийтийн эрүүл мэндийн үзүүлэлтийг урьдчилан цуглуулсны дараа суурь үзүүлэлтийг бий болгох нь сайн туршлага болно. Жишээлбэл, нас баралтын түвшин, өвчлөлийн түвшин, өвчлөлийн давтамж зэргийг үүнд оруулна.
- Үүний дараа доорх зүйлсэд нөөцийг чиглүүлэх замаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээний үр ашгийг дээшлүүлэх хэд хэдэн сонголт бий:
 - Эрүүл мэндийг дэмжих, мөн өвчний үүсэл, даамжрал, үр дагавраас урьдчилан сэргийлэх, түүнийг удаашруулах. Урьдчилан сэргийлэх зардалд хөрөнгө зарснаар дунд болон урт хугацаандаа амьдралын чанарыг дээшлүүлж, төсөв бага зарцуулах хөрөнгө оруулалт болно;
 - Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний дэд бүтцийг бий болгох, шинэчлэх хөтөлбөрийг санхүүжүүлэх;
 - Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тогтолцоонд ажиллаж буй мэргэжилтнүүдийг сургах.

Удирдамж 27. Эрүүл мэндийн мэдээллийн кампанит ажил зохион байгуулах, түгээх

Нийгмийн даатгалын байгууллага нь эрүүл мэндийн мэдээллийн стратеги боловсруулж, кампанит ажил зохион байгуулна.

Эрүүл мэндийн мэдээлэл нь мэдлэг бүхий хүмүүс (ихэвчлэн тусламж үйлчилгээ үзүүлэгчид) болон өвчин эмгэг, хийгдэж буй эмчилгээ, тусламж үйлчилгээний хүртээмжийн талаар иж бүрэн мэдээлэл авах боломжгүй хүмүүсийн хоорондын тэгш бус байдлын олон хүчин зүйлээс хамаардаг.

Бүтэц

- Эрүүл мэндийн даатгалд хамрагдсанаар ашиг тусыг нь хүртэх боломжтой хүмүүст даатгалыг хүртээмжтэй болгохын тулд мэдээлэл маш чухал билээ. Тус мэдээлэл нь тусламж үйлчилгээний багцад байгаа бараа үйлчилгээний төрөл, нөхөн төлбөрийн механизм, түүнчлэн нийтийн эрүүл мэндийн талаарх ерөнхий мэдээлэлтэй холбоотой байна. Нийгмийн даатгалын байгууллагууд эрүүл мэндийн мэдээллийг мэргэжлийн түвшинд хүргэх шаардлагатай бөгөөд мэдээлэл, харилцаа холбооны мэргэжилтнүүдийн үйлчилгээ тэдэнд хэрэгтэй болж магадгүй.
- Эрүүл мэндийн мэдээллийн материалуудыг эрүүл мэндийн мэргэжилтнүүдтэй болон даатгуулагчдын төлөөлөл бүхий байгуул-лагуудтай хамтран боловсруулах ба материал нь ойлгомжтой, хүртээмжтэй байна.
- Байгууллага зорилтот бүлэгт тохиромжтой материалыг ашиглах ёстой.
- Эрүүл мэндэд үзүүлэх ашиг тус эсвэл эрсдэлийн талаарх эрүүл мэндийн боловсрол нь мөн эрүүл мэндийг дэмжих хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх стратеги болно.

Механизм

- Нийгмийн даатгалын байгууллага нь аль болохоор зорилтот бүлгийн хүн амын ихэвчлэн ашигладаг мэдээллийн эх сурвалжид тохирсон харилцааны хэрэгслийг ашиглаж мэдээлэл өгөх нь зүйтэй.
- Нийгмийн даатгалын байгууллага нь эрхийн карт, тусгай эрүүл мэндийн карт, энгийн цахим хэрэглээний зэрэг аргаар төрөл бүрийн байгууллагуудаас үзүүлж буй тусламж үйлчилгээнээс авах боломжийг таниулан сурталчлах ажлыг хөнгөвчлөх арга хэрэгслүүдийг бий болгоно.
- Байгууллага нь нөлөөлөлд өртсөн бүлгүүдэд, тэр дундаа даатгалд хамруулахад хүндрэлтэй хүмүүст зориулан мэдээлэл хүргэх кампанит ажлыг зохион байгуулах ба тэдгээр кампанит ажлуудыг иргэний холбоо, олон нийтийн байгууллагын ахлагчид, үйлдвэрчний эвлэл, хамтын сангууд зэрэг тухайн орон нутгийн оролцогчдоор дамжуулан хүргэнэ.

- Эрүүл мэндийн боловсрол нь зорилтот бүлгийнхэнд насан туршид нь, мөн амьдралын томоохон өөрчлөлтийнх нь үед (хүүхэд нас, өсвөр нас, хөдөлмөрийн нас, тэтгэврийн нас) мэдээллээр хангах зорилготой юм.
- Байгууллага нь чадавхыг бэхжүүлэх, зан үйлийн өөрчлөлтийг зохих нөхцөлд (уулзалт, хурал, сургалт) дэмжих арга хэрэгслээр хангах ёстой.

Удирдамж 28. Тодорхой зохицуулалттай төлөвлөгөөний дагуу даатгалыг хамгаалах нь

Нийгмийн даатгалын байгууллага нь зохицуулалтын үйл ажиллагааг тодорхойлох, хөтөлбөр болгон боловсруулах, хамгийн чухал нь хэрэгжүүлэх, үнэлэх ажлын арга зүйг бий болгодог. Үүний тулд үйл ажиллагааны төлөвлөгөө гаргана.

Үйл ажиллагааны төлөвлөгөөг дараах чиглэлийн дагуу зохион байгуулна. Зохицуулалтын төлөвлөгөө нь эрүүл мэндийн даатгалын үйлчилгээний тогтвортой үйл ажиллагааг хангахад туслах бүх үйл ажиллагааг нэгтгэх юм. Энэ хүрээнд хэрэгжиж буй төслүүд нь орлого, зарлага болон олон янзын оролцогчдын зан төлөвт нөлөөлөхүйц байхын зэрэгцээ технологийн хөгжлийг мөн харгалзан үзнэ. Зохицуулалтын төлөвлөгөөний зорилго нь чанар/үр ашгийн хувьд хамгийн үр дүнтэй тусламж үйлчилгээг тодорхойлох явдал байна.

Бүтэц

- Эрүүл мэндийн зохицуулалтын зорилтуудыг тодорхойлохын тулд тухайн эрүүл мэндийн тогтолцооны шинж чанар (оролцогч тус бүртэй холбоотой чиг үүрэг), түүний дотор Нийгмийн даатгалын байгууллагын хүлээж буй үүргийг (түүний бие даасан болон хамтын оролцооны талбарыг оруулаад) тодорхойлох шаардлагатай.
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нөөцийг зохицуулахын тулд эрүүл мэндийн-эдийн засгийн мэдээллийг цуглуулж (мэдээлэл цуглуулах/зардлын дүн шинжилгээ хийх, тэр дундаа хэмжээ, өвчлөлөөр), тогтолцооны бусад оролцогчдод түгээнэ.
- Зохицуулалтын үйл ажиллагаа амжилттай байх эсэх нь нэг талаас эрүүл мэндийн даатгалын үйлчилгээ үзүүлэхэд оролцож буй төрөл бүрийн оролцогч талуудын зохистой зохион байгуулалтаас хамаарна (Зураг 1-ийг харна уу).
- Зохицуулалтын төлөвлөгөө нь дараах зүйлсийг агуулсан байна:
 - Үйл ажиллагааны сэдэв/шинж чанар;
 - Хүрэх үр дүн, амжилтыг хэмжихэд хамааралтай үзүүлэлтүүд;
 - Хамаарах оролцогчид, тэдний оролцооны шинж чанар;
 - Төлөвлөх: үе шатуудыг тодорхойлох, төслийг эцэслэх хугацаа;
 - Үйл ажиллагааг хэрхэн хэрэгжүүлэх (үйл явцын дараалал/ үүрэг, холбогдох хариуцлагын хуваарилалт/үе шат, эцсийн хугацаа);
 - Шаардлагатай нөөц бололцоо (ур чадвар/экспертиз/хөрөнгө оруулалт);
 - Эрсдэлийн дүн шинжилгээ (SWOT);
 - Төслийн явцыг тухай бүрд нь эсвэл заасан хугацаанд мэдээлэх/баримтжуулах арга хэмжээ;
 - Үнэлгээ (хэн, хэзээ, яаж?)
- Үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ дараах ерөнхий зарчмуудыг баримтална.:

- Үйл ажиллагааны төлөвлөгөөний үе шат бүрийг ойлгомжтойгоор тодорхойлсон байх ёстой бөгөөд уншихад хялбар болгох үүднээс тодорхойгүй, шаардлагагүй, илүүц мэдээлэл болоод хэт ерөнхий чиглэлээс зайлсхийнэ;
- Хариуцлага: тодорхой нэг хүн үйл ажиллагааны төлөвлөгөөний үе шат тутмын хэрэгжилтийг хянаж ажиллах үүрэг хүлээх ба үйл ажиллагаа бүрийн биелэлтийг цаг тухайд нь хангаж ажиллана. Төлөөллийн хүрээ тодорхой байх хэрэгтэй;
- Нөөц бололцоо: үйл ажиллагааны үе шат бүрд захиран зарцуулах эрх бүхий боловсон хүчний, санхүүгийн болоод материаллаг нөөцийн бэлэн байдлыг хангана. Нийгмийн даатгалын байгууллага нь эдгээр асуудалд анхаарал хандуулж байх шаардлагатай.

Механизм

- Нийгмийн эрүүл мэндэд үр дүн гаргана гэдэг нь нөөц бололцоог үе шаттайгаар дайчлах шаардлага гарсан ч хамаагүй (цаг хугацааны явцад арга хэрэгсэлд суурилсан зорилтоос үр дүнд суурилсан зорилт руу шилжих) үйл ажиллагааны хамрах хүрээг олон жилээр төлөвлөнө гэсэн үг юм.
- Байгууллага нь үйл ажиллагаагаа тодорхой, бодит зорилтуудтай холбож, ил тод байдлыг үлгэрлэн харуулах замаар холбогдох оролцогчдын дэмжлэгийг авна. Иймээс төлөвлөгөө нь оролцооны нийтлэг ашиг сонирхолд тулгуурласан зөвшилцөлд үндэслэсэн байх ёстой.
- Биелүүлэх зорилтууд болон даатгалын түвшнээс хамааран зохицуулалтын төлөвлөгөөнд төрөл бүрийн арга хэрэгслийг ашиглана:
 - Төсвийн хяналт;
 - Нийлүүлэлтийн гэрээг бий болгох;
 - Эрэлтийн төлбөрийн чадвар (жишээлбэл, эрсдэлийн санхүүжилтийг нэгтгэх замаар);
 - Зардал, эрүүл мэндийн интервенцийн санхүүгийн зохицуулалт;
 - Тусламж үйлчилгээний чанар, хамаарал, дараалал эсвэл цогц үйлчилгээтэй холбоотой санхүүжилт;
 - Эрүүл мэндийг бэхжүүлэх: өвчтөнүүдийг өөрсдийн авах тусламж үйлчилгээний тал дээр идэвхтэй оролцогч байхад нь дэмжлэг болох мэдээллээр хангах, сургах, өөрсдийн хэрэгцээгээ тодорхойлж, хэрэгцээ нь хангагдаж байгаа эсэх дээр хяналт тавих, асуудлыг шийдвэрлэх, нөөц бололцоогоо дайчлах чадварыг нэмэгдүүлнэ. Өвчтөнүүд өөрт хамаарах эмчилгээний шийдвэрийг гаргахад тодорхой үүрэг гүйцэтгэж өөрсдийн амьдралдаа илүү хяналт тавьдаг болно.
- Зохицуулалтын төлөвлөгөө нь үйл ажиллагаагаа тодорхойлох, үе шаттай болгох, зорилт тавих, гүйцэтгэлийг хэмжих (үр дүн ба ашиглагдсан нөөц) зэрэг албан ёсны үйл явцын нэгээхэн хэсгийг төлөөлдөг бөгөөд төлөвлөгөөний бүх хэсгийг тогтмол хуваалцаж, мэдээлж байх ёстой.

Удирдамж 29. Эрүүл мэндийн бүтээгдэхүүний салбарт эрүүл мэндийн аюулгүй байдлыг сайжруулах

Нийгмийн даатгалын байгууллага нь өвчтөний нийлүүлэлтийн сүлжээний бүх түвшинд хяналтын арга хэмжээг авч, өөрт байгаа мэдээлэлд дүн шинжилгээ хийснээр эрүүл мэндийн бүтээгдэхүүний эрүүл мэндийн аюулгүй байдлыг сайжруулахад хувь нэмэр оруулна.

Санаатай эсвэл санамсаргүй байдлаар эрүүл мэндийн бүтээгдэхүүнийг зүй бусаар ашиглах нь маш аюултай байдаг. Эрүүл мэндийн аюулгүй байдлыг хангах нь эмийн зохицуулалтын бодлогын гол чиглэл байсаар ирсэн.

Бүтэц

- Эрүүл мэндийг хамгаалах нь дараах зүйлс дээр суурилна:
 - Бүтээгдэхүүний баталгаатай байдлыг нотлох чадвар (нийлүүлэлтийн талаарх 31-р удирдамжийг үзнэ үү);
 - Зохистой хадгалалт;
 - Оновчтой эмийн жор, олголт;
 - Өвчтөний зохистой хэрэглээ;
 - Эрсдэл ба үр ашгийн зохистой харьцаа бүхий эмнэл зүйн үр дүнгийн үнэлгээ;
 - Эмийн хяналтын тайлангийн дүн шинжилгээ.
- Аюулгүй байдлын хамгаалалт нь эрүүл мэндийн бүтээгдэхүүн хөгжүүлэх, үйлдвэрлэх олон улсын стандарт, нэг буюу хэд хэдэн эрүүл мэндийн байгууллагын оролцоо, эрүүл мэндийн мэргэжилтнүүдийг бэлтгэх, эрүүл мэндийн бүтээгдэхүүний хуваарилалтыг тодорхой мэргэжилтнүүдийн хүрээнд хязгаарлах эрх мэдлийн монопол: эм зүйч, ургамал судлаач, эмч.

Механизм

- Төлбөр төлөгч этгээдүүд нь зөвхөн эрх бүхий байгууллагаас зах зээлд нэвтрүүлэх эрх олгосон эрүүл мэндийн бүтээгдэхүүнүүдийг худалдаж авна. Үүнд бүтээгдэхүүний найрлага, эмчилгээний заалтуудын талаарх ил тод байдал, түүний эрсдэл ба үр ашгийн харьцааг эмнэлзүйн туршилтаар эсвэл зөвшөөрөгдөх нотолгоонд үндэслэн (уламжлалт анагаах ухаанд удаан хугацаагаар ашиглагдсан гэх мэт) зэргийг хамааруулдаг.
- Хэрэв төлбөр төлөгч этгээдүүд эрүүл мэндийн бүтээгдэхүүний үнийг тогтоох үүрэгтэй бол нийлүүлэлтийн сүлжээний чанарыг (жишээлбэл, хадгалах температурыг дагаж мөрдөх) хангах арга хэмжээний хэрэгжилттэй талуудын үнэ өртгийн зөрүү нь хэр зэрэг нийцэж буй эсэхийг баталгаажуулна.
- Төлбөр төлөгч этгээдүүд нь эрүүл мэндийн бүтээгдэхүүний жор бичиж өгөх, олгохтой холбоотой үүргээ мэргэжлийн хүмүүс хэрхэн биелүүлж байгааг хянах тогтолцоог бий болгоно. Эдгээр үүргүүдэд дараах зүйлс хамаарна:

- Нөхөн төлбөр олгодог бүтээгдэхүүний эмчилгээний заалтууд;
- Оновчтой жор бичих дадал;
- Патент бүхий өндөр өртөгтэй эмийг ерөнхий нэршлийн эмээр солих;
- Борлуулалтын дижитал хэлбэрт шилжих;
- Операторын сургалт;
- Бүтээгдэхүүний хадгалалт, байрны чанарын стандартууд.
- Мэргэжилтнүүдийн биелэлтийг хянах үр дүнтэй системийг бий болгохын тулд төлбөр төлөгч этгээдүүд нь хяналтын мэргэшсэн мэргэжилтнүүдийг ашиглаж үйл явцыг дижитал хэлбэрт шилжүүлэхэд шаардлагатай санхүүгийн тусламжийг олгох юм.
- Төлбөр төлөгч этгээдүүд нь зөвхөн үйл явцын чанар, хангамжийн аюулгүй байдлыг хангасан эрх бүхий түгээлтийн сүлжээгээр дамжуулан нийлүүлсэн эмийн төлбөрийг төлөх ёстой.
- Төлбөр төлөгч этгээдүүд нь зөвхөн эмчийн (эсвэл бусад жор олгогчийн бичсэн) бичсэн жорын дагуу эмийг олгох системийг тогтоож болно. Энэ нь өвчтөнүүд эмчилгээнд нь шаардлагатай нарийн тоо хэмжээ бүхий эмийг л авна гэсэн үг юм. Ингэснээр өвчтөнүүдийн гэрт ашиглагдаагүй эмийн үлдэгдлүүд хадгалагдах явдлыг хязгаарлаж байгаа боловч эм тарианы эргэлтэд төөрөгдөл, алдаа гарах, хуурамч эм нэвтрэх (үйлдвэрлэгчийн анхдагч аюулгүйн сав баглаа боодлыг задалснаар) эрсдэлийг нэмэгдүүлдэг.
- Төлбөр төлөгч этгээдүүд нь эмийн хяналтын тогтолцоог явуулахад хувь нэмрээ оруулж чадна. Эмийн хяналтын үндэсний систем болон олон улсын тайлангаар дамжуулан гаж нөлөөний талаар тэдэнд мэдээлэх шаардлагатай.
- Төлбөр төлөгч этгээдүүд тодорхой бүтээгдэхүүн эсвэл үйлдвэрлэлийн багц дугаартай холбоотой аюулгүй байдлын асуудал илэрсэн тохиолдолд өвчтөнд мэдээлэх боломжтой байхын тулд зах зээлд нэвтрүүлсэн бүтээгдэхүүнийг хөөж олох боломж бүхий системийг бий болгож болно.
- Төлбөр төлөгч этгээдүүд эрүүл мэндийн бүтээгдэхүүний зохисгүй хэрэглээний эрсдэлийн (нөлөө буурах, хэтрүүлэн хэрэглэх аюул, хүүхэд залгих эрсдэл гэх мэт) талаар олон нийтийн мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх боломжтой.
- Төлбөр төлөгч этгээдүүд ашиглаагүй эсвэл хугацаа нь дууссан эмийг цуглуулах системийг бий болгож болно.

Удирдамж 30. Эрүүл мэндийн бүтээгдэхүүний зардлыг зохицуулах, хэрэглээг чанаржуулах

Нийгмийн даатгалын байгууллага нь бүтээгдэхүүний эрүүл мэндэд хэр ач холбогдолтойг үнэлэх, үнийг зохицуулах, зохистой хэрэглээг сурталчлах зэрэг аргаар эрүүл мэндийн бүтээгдэхүүний зардлыг зохицуулах, тэдгээрийн хэрэглээг чанаржуулахад тусалдаг.

Эрүүл мэндийн бүтээгдэхүүн нь эрүүл мэндийн зардлын болон шууд ашиглах боломжтой арга хэрэгслүүдийн томоохон хувийг эзэлдэг учир эдгээр арга хэмжээ чухал байдаг. Эмчилгээний хүртээмж, санхүүгийн тогтвортой байдал, түгээлтийн сувгийн төлбөр (энэ нь эрүүл мэндийн аюулгүй байдал, нийлүүлэлтийг хамгаалах боломж олгодог - Удирдамж 29, 31-ийг үзнэ үү), инновацыг дэмжих, түүнчлэн хамаарал бүхий үндэсний үйлдвэрлэл зэрэг хэд хэдэн бодлогуудыг нийцүүлэх шаардлагатай учир тус зардлыг зохицуулах нарийн төвөгтэй байдаг.

Бүтэц

- Зардлын зохицуулалт нь хэд хэдэн чиглэлийг агуулж болно.:
 - Үнэ болон нөхөн төлбөрийн түвшинд тэдгээрийн зохицуулалтаар дамжуулан шууд арга хэмжээ авах;
 - Эмийн жорын чанар байдлаар дамжуулан түүний хэмжээнд зохицуулалт хийх;
 - Салбаруудад татвар ногдуулах замаар шууд бус арга хэмжээ авах мөн/эсвэл инновац, аж үйлдвэрийн хөгжлийг дэмжих арга хэмжээ.
- Эрүүл мэндийн бүтээгдэхүүний салбарын эдийн засгийн зохицуулалт нь төрийн байгууллагуудын хооронд санал зөрөлдөхөд хүргэж болзошгүйг цохон тэмдэглэх нь зүйтэй: эрүүл мэндийн салбар зардлаа бууруулах хүсэлтэй байж болох бол аж үйлдвэрийг хариуцсан яам газраас тус зардлыг инновац, экспорт, өндөр ур чадвартай ажлын байрыг дэмжиж буй явдал гэж үзэж болно. Стратегийн бие даасан байдлын тухай асуудал, өөрөөр хэлбэл зайлшгүй шаардлагатай гэж үзсэн эрүүл мэндийн бүтээгдэхүүнийг бие даан үйлдвэрлэх чадавх нь энэ салбарыг хэрхэн зохицуулахад нөлөөлдөг.
- Үйл ажиллагааны хувьд зохицуулалт нь төлбөр төлөгч этгээд ба/эсвэл улсын ашиг сонирхлыг, түүнчлэн эмч нарын эмчилгээний протоколын биелүүлэлтийг (жорыг чөлөөтэй олгох үзэл санааны эсрэг байж болзошгүй), өвчтөнүүдийн эмчилгээг чанд баримтлан сахих байдлыг (нийцэл болон зохисгүй хэрэглээтэй тэмцэх) хүний оролцоо бүхий эсвэл дижитал арга замыг хамгаалах зорилгоор үйлдвэрлэгчидтэй тэгш байдлаар хэлэлцээр хийх шаардлага үүсгэдэг.
- Эцэст нь, эрүүл мэндийн бүтээгдэхүүний зардал хэдий өндөр байж болох ч тэдгээрийг зохисгүй хэрэглээний үр дагавар, зардлыг харгалзан үзэх нь чухал юм. Энэ нь системийн ерөнхий үр ашгийг дээшлүүлэх зохицуулалтын арга хэмжээ шаардлагатай гэдгийг бүрэн нотолж байна.

Механизм

- Төлбөр төлөгч этгээдүүд эрүүл мэндийн бүтээгдэхүүний салбарын үйл ажиллагааг дурдахдаа олон улсын нэр томъёог ашиглах ёстой:
 - Мэдээллийн систем дэх бүтээгдэхүүнүүдээ Олон Улсын Өмчийн Бус Нэр (INN)-ээр;
 - Зах зээлийн дүн шинжилгээ болон олон улсын хэмжээнд мэдээлэл солилцохдоо АТС ангиллыг ашиглана. (АТС гэдэг нь Анатомийн Эмчилгээний Химийн ангиллын систем гэсэн үг юм. Зориулалт бүхий эрхтэн, эмчилгээний шинж чанар, фармакологийн үйл ажиллагааны механизм, химийн ангиллыг харгалзан молекул бүрд өвөрмөц таван түвшний кодыг өгдөг.)
- Төлбөр төлөгч этгээдүүд нь эмчилгээний, нийгмийн эрүүл мэнд болон ёс зүйн шалгуурт үндэслэн нөхөн төлбөр бүхий эрүүл мэндийн бүтээгдэхүүний “сагс”-ыг тодорхойлно. Өвчний хүндрэлийн зэрэг, үр нөлөө, өртөг зэрэг шалгуурыг харгалзан үзсэний үндсэн дээр нөхөн төлбөр авах өөр өөр нөхцөл (жишээлбэл, урьдчилан тохиролцсоны дагуу), мөн тухайн нөхөн төлбөрийн хувь хэмжээ (энэ тохиолдолд нөхөн төлбөрийн хувь хэмжээ хэд хэд байдаг) болон хамаарах хугацааг (даатгалын хугацаа) тогтоох боломжтой.
- Зохицуулалтын үйл ажиллагаагаар өвчтөн бүрийг хамгийн сайн эмчилгээ авах нөхцөлийг дэмжих ёстой. Төлбөр төлөгч этгээдүүд нь эрүүл мэндийн мэргэжилтэн болон түүний өвчтөн хоорондын харилцаанд шууд хөндлөнгөөс оролцох ёсгүй.
- Төлбөр төлөгч этгээдүүд эрүүл мэндийн бүтээгдэхүүний үнийг тогтоох үүрэгтэй байж болно. Хэрэв тийм бол энэ үйл явцыг эмнэлзүйн туршилтын үр дүн, хэрэв байгаа тохиолдолд анагаах ухаан-эдийн засгийн судалгааны үр дүнд үндэслэх ёстой. Хэлэлцээрийн журам байгаа бол энэ нь ил тод, төлбөр төлөгч байгууллага болон үйлдвэрлэгчийн хооронд эсрэгцэл үүсэх боломжтой байх ёстой бөгөөд гуравдагч этгээдээр шүүн таслуулахуйц байна. Тогтоосон үнэ нь өвчтөнд хүртээмжтэй байхаас гадна нийлүүлэгч болон түгээлтийн сувгийн эдийн засгийн үр ашгийг хангах ёстой.
- Эрүүл мэндийн бүтээгдэхүүний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор төлбөр төлөгч байгууллагууд өвчтөнд учирч буй санхүүгийн бэрхшээлийг хөнгөвчлөхийн тулд гуравдагч талын төлбөрийн системийг бий болгож болно. Тэд мөн жорын эмтэй дүйцэхүйц, гэхдээ хямд үнэтэй ерөнхий нэршлийн эмийг сонгох талаар түлхэц үзүүлж болно.
- Төлбөр төлөгч этгээдүүд эрүүл мэндийн бүтээгдэхүүний зохистой хэрэглээг сурталчлахад хувь нэмрээ оруулах шаардлагатай. Үүний тулд хөгжүүлсэн хөтөлбөрүүд нь хамгийн сүүлийн үеийн мэдлэгт болон шинжлэх ухааны зөвшилцөлд суурилсан, ил тод нөхцөлд боловсруулагдсан байх ёстой. Энэ чиглэлийн үйл ажиллагаа нь үр ашигтай байдал (хамгийн ашигтай эсвэл хамгийн бага өртөгтэй эмчилгээг бичиж өгөх), ерөнхий нэршлийн эмийн хэрэглээг дэмжих, чанарын дутагдлыг арилгах (давхардсан жор, тохиромжгүй эмчилгээний сонголт), мөн/эсвэл өвчтөнүүдийг эмчилгээгээ чандлан дагахад туслах зорилготой байж болно.

Удирдамж 31. Эрүүл мэндийн бүтээгдэхүүний нийлүүлэлтийг баталгаажуулахад туслах

Нийгмийн даатгалын байгууллага нь эмчилгээг цаг алдалгүй ойроос авах, үр дүнтэй, хуурамч бус эмийн хүртээмжийг хангахын тулд эрүүл мэндийн бүтээгдэхүүний нийлүүлэлтийг баталгаажуулахад үүрэг гүйцэтгэдэг.

Бүтэц

- Эрүүл мэндийн бүтээгдэхүүний нийлүүлэлтийг найдвартай болгоход эм үйлдвэрлэлээс эхлээд өвчтөнд хүргэх хүртэлх бүх оролцогч талыг хамардаг.
- Баталгаатай бүтээгдэхүүнийг хадгалалтынх нь шинж чанарт болон өвчтөний хэрэгцээнд (архаг өвчлөлд зориулсан тасралтгүй нийлүүлэлт эсвэл ховор, цочмог өвчний үеийн шуурхай хэрэгцээ) тохирсон нөхцөл, хугацаанд хадгалах, тээвэрлэх шаардлагатай.

Механизм

- Төлбөр төлөгч этгээдүүд үнэ тогтоох болон/эсвэл тухайн бүтээгдэхүүнийг тусламж үйлчилгээний багцад оруулах замаар үндэсний эрүүл мэндийн салбарын үйлдвэрлэлийн сүлжээг дэмжихэд хувь нэмрээ оруулах боломжтой. Түүхий эдийн нийлүүлэлтийн сүлжээг баталгаатай болгох нь ихэвчлэн төрийн үүрэг байдаг.
- Төлбөр төлөгч этгээдүүд нь хомсдол үүссэн тохиолдолд улс орныг хэдэн сарын турш хэвийн хэрэглээний түвшинд байлгах боломжтой үндэсний нөөцийн хэмжээг тусламж үйлчилгээний багцын нэг хэсэг болгон нөхөн төлбөр авах нөхцөлөөр тогтоож болно.
- Төлбөр төлөгч этгээдүүд нь нийлүүлэлтийн хомсдол үүссэн тохиолдолд орлох эмчилгээний аргыг тодорхойлох, хувьцаа арилжих зорилгоор гадны байгууллагатай холбоо тогтоон ажиллаж болно.
- Төлбөр төлөгч этгээдүүд эрүүл мэндийн бараа бүтээгдэхүүний баглаа боодлыг хамгаалалтын системтэй байлгах шаардлага тавьж түгээлтийн сувгийг бүхэлд нь баталгаажуулах төхөөрөмжөөр хангахад хувь нэмэр оруулах ёстой.
- Төлбөр төлөгч этгээдүүд нь эрүүл мэндийн бүтээгдэхүүнүүдийг эргүүлэн мөшгөж олох боломжтой байхад анхаарна.
- Төлбөр төлөгч этгээдүүд нь хадгалалтын чанар, хяналтын шаардлагыг хангахуйц санхүүжилтийг нийлүүлэлтийн сүлжээний оролцогч бүрд олгоно. Тэд түгээгчдийн дунд үнэ унагаах үзэгдэлтэй тэмцэх шаардлагатай ба уг үзэгдэл нь заримд нь эдийн засгийн хүндрэл учруулж, ажлаа найдвартай гүйцэтгэхэд нь саад болох тал байдаг.
- Төлбөр төлөгч этгээдүүд хуурамч барааг илрүүлэх, хууль бус наймаатай тэмцэх үүрэгтэй хууль сахиулах байгууллагуудтай мэдээллээ хуваалцана.
- Төлбөр төлөгч этгээдүүд итгэмжлэгдсэн түгээлтийн байршлуудыг (эмийн сан, онлайн борлуулагч гэх мэт биет байгууллагууд) тодорхойлох эсвэл түгээлтийн үйл ажиллагааг өөрсдөө зохицуулна.

- Төлбөр төлөгч этгээдүүд ханган нийлүүлэлтийн сүлжээний оролцогчдыг стандартын дагуу ажиллаж байгаа эсэхийг хянуулахаар байцаагчдыг ажиллуулна.
- Төлбөр төлөгч этгээдүүд эрүүл мэндийн мэргэжилтнүүдэд хомсдолын талаар мэдээлэх, хангамжийн системийн аюулгүй байдлыг үнэлүүлэх (жишээлбэл, эрүүл мэндийн байгууллага доторх эмийн эргэлтийг баталгаажуулах) хүсэлт тавих боломжийг олгох механизмыг бий болгоход туслах ёстой.

Удирдамж 32. Архаг, хүнд өвчнөөс сэргийлэх, урьдчилан сэргийлэх үзлэгийг дэмжих замаар хувь хүний эрүүл мэндийг сайжруулах

Нийгмийн даатгалын байгууллага нь эрүүл мэндийн даатгалыг зохицуулахад зайлшгүй шаардлагатай арга хэрэгсэл болгон урьдчилан сэргийлэлт, эрүүл мэндийн боловсролын бодлогыг сайжруулна.

Нийгмийн даатгалын байгууллага нь иргэдийг мэдээллээр хангаж, илүү хариуцлагатай байх талаар нь дэмжсэнээр өөрсдийнхөө эрүүл мэндэд анхаарахад идэвхтэй оролцогч байхад нь туслах байдлаар урт хугацаандаа эрүүл мэндийн асуудалтай болох, даамжруулахаас нь сэргийлэх боломжийг олгоно.

Бүтэц

- Эрүүл мэндийн даатгалын шинэ журам эсвэл нэмэлт өөрчлөлт нь анхдагч, хоёр эсвэл гуравдагч шатлалын салбарын идэвхтэй бодлогын хамт дагалдана. COVID-19 тахал нь архаг эсвэл халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, дэмжих арга хэмжээ хэр чухал болохыг харуулсан бөгөөд тодорхой арга хэрэгслээр өвчлөл, хүндрэлийг бууруулах боломжтой юм. Өвчтөнүүдийн хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулах, дахин нэгтгэхэд туслахуйц нөхөн сэргээх явцыг мөн дэмжих шаардлагатай.
- Урьдчилан сэргийлэх бодлого нь дангаараа байх бус, харин эрүүл мэндийн дэд бүтэц, тусламж үйлчилгээний санхүүгийн болон боловсон хүчний хөрөнгө оруулалтын нэг хэсэг байна.
- Урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгох арга хэрэгсэл нь олон төрлийн ур чадварыг (харилцаа холбоо, үнэлгээ, чиглүүлэг гэх мэт) шаарддаг бөгөөд эдгээрийг зорилтот бүлгүүдэд аль болох ойртуулж, олон нийтийн сүлжээг дайчлан, хүрэх зорилтууд болон өнөөг хүртэл хүрсэн үр дүнд нийцүүлэхийн тулд техникийн хувьд байнга дасан зохицож байх ёстой.
- Эрүүл мэндийг дэмжих үйл явц нь эрүүл мэндийн байдлаас үл хамааран нийт хүн амд эрүүл мэндийн талаар мэдээлэл, зөвлөгөөг түгээх замаар хамтын буюу бүх нийтийн хэмжээний урьдчилан сэргийлэх зарчим, түүнчлэн тодорхой эрсдэлд өртөж буй бүлэг хүмүүст чиглэн сонгосон, эсвэл хувь хүнд чиглэсэн тусгай урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд тулгуурлана.
- Урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг орон нутгийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдээр дамжуулан хүргэнэ.
- Тусгайлан боловсруулсан боловсролын хөтөлбөрөөс үр ашиг хүртэхийн тулд хамгийн түгээмэл халдварт бус архаг өвчинд (чихрийн шижин, амьсгалын замын өвчин, цусны даралт ихдэлт гэх мэт) онцгой анхаарал хандуулж, эрсдэлт хүчин зүйлсийг эрэмбэлж (хөдөлгөөний дутагдал, эрүүл бус хооллолт, тамхины хэрэглээ гэх мэт), эрүүл мэндийн тэгш бус байдлыг бууруулахад дэмжлэг үзүүлнэ.
- Нийгмийн даатгалын байгууллага нь эрүүл мэндийн салбарын бүх оролцогчдыг нэгтгэсэн цогц стратеги боловсруулахын тулд улсын хэмжээний нийт оролцогчидтой (ялангуяа байгаль орчин, ажил хөдөлмөр, боловсрол) нягт хамтарч ажиллана.

Механизм

- Байгууллага нь мэдэгдэж буй өвчний тархвар судлалын өгөгдөлд (нас баралт, өвчлөл, тархалт, зардал гэх мэт) үндэслэн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг тодорхойлно.
- Архаг өвчтэй хүн бүр тодорхой, шинжлэх ухааны үндэслэлтэй эмчилгээний талаарх боловсролын хөтөлбөрт хамрагдах боломжтой байна.
- Нийгмийн даатгалын байгууллага нь мэдээлэл дамжуулахдаа олон орны туршлагаар үр дүн нь нотлогдсон олон нийтийн сүлжээг дайчлах замаар хамруулахад хүндрэлтэй бүлгүүдэд эрүүл мэндийн сайн туршлагыг сурталчлах боломжтой байна.
- Стратеги боловсруулах, урьдчилан сэргийлэлтийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, тэдгээрийн үр нөлөөг үнэлэх, хамтын зорилгод нийцүүлэн ашиг-эрсдэлийн тэнцвэрийг байнга нийцүүлэхийн тулд Нийгмийн даатгалын байгууллага доторх эсвэл түншлэлээр дамжуулан олон төрлийн ур чадварыг дайчлах нь чухал.
- Эрүүл мэндийн харилцааны стратегийг зохих хэмжээнд хүлээн зөвшөөрүүлэхийн тулд олон нийтийг эсвэл тэдний төлөөллийг оролцуулна.
- Нийгмийн даатгалын байгууллага нь хүн амын тодорхой бүлэг эсвэл бүс нутагтай холбоо тогтоохдоо МХХТ-ийн хэрэгслийг ашиглах боломжтой байхын зэрэгцээ цахим хуваагдлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллах ёстой.
- Урьдчилан сэргийлэлт, эрүүл мэндийн боловсролын бодлогыг нэвтрүүлэх зохицуулалтын төлөвлөгөөг найдвартай, тогтвортой үзүүлэлтээр жишиж үнэлнэ.
- Нийгмийн даатгалын байгууллага нь урьдчилан сэргийлэх тодорхой үйл ажиллагаатай зэрэгцэн урамшууллыг хэрэгжүүлэх ёстой:
 - Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний дэд бүтэц, оролцогчдод зориулсан зорилтот санхүүжилт;
 - Нийгмийн даатгалын байгууллага ба түүний хэрэглэгчид хоорондын гэрээгээр урьдчилан сэргийлэг, илрүүлэг, эрүүл мэндийн боловсролд олгох урамшуулал (нөхцөлт тэтгэмж, нөхцөлд хамаарах үйл ажиллагаа гэх мэт).
- Нийгмийн даатгалын байгууллага нь урьдчилан сэргийлэх болон эрүүл мэндийн боловсрол олгох хөтөлбөрүүдийг олон нийтэд нэвтрүүлэхээсээ өмнө эрсдэл өндөртэй буюу тэгш бус нөхцөл байдалтай нүүр тулсан хүн амыг харгалзан үзэж, зорилтот бүлэг эсвэл тодорхой бүс нутгийн хэмжээнд туршиж үзэх нь тустай байж болно.

С. “ОРХИГДСОН ДУНДАЖ”-ИЙГ ХАМРУУЛАХ НЬ

Албан бус эдийн засагт ажиллагчдыг нийгмийн даатгалд хамруулах нь нүсэр бөгөөд хүнд сорилт юм. Зарим улс орон энэхүү урт хугацааны даатгалын цоорхойн талаар шаардлагатай арга хэмжээг авч байгаа ч албан бус эдийн засагт ажиллагчдын тоо тасралтгүй өссөөр байгаа нь энэ асуудлыг яаралтай авч үзэх шаардлагыг бий болгож байна.

Албан бус эдийн засаг дахь нэн ядуу ажиллагчдад зориулсан нийгмийн халамжийн хөтөлбөрүүд байдаг ч ажлынхаа үр шимээр “ядууралд” өртөөгүй учир хамрагдахгүй хүмүүс байдаг. Хэдий тийм ч тэд энгийн хөтөлбөрт шимтгэл төлөх хангалттай орлого олдоггүй. Тэдний нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамрагдах хязгаарлагдмал боломж, захиргааны нарийн төвөгтэй байдал нь албан салбарын ажиллагчид болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд зориулсан шимтгэлийн энгийн хөтөлбөрт хамрагдахад саад болдог.

Албан бус эдийн засагт ажиллаж байгаа эдгээр ажиллагчдыг нэн ядуу биш, гэвч хангалттай орлого олдоггүй “орхигдсон дундаж” хэмээн нэрийддэг. Эдгээрт орлого багатай хувиараа хөдөлмөр эрхлэгчид, барилгын энгийн ажилчид эсвэл ажлын байрны хүнд нөхцөлд бага цалин хөлсөөр олон цагаар ажилладаг ажилчид, ур чадвар муутай цагаач ажилчид, хөдөө орон нутгийн ажилчид, захын худалдаачид гэх мэт бичил бизнес эрхлэгчид багтдаг. Ялангуяа ажиллах хүчний дийлэнх хувийг нь албан бус эдийн засаг эзэлдэг улс орнуудад “орхигдсон дундаж” гэгддэг хүн амын томоохон бүлэг нийгмийн хамгааллын тогтолцооноос хасагдаж байгаа нь тухайн улс орны ядуурлын түвшин өсөх эрсдэлийг улам бүр нэмэгдүүлж байна.

Нийгмийн хамгааллын хамрах хүрээг нэмэгдүүлэх захиргааны шийдлүүдийн талаарх ОУНХХ-ны удирдамжийн энэ хэсэг нь “орхигдсон дундаж”-ийг хамруулах нийгмийн даатгалын хамрах хүрээг хэрхэн нэмэгдүүлэх талаар зөвлөмжийг өгөх юм. Энэ нь уг эмзэг бүлгийг даатгалд хамруулах чиглэлээр ахиц дэвшил гаргасан улс орнуудын туршлагаас, тэр дундаа албан бусаар ажиллаж байгаа ажиллагчдын амьжиргааны эх үүсвэр, бизнесийг албан ёсны болгох санаачилгуудад тулгуурласан болно. Захиргааны үйл явцыг хялбарчлах, шимтгэлийг татаасжуулах, мэдээлэл, харилцааны тохирсон, тусгай аргачлал бий болгох нь хамруулахад хэцүү тэрхүү бүлгийг нийгмийн хамгаалалд хамруулахад амжилт олох чухал хүчин зүйл болох юм. Татварын алба зэрэг бусад төрийн байгууллагуудтай уялдаа холбоотой ажиллах нь “Орхигдсон дундаж”-ийг бүртгэлжүүлэх, тодорхойлох, албан салбарт шилжүүлэх, нэг цонхны үйлчилгээ үзүүлэхэд чухал ач холбогдолтой байна.

Улс орны онцлог, бүс нутгийн өвөрмөц байдлыг харгалзан үзэж, орхигдсон дунджийг хамруулах стратегийг тухайн улсын нийгмийн хамгааллын тогтолцооны хүрээнд тодорхойлдог. Албан бусаар ажиллаж байгаа ажиллагчдыг нийгмийн халамжийн тогтолцооноос шимтгэл төлөх тогтолцоо руу шилжих үйл явцыг хөнгөвчлөх хөтөлбөртэй байх, мөн эдгээр хөтөлбөрүүдийн санхүүжилт, тогтвортой байдлыг дэмжих нь гол хүчин зүйл юм. Эдгээр стратегиудад үндэсний дэмжлэг зайлшгүй шаардлагатай.

Удирдамж 33. Хамруулах хүн амын бүлгийг тодорхойлох

Нийгмийн даатгалын байгууллага нь хамрах хүрээг өргөтгөх стратегийн төвд байх хүн амын үндсэн шинжийг тодорхойлдог.

Хамруулах хүн амын бүлгийг тодорхойлох нь албан бус эдийн засагт ажиллаж байгаа хүн амын бүлгийг, ялангуяа орхигдсон дундаж хэсгийг үр дүнтэй хамруулах зорилгоор хамрах хүрээг өргөтгөх стратеги боловсруулах, нийгмийн даатгалын тогтолцоо, хөтөлбөрийн үндсэн шинж чанарыг тодорхойлох эхний алхам юм.

Бүтэц

- Удирдлага нь нийгмийн хамгааллын ерөнхий хамрах хүрээний зорилтуудыг болон одоо хэрэгжиж буй тогтолцоо болон хөтөлбөрт хамрагдаагүй бүлгүүдийн урьдчилсан байдлаарх тодорхойлолтыг харгалзан үзэж “орхигдсон дундаж”-ид хамаарах хүн амын бүлгийн шинж чанарыг тодорхойлно.
- Удирдлага нь хамруулах хүн амын шинж чанарыг тодорхойлоход туслах нийгэм, эдийн засгийн суурь үзүүлэлтүүдийг цуглуулна.
- Удирдлага нь Нийгмийн даатгалын байгууллага болон бусад байгууллагуудын мэдээллийн санг ашиглан хамруулах хүн амын шинж чанарыг тодорхойлохдоо бэлэн байгаа мэдээллийг ашиглах, шаардлагатай гэрээ хэлэлцээрийг байгуулах ёстой.
- Удирдлага нь Зорилтот бүлгийг тогтоох тогтолцоог бий болгох 9-р удирдамжийн зөвлөмжүүдийг ашиглан хувь хүмүүсийг тодорхойлох үр дүнтэй механизмыг ашиглана.

Механизм

- Хамруулах зорилтот хүн амыг тодорхойлохын тулд удирдлага нь албан бус эдийн засгийн үйл ажиллагааны төрөл, албан бус байдлын түвшин, хамаарах хүн амын тооцоолол, тэдний нас, газарзүйн тархалт, тэдний орлогын тооцоололд анхаарлаа хандуулж, албан бус эдийн засгийн талаарх мэдээллийг цуглуулна.
- Хүн амыг зохих байдлаар тодорхойлохын тулд хамгийн багадаа гэхэд дараах мэдээллүүдийг цуглуулах шаардлагатай:
 - Орлогын түвшин;
 - Хөгжиж бий болсон эдийн засгийн үйл ажиллагааны төрөл, эдийн засгийн салбарууд;
 - Урт хугацааны даатгалын стратегид жендерийн асуудлыг тусгахад зайлшгүй шаардлагатай байдаг тул тухайн хүн амыг нас, хүйсийн хуваарилалт;
 - Тодорхойлсон бүс нутаг дахь газарзүйн тархалт, онцлог;
 - Орон сууц, төрийн үйлчилгээний хүртээмж зэрэг орчны хүчин зүйлс;
 - Өрх бүхий бүлгүүдийн бүрэлдэхүүн;

- Зөвхөн орлого ологч хүний төдийгүй түүний эцэг эх, хүүхдүүдийн боловсролын түвшин.
- Удирдлага нь улс орны хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, түгээмэл хүнсний хэрэглээний сагсны үнэ, зохистой аж төрөхөд шаардлагатай үндсэн үйлчилгээний өртөг болон албан бус эдийн засагт ажиллаж буй хүн амын шинж чанарыг илүү сайн тодорхойлох боломж олгох бусад мэдээлэл зэрэг нийгэм-эдийн засгийн лавлагаа утгуудыг судална.
- Удирдлага нь суурь мэдээллийг тогтмол хянах, шинэ параметруудийг нэмж оруулах тогтолцоог бүрдүүлэх ёстой. Энэ нь хамруулах хүн амын дунд гарч болох өөрчлөлтийг хянах боломжийг олгоно. Эдгээр мэдээллүүдийг удирдах үүрэгтэй байгууллагуудтай зөвшилцөлд хүрэх нь тэдний тус ажлыг биелүүлэх үүрэг даалгаварт хувь нэмэр оруулна.

Удирдамж 34. Нийгмийн хамгааллын тэтгэмжийн бүртгэлийг бий болгох

Нийгмийн даатгалын байгууллага нь одоо байгаа үйлчилгээ, хөтөлбөрүүдээр олгож буй нийгмийн хамгааллын тэтгэмжийн бүртгэлийг бий болгоно. Тодруулбал, үүнд үндсэн нийгмийн хамгааллын суурь түвшинд олгогддог нийгмийн халамжийн тэтгэмж болон шимтгэлийн жишиг тогтолцооны тэтгэмж зэргийг багтаана.

Одоогийн байгаа үйлчилгээнүүдийн тэтгэмжийг бүртгэх нь шинэ үйлчилгээнүүдийг болон тэдгээрийн тэтгэмжийг тогтооход чухал өгөгдөл болдог. Ингэснээр шимтгэлийн болон нийгмийн халамжийн үйлчилгээгээр олгогдож буй тэтгэмжүүдийн хоорондын ялгааг тодорхойлох боломжтой болно.

Бүтэц

- Удирдлагаас “орхигдсон дундаж”-ийг хамруулах тогтолцоо эсвэл үйлчилгээг бүрдүүлэх тэтгэмжийг тодорхойлох урьдчилсан арга хэмжээ болгож одоогийн байгаа тогтолцоо, нийгмийн хөтөлбөрүүдээс олгогддог тэтгэмжийн бүртгэлийг бий болгох, хөтлөх талаар хариуцах газруудад зааварчилгаа олгоно:
 - Зорилго нь одоо байгаа нийгмийн хамгааллын суурь түвшин, тэдгээрийн тэтгэмж, хожмын шимтгэлийг тодорхойлох явдал юм. Энэ нь нийгмийн хамгааллын даатгалыг өргөжүүлэх илүү үр дүнтэй загваруудыг тодорхойлох боломжийг олгоно;
 - Энэ мэдээлэл нь суурь түвшин болон шимтгэлийн системийн тэтгэмжийн хоорондын ялгааг тодорхойлох боломжтой болгоно.
- Удирдлага нь байгууллагын бүтэц, холбогдох салбар, үүрэг, хариуцлага, мөн суурь түвшний тэтгэмж болон шимтгэлийн системийн тэтгэмжийн ялгааг тогтоох, бүртгэлийг бий болгох, хөтлөх ажлын төлөвлөгөөг тодорхойлно. Эдгээр үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэрэгслийг хөгжүүлэх хэрэгцээ үүсэх магадлалтай.
- Анхны судалгаа хийгдсэний дараа эдгээр мэдээллийг шинэчилж байхын тулд удирдлагаас судалгаанд хамрагдсан үйлчилгээнүүдийг зохицуулагч этгээдүүдтэй гэрээ байгуулна.

Механизм

- Удирдлага нь одоо хэрэгжиж буй нийгмийн тогтолцоо, хөтөлбөрүүдээс олгогдож буй тэтгэмжийн бүртгэлийн үүсгэлт, хөтлөлтийг хариуцах газруудад нь даалгана. Ялангуяа дараах мэдээллийг цуглуулах шаардлагатай:
 - Шимтгэлийн ерөнхий тогтолцоонд хамрагдаагүй хүмүүст олгогдох боломжтой нийгмийн хамгааллын суурь түвшний нэг хэсэг бүхий нийгмийн халамжийн хөтөлбөрүүд;
 - Тэтгэмжийн нарийвчилсан хамрах хүрээ, ач холбогдол, хүн амын дундах субъектив үнэлэмж.

- Судалгаа нь хамрагдах хүн амын онцлог, түүнчлэн хүн амын насны ангилал, орлогын түвшин, газарзүйн байршил, үйл ажиллагаа, тэдгээрт нөлөөлж болзошгүй өсөлтөөс хамааран тэтгэмжийн хувьсах чадварыг харгалзан үзнэ.
- Мэдээллийн дүн шинжилгээг системчлэхийн тулд удирдлага нь дараах зүйлсийг агуулсан хяналтын самбарыг боловсруулах ёстой:
 - Хамруулах гэж буй хүн амын дундах ойлголтын дагуу одоогийн тэтгэмжүүдийн эрэмбэлсэн байдал;
 - Засгийн газар болон нийгмийн хамгааллын захиргааны хэтийн төлөв зэргийг багтаасан харьцуулалт бүхий тэтгэмжийн жишгийг тогтоох тэтгэмжийн нарийвчилсан зардал.
- Удирдлага нь судалгааг хөгжүүлэх, бүртгэлийг бий болгох, түүнээс хойших ашиглалтын төлөвлөлт болон төсвийн хуваарилалт зэргийг бий болгох холбогдох байгууллагуудтай гэрээ байгуулна.

Удирдамж 35. Албан ёсны болгох, шилжилтийн стратегийг тодорхойлох

Нийгмийн даатгалын байгууллага нь тухайн хүн амыг хамруулах тэдний хэрэгцээнд нь тохирсон үйлчилгээ, хөтөлбөрөөр дамжуулан бусад үйлчилгээ, хөтөлбөрөөс эсвэл тэдэн рүү шилжих шилжилтийг мөн харгалзан үзэж албан ёсны болгох стратегиудыг тодорхойлно.

Нийгмийн даатгалын байгууллага нь “Орхигдсон дундаж” болох хүн амыг албан ёсны болгоход чиглэсэн стратегийн үндсэн хэсэг болгон тэднийг нийгмийн даатгалд хамрагдахад тулгарч буй саад бэрхшээлийг даван туулах боломжийг олгох үйлчилгээнүүдийг боловсруулдаг.

Бүтэц

- Удирдлага нь хамруулах хүн амыг албан ёсны болгох зорилт бүхий стратегийг тодорхойлох ба явцдаа тусгайлан боловсруулсан үйлчилгээ, хөтөлбөрүүдийг бий болгож, бусад хөтөлбөрөөс болон хөтөлбөр рүү шилжих шилжилтийг харгалзан үзнэ:
- Тус стратеги нь “Орхигдсон дундаж”-ийн хүн амын анхаарлыг татахуйц үйлчилгээ, хөтөлбөрүүдийн боловсруулалтыг дэмжиж, одоо байгаа бусад үйлчилгээнүүд рүү шилжих хөдөлгөөнийг хөнгөвчлөхөөр байна;
- Хэрэгжүүлэх үйлчилгээ, хөтөлбөрүүд нь зорилтот хүн амыг албан ёсны болоход, мөн нийгмийн хамгааллын тогтолцоонд хамрагдахад тэдэнд тулгарч буй саад бэрхшээлийг даван туулахад түлхэц болох ёстой. Эдгээр нь шимтгэлийн хялбаршуулсан загвар, тухайн хүн амд шаардлагатай тэтгэмжүүд, шимтгэлд төлөх доод хэмжээ зэргээс бүрдсэн байна.
- Удирдлага нь зорилтот хүн амыг хамруулах үйлчилгээ, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд эдийн засаг, нийгэмд үзүүлэх нөлөөллийг одоо байгаа тогтолцоонуудтай харьцуулж үнэлэх ёстой. Санхүүжилтийн загвар нь нийгмийн хамгааллын тогтолцоог бүхэлд нь дунд болон урт хугацаанд тогтвортой байлгахад чиглэгдсэн байна.
- Удирдлага нь нийгмийн хамгааллын тогтолцооны бусад байгууллагуудтай хамтран зорилтот хүн амыг амьдралынх нь бүх явцын туршид даатгах стратегийг тодорхойлж, хэрэгжүүлэх ёстой.
- Удирдлага нь төрөл бүрийн аж үйлдвэр, татвар цуглуулагч, мөнгө зээлдүүлэгч болон захиргааны дэмжлэг үзүүлэгч бусад байгууллагуудыг бүртгэх үүрэг бүхий төрийн байгууллагуудтай гэрээ байгуулж, зорилтот хүн амыг албан ёсны болгоход чиглэсэн хамтын арга хэмжээг боловсруулахад менежментийн дэмжлэг үзүүлнэ.
- Удирдлага нь хамруулах хүн амын хэрэгцээг илүү сайн ойлгож, итгэл үнэмшлийг нь нэмэгдүүлэхийн тулд тус хүн амын, тухайлбал албан бус салбарын төлөөлөлтэй үйл ажиллагаагаа уялдуулах ёстой.
- Удирдлага нь албан ёсны болгох стратегийг тодорхойлохдоо актуарийн нэгжийг татан оролцуулна. Ялангуяа Нийгмийн Хамгааллын Актуарийн Ажлын талаарх

ОУНХХ-ОУХБ-ын Удирдамж дахь Нийгмийн хамгааллын тогтолцоог шинээр зохиох эсвэл өөрчлөх 43-р удирдамжийн зөвлөмжийг хэрэгжүүлнэ.

- Удирдлага нь ОУНХХ-ны Хамрах хүрээг нэмэгдүүлэх захиргааны шийдлүүдийн тухай удирдамжийн А хэсэг дэх зөвлөмжийг, ялангуяа Хамрах хүрээг өргөтгөх стратеги төлөвлөгөөг боловсруулах 3-р удирдамжид заасан зөвлөмжийг дагаж мөрдөх, тус багц Удирдамжийн Зорилтот бүлгийг тогтоох тогтолцоог бий болгох 9-р удирдамжийн арга барилыг ашиглана.

Механизм

- Удирдлага нь албан ёсны болгох ажлын хүрээг “Орхигдсон дундаж”-ийн хүн амыг хамруулах зорилго бүхий үйлчилгээгээр дамжуулан тодорхойлно. Энэ утгаараа:
 - Эдгээр үйлчилгээд хамрагдах нөхцөлийг тодорхой зааж өгөх, ялангуяа бусад шимтгэлд суурилсан үйлчилгээнүүдийнхээс ялгаатай тохиолдолд;
 - Бизнесийн үйл ажиллагааг албан ёсны болгох бусад давуу талууд болох тухайн үйл ажиллагааны эдийн засгийн мөчлөгтэй холбогдуулан татварыг бууруулах, орлогод суурилсан үүрэг зэргийг багтаах боломжийн талаар үнэлэх ёстой.
- Шилжилтийн стратегийг тодорхойлохын тулд удирдлага нь шинэ үйлчилгээнүүд болон одоо байгаа шимтгэлийн ба нийгмийн халамжийн үйлчилгээнүүдийн хоорондын уялдаа, мөн бизнесийн үйл ажиллагаанаас үүдэлтэй татварын төлбөрийг тоймлоно.
- Удирдлага нь албан ёсны болгох мөн шилжилтийн стратегиуд болон албан бус эдийн засагт ажиллаж буй хүн амыг насан туршийн нийгмийн даатгалд хамруулалтыг татварын алба, үндэсний эдийн засгийн хөгжлийн агентлаг зэрэг эдийн засгийн хөгжлийн байгууллагуудтай уялдуулан зохион байгуулна. Тус стратеги нь холбогдох ажиллагаагаар дамжуулан эдийн засгийг албан ёсны болгох явцыг хөнгөвчилж байх ёстой.
- Тодорхой үйлчилгээнүүдэд суурилсан албан ёсны болгох стратеги нь үйлчилгээ хоорондын шилжилтийг дэмжих шаардлагатай. Хүн ам нь нийгмийн халамжийн хөтөлбөрөөс тодорхой тогтолцоо руу, явцдаа шимтгэлийн ерөнхий хөтөлбөрт шилжих боломжтой байдаг. Тиймээс тус стратеги нь бусад үйлчилгээний журам, нөхцөлийг агуулах ба албан ёсны болгох үйл явцыг багтаасан байх ёстой.
- Удирдлага нь зорилтот хүн амыг хамруулах хүрээг нэмэгдүүлэх талаар олон нийтийн болон нийгмийн даатгалын тогтолцоонд шимтгэл төлөгчдийн саналыг харгалзан үзэх шаардлагатай. Нийгмийн даатгалд хамруулах, явцдаа албан ёсны болгох үйл ажиллагааны талаар олон нийтэд сөрөг сэтгэгдэл төрүүлэхгүйн тулд нийгмийн ойлголтыг анхаарч үзэх хэрэгтэй.

Удирдамж 36. Үйлчилгээ, хөтөлбөрүүдийн эдийн засгийн загварыг тодорхойлох

Нийгмийн даатгалын байгууллага эсвэл эрх бүхий байгууллага нь зорилтот хүн амыг хамруулах үйлчилгээ эсвэл хөтөлбөрүүдийн, тэр дундаа сангийн эх үүсвэр болон олгох тэтгэмжийн эдийн засгийн загварын шинж чанарыг нарийн тодорхойлно.

Бүтэц

- Удирдлага нь зорилтот хүн амыг хамруулах үйлчилгээ эсвэл хөтөлбөрийн, тэр дундаа хөтөлбөрийн төрөл, сангийн эх үүсвэр болон тэтгэмжийн эдийн засгийн загварын шинж чанарыг тодорхойлно. Эдийн засгийн загвар нь шимтгэлийн хувь хэмжээ болон тэтгэмжийг санхүүжүүлэх татаасны хувь хэмжээг тогтоох юм.
- Тус загварын эдийн засгийн хувьсагчдад хяналт тавихыг удирдлагаас хариуцах нэгжүүдэд даалгана.
- Удирдлага нь үйлчилгээний эдийн засгийн загварыг тодорхойлохдоо актуар нэгжийг татан оролцуулах шаардлагатай. Ялангуяа Нийгмийн Хамгааллын Актуарийн Ажлын талаарх ОУНХХ-ОУХБ-ын удирдамж дахь Нийгмийн хамгааллын одоогийн тогтолцоог шинээр зохиох эсвэл өөрчлөх 43-р удирдамжийн зөвлөмжийг хэрэгжүүлнэ.

Механизм

- Удирдлага нь зорилтот хүн амыг хамруулах үйлчилгээ, хөтөлбөрүүдийн эдийн засгийн загварын шинж чанарыг тодорхойлох ёстой. Ялангуяа:
 - Хөтөлбөрийн төрөл: шимтгэлтэй, шимтгэлгүй, татаастай эсвэл холимог. Холимог санхүүжилтийн тогтолцоо нь албан бус эдийн засаг дахь ажилчдын бий болгосон бизнесийн үйл ажиллагааг албан ёсны болгоход хувь нэмэр оруулж, нийгэм-эдийн засгийн бусад бодлогын хэрэгжилтийг үнэлэхэд шаардлагатай мэдээллийг цуглуулах боломжийг олгодог;
 - Сангийн эх үүсвэр: ажилчид, ажил олгогчдын төлсөн шимтэл ба засгийн газар. Хэрэв хамаарах тохиолдолд ажилчдын шимтгэлд, ялангуяа хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа тохиолдолд олгох татаасны томьёо;
 - Даатгуулагч болон түүний асран хамгаалагч авах эрхтэй уг үйлчилгээнд багтсан тэтгэмжүүд. Тэтгэмжийн хэмжээг үндэсний болон олон улсын нийгмийн хамгааллын стандартын одоо байгаа мэдээлэлд болон нийгмийн хамгааллын тэтгэмжийн олон улсын доод жишиг хэмжээг тодорхойлогч Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 1952 оны Нийгмийн Хамгааллын (доод хэм хэмжээний) Конвенц (No. 102)-од үндэслэн тогтоож болно;
 - Шимтгэлийн загвар нь аль болох хялбар байх ёстой бөгөөд тооцоолол, хэрэгжүүлэлтийн явцыг хөнгөвчлөхүйц байна. Ингэснээр зорилтот бүлгийн бий болгосон бизнесийн үйл ажиллагаатай холбоотой шимтгэл төлөлтийн тодорхой хувилбаруудыг бий болгох боломжтой.

- Хэрэв үйлчилгээ нь татаастай бол удирдлага нь татаасны эх үүсвэр, санхүүжилт хүлээн авах хуваарь, тооцооллын томьёо, Нийгмийн даатгалын байгууллагын аль хэсэг нь тус орлогод хяналт тавих үүргийг хүлээж байгааг мөн түүнийг тайлагнах бодлого зэргийг тодорхойлох ёстой.
- Удирдлага нь зорилтот хүн амыг хамруулах үйлчилгээний зарим тэтгэмжийг олгохдоо шимтгэлийн доод хэмжээ зэрэг тодорхой шалгууруудыг тавьж болно.
- Удирдлага нь зорилтот хүн амын нийгмийн хамгааллын талаарх хандлага болон шимтгэл төлөх чадвар, тэр тусмаа нийгмийн даатгалд хэр хэмжээний шимтгэл төлөх боломжтой хэмээн үзэж байгааг нь авч үзэх шаардлагатай.

Удирдамж 37. Үйлчилгээ, хөтөлбөрүүдийн байнгын нөхцөлүүдийг тогтоох

Нийгмийн даатгалын байгууллага нь зорилтот хүн амыг хамруулах зорилготой үйлчилгээ эсвэл хөтөлбөрүүдэд байнгын нөхцөлүүдийг тогтоодог.

Байнгын нөхцөл нь нийгмийн хамгааллын ерөнхий тогтолцооны, ялангуяа зорилтот хүн амыг хамруулах үйлчилгээ нь татаастай эсвэл шимтгэлийн үйлчилгээнээс ялгаатай тэтгэмжүүдийг олгох бол тогтвортой байдлыг зохицуулахад туслах зорилготой байна.

Бүтэц

- Зорилтот хүн амыг хамруулахаар боловсруулсан үйлчилгээнүүд нь байнгын нөхцөл эсвэл журамтай байх эсэхийг удирдлагаас тогтоох ёстой:
 - Байнгын нөхцөл нь бизнесийн төрөл, орлого, холбоо тогтоосноос хойш өнгөрсөн хугацаатай холбоотой байж болно. Эдгээр нь эдийн засгийн үзүүлэлтүүд эсвэл цаг хугацааны хуваарьт суурилсан байх боломжтой;
 - Даатгуулсан хугацаанаас хамааран шимтгэлийн нэмэгдлийг тогтоож болно.
- Удирдлага нь өмнөх удирдамжуудаар тодорхойлсон албан ёсны болгох болон шилжилтийн стратегиудыг харгалзан даатгах гэж буй хүн амыг хамруулсан үйлчилгээний байнгын нөхцөлүүдийг тогтооно.
- Удирдлага нь тогтолцооны байнгын нөхцөлүүдийг тодорхойлохдоо актуар нэгжийг татан оролцуулах шаардлагатай. Ялангуяа Нийгмийн Хамгааллын Актуарийн Ажлын талаарх ОУНХХ-ОУХБ-ын удирдамж дахь Нийгмийн хамгааллын одоогийн тогтолцоог шинээр зохиох эсвэл өөрчлөх 43-р удирдамжийн зөвлөмжийг хэрэгжүүлнэ.

Механизм

- Удирдлага нь зорилтот хүн амыг хамруулах үйлчилгээний байнгын нөхцөлийг тогтоох ёстой.
- Байнгын байдлын шалгуур нь эргэлтийн хэмжээ, даатгалд хамруулах үйл ажиллагааны төрөл, орлогоос суутгах зардлын хэмжээ гэх мэт үйлчилгээд хамрагдахад тавих нөхцөлд багтсан байж болно;
- Энэ нь мөн татаасыг аажмаар багасгах, шимтгэлийн хэмжээг нэмэгдүүлэх зэрэг шимтгэлийн талаар журамтай холбоотой байж болно;
 - Байнгын нөхцөл нь энгийн бөгөөд хүн амд хүлээн зөвшөөрөгдсөн параметруудад суурилсан, нийгэм-эдийн засгийн хувьслаас хамааран өөрчилж болохуйц байна.
 - Удирдлага нь үйлчилгээ тус бүрд тогтоосон параметруудийн дагуу байнгын нөхцөлийг хянах арга хэрэгслийг тодорхойлно.
- Удирдлага нь тус үйлчилгээнүүдийг хэрэгжүүлэхдээ эдгээр нөхцөлүүдэд хяналт тавих, зохицуулах журмыг бий болгох шаардлагатай.

Удирдамж 38. Олон нийттэй харилцах стратегийг тодорхойлох

Нийгмийн даатгалын байгууллага нь зорилтот хүн амыг хамруулах зорилгоор боловсруулсан үйлчилгээнүүд, ялангуяа үйлчилгээнд хамрагдах нөхцөлийн талаар, мөн бусад үйлчилгээ болон хөтөлбөрүүдтэй ямар харилцан уялдаатай болох талаар мэдээлэх олон нийттэй харилцах стратегийг боловсруулдаг.

Олон нийттэй харилцах стратеги нь зорилтот хүн амд үр дүнтэйгээр хүрч, шинэ үйлчилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилготой юм.

Бүтэц

- Удирдлага нь зорилтот бүлэгт чиглэсэн олон нийттэй харилцах стратеги боловсруулах ажлыг олон нийттэй харилцах нэгжид даалгана:
 - Үйлчилгээний үндсэн шинж чанаруудыг, ялангуяа түүнд хамрагдах нөхцөл, бүртгэлийн механизм, боломжит тэтгэмж ба хүртээмж, байнгын нөхцөл, шимтгэлийн үйлчилгээд шилжих арга замуудыг тодорхой тусгасан байх;
 - Боловсруулсан үйлчилгээг сонирхох сонирхлыг бий болгох гол хүчин зүйл нь итгэлцэл учраас тус стратеги нь хамрагдах хүн амд итгэлцэл бүхий харилцааны суурийг тавина.
- Удирдлага нь зорилтот бүлэгт ойр байх төрийн болон хувийн хэвшлийн бусад байгууллагуудыг олон нийттэй харилцах стратеги боловсруулж хэрэгжүүлэх, итгэлцлийг бий болгоход татан оролцуулах ёстой.
- Удирдлагаас анх удаа ажиллаж буй залуусыг хамруулах зорилготой үйлчилгээнүүдийн талаар мэдээлэл өгөхдөө боловсролын байгууллагуудтай гэрээ байгуулж ажиллана.
- Боловсруулсан үйлчилгээнээс хамааран нийгмийн даатгалын байгууллага нь хүн амын нас, газарзүйн тархалт, боловсролын түвшин, цахим оролцоо гэх мэтээр хүн амын тархалтыг харгалзан янз бүрийн харилцааны суваг, хэрэгслийг ашиглана.
- Олон нийттэй харилцах стратеги нь нийгмийн даатгалын байгууллагын харилцааны бодлогод суурилсан байх ёстой бөгөөд Нийгмийн Хамгааллын Байгууллагуудын харилцаа холбооны талаарх ОУНХХ-ны удирдамжийг дагаж мөрдөх ёстой.

Механизм

- Удирдлага нь Олон нийттэй харилцах нэгжийн дэмжлэгтэйгээр зорилтот бүлэгт тусгайлан зориулсан олон нийттэй харилцах стратегийг боловсруулна:
 - Зорилтот хүн амын нийгмийн хамгаалалд зориулан тусгайлан боловсруулсан үйлчилгээнүүдэд хамрагдалтыг дээд зэргээр нэмэгдүүлэхийг эрмэлзэх;
 - Тус үйлчилгээд хамрагдсанаар цаашид даатгалын түвшин хэрхэн сайжирч болох боломжуудыг (жишээлбэл, бусад үйлчилгээд шилжих гэх мэт) тайлбарлах;

- Олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн нөлөө бүхий бусад байгууллагуудыг оролцуулснаар хамрагдалтыг нэмэгдүүлж, байгууллага хоорондын хамтын ажиллагааг бий болгоно.
- Удирдлага нь мэдээллийн материалыг олшруулан түгээх үүргийг гүйцэтгэх боломж бүхий байгууллагуудтай хамтран ажиллаж болно. Үүний тулд бүртгэл, шимтгэл төлөлт, тэтгэмж, төлбөрийг олгох ажилд оролцож буй бүх талуудаас өгч буй мэдээллийг уялдаа холбоотой байлгах үүднээс сургалтын төлөвлөгөөг боловсруулна.
- Удирдлага нь зорилтот хүн амын оршин суудаг газар эсвэл тэдний ажил явагдаж буй байршилтай ойролцоо мэдээлэл өгөх арга хэмжээг боловсруулах ёстой.
- Удирдлага нь олон нийттэй харилцах ерөнхий стратегийн хүрээнд олон нийтийн сүлжээн дэх харилцаа холбооны төлөвлөгөөг боловсруулахдаа зорилтот хүн амын цахим оролцоо, ялангуяа интернэт болон гар утасны хүртээмж хэр зэрэг байдгийг үнэлэх ёстой.

Удирдлага 39. Захиргааны үйл явцыг хялбарчлах: Бүртгэл ба хамруулалт

Нийгмийн даатгалын байгууллага нь зорилтот хүн амыг бүртгэх, хамруулах хялбаршуулсан явцыг бий болгоно.

Нийгмийн даатгалын байгууллага нь зорилтот хүн амыг албан ёсны болгоход захиргааны нарийн төвөгтэй байдал нь хүндрэл үүсгэдэг болохыг бодолцох нь зүйтэй. Тиймээс шинэ үйлчилгээд бүртгэх, хамруулах үйл явцыг хялбарчлах хэрэгтэй. Энэхүү явцаар хамруулах нөхцөлүүдийг баримталж байгаа эсэхийг мөн хянана.

Бүтэц

- Удирдлага нь зорилтот хүн амыг хамруулах үйлчилгээ, хөтөлбөрт бүртгүүлэх, хамруулах ажлыг хөнгөвчлөх зорилго бүхий хялбаршуулсан явцыг хэрэгжүүлэхийг хамаарах газруудад даалгана. Ялангуяа:
 - Техник технологийн дэвшлийг ашиглан өөрсдөө бүртгүүлэх механизмыг хөгжүүлэх;
 - Үйлчилгээ эсвэл хөтөлбөрт хамрагдах журмын хэрэгжүүлэлтийг сахина.
- Удирдлага нь бусад байгууллагатай харилцан мэдээлэл солилцох, нэгдсэн бүртгэлийн журмыг хэрэгжүүлж, бүртгэл, хамруулалтын үйл ажиллагаанд чиглүүлэгчийн үүрэг гүйцэтгэх гэрээг байгуулна. Үйлчилгээний хэрэгжилтэд түншлэлийг харилцааг ашиглах 4-р удирдамж нь ийм үед онц ач холбогдолтой.
- Удирдлага нь энэхүү багц удирдамжийн А.4 буюу Үр Дүнтэй Бүртгэлийн Тогтолцоог Хөгжүүлэх нь хэсэгт заасан зөвлөмжийг мөрдөж, энэ багц удирдамжийн Зорилтот бүлгийг тогтоох тогтолцоог бий болгох 9-р удирдамж дээрх арга замуудыг ашиглана.

Механизм

- Удирдлага нь гишүүнчлэлийн бүртгэл хариуцсан нэгжүүдэд бүртгэл, хамруулалтын хялбаршуулсан явцыг хэрэгжүүлэх зааварчилгааг өгнө:
 - Хүртээмжтэй хэл, энгийн хэрэглэгчийн цэсийг ашиглан зорилтот бүлэгт тохирсон үйлчилгээг хөгжүүлэх;
 - Одоо байгаа мэдээллийг ашиглан хэрэглэгчээс бөглөх мэдээллийг багасгах, ялангуяа нийгмийн даатгалын байгууллага эсвэл бусад байгууллагаас аль хэдийн ирүүлсэн эсвэл үүсгэсэн мэдээллийг шаардахаас зайлсхийх;
 - Тус явц нь зорилтот хүн амд нийцүүлсэн төхөөрөмж, технологи ба хандалтын хэрэгслүүдээр дамжуулан хүртээмжтэй байх;
 - Тус явц нь хамруулах нөхцөлийг дагаж мөрдүүлэх, мэдээллийн чанарыг сайжруулах үр дүнтэй зохион байгуулалтын арга хэмжээг багтаасан байна.
- Удирдлага нь хүртээмж ба ашиглалтыг нэмэгдүүлэх зэрэг онцлогт нь тохирсон ажлуудыг хэрэгжүүлэх замаар захиргааны тодорхой журам, механизмыг хүн амын

бүлэг, үйл ажиллагааны төрлөөр нь тодорхойлно. Хэрэглэгдэх технологи нь уян хатан, боломжийн үнэтэй байна. МХХТ-ийн чадавхыг бүрдүүлэх 6-р удирдамжид заасан зөвлөмжийг анхаарч үзэх, ашиглах хэрэгтэй.

- Удирдлага нь албан ёсны болгох явцыг олон талаас нь хялбаршуулах үүднээс бусад агентлагуудтай хамтран бүртгэл, хамруулалтын журмыг хэрэгжүүлэх шаардлагатай:
 - Зорилтот хүн амыг албан ёсны болгоход үүрэг гүйцэтгэх бусад байгууллагуудтай (жишээ нь: Татварын газар, Эрүүл мэнд, салбарын зөвшөөрөл олгогч, орон нутгийн бүртгэл хариуцсан газар гэх мэт) нэг цэгийн үйлчилгээнд түшиглэсэн бүртгэлийн нэгдсэн механизмыг хөгжүүлнэ. Байгууллагуудын мөрдөж буй аргачлалыг болон хамтран ашиглаж буй мэдээлэл, түүний чанарыг нарийвчлан үнэлсэн байна. Үүн дээр үндэслэн зорилтот хүн ам нь аль ч байгууллага эхэлж холбогдож магадгүйг харгалзан үзэж, үйлчлүүлэгчтэй харилцах шинэ хандлагыг тодорхойлно;
 - Явцын зарим хэсгийг гүйцэтгэх, эсвэл хувь хүмүүсийг бүртгүүлэхэд нь туслах зэрэг тусалцааны үүрэгтэйгээр бусад байгууллагуудыг татан оролцуулах;
 - Бүртгэх, хамруулах үйл явцын хурд, чанарыг сайжруулах зорилгоор мэдээлэл солилцох үйл ажиллагааг хөнгөвчлөх;
 - Бүртгэлийг бусад этгээдүүдээр дамжуулан хийхдээ хяналтын тодорхой механизмыг ашиглана.
- Удирдлага нь зорилтот хүн амыг бүртгэхэд шаардагдах мэдээллийн нарийвчилсан жагсаалтыг гаргах, Нийгмийн даатгалын байгууллагын мэдээллийн санд ямар нь байгаа, эсвэл цуглуулах ёстойг олж тогтоох ажлыг хариуцах газруудад даалгана. Хариуцсан газрууд нь мэдээллийн чанарыг байнга үнэлэх ба эх сурвалжаас хамаарах чанарын хувьсах үзүүлэлтүүдийг харгалзан үзэж хянан шалгах эцсийн хугацааг тогтооно. Удирдамж 12 буюу Мэдээллийн сангийн чанарыг сайжруулах механизмын хэрэгжилтийг анхаарч үзэх хэрэгтэй.
- Удирдлага нь шинэ үйлчилгээнүүдээс татгалзсан, эсвэл хувь хүний санхүүгийн байдалтай уялдаагүйгээр шимтгэлийн төлөлтийн тасалдсан эсэхийг хянах систем боловсруулна.

Удирдлага 40. Захиргааны үйл явцыг хялбарчлах: Шимтгэл төвлөрүүлэлт

Нийгмийн даатгалын байгууллага нь зорилтот хүн амыг хамруулах үйлчилгээ эсвэл хөтөлбөрт зориулж шимтгэл төвлөрүүлэх хялбар процессыг бий болгоно.

Бусад явцын адил бүртгэлийн дараах шимтгэл төлөлтийн явцад учрах хүндрэлийг бууруулах зорилготой.

Бүтэц

- Удирдлага нь зорилтот хүн амыг хамруулах зориулалттай үйлчилгээ, хөтөлбөрийн шимтгэлийг төвлөрүүлэх үйл явцыг хялбаршуулан хэрэгжүүлэхийг хариуцах газруудад даалгана. Ялангуяа:
 - Сайн дурын дагуу хэрэгжүүлж болохуйц байх хялбаршуулсан арга барил, механизмыг сурталчлах;
 - Шимтгэл төлөх боломжтой цахим механизмуудыг авч үзэх;
 - Бусад этгээдүүдтэй хамтарсан шимтгэл цуглуулах явцыг бий болгож, шаардлагатай гэрээ хэлэлцээрийг байгуулж, зохих хяналтын механизмыг хэрэгжүүлнэ.
- Удирдлага нь бүртгүүлсэн хүний нэрийн өмнөөс шимтгэл төлж болох хувь хүн эсвэл аж ахуйн нэгжийг тодорхойлно.
- Удирдах зөвлөл болон удирдлага нь бусад байгууллагатай мэдээлэл солилцох боломжийг хууль эрх зүйн болон зохицуулалтын хүрээнд баталгаажуулж, мэдээлэл хадгалахтай холбоотой үүрэг хариуцлагыг тогтооно. Энэхүү багц удирдамжийн Шимтгэл төвлөрүүлэх, дагаж мөрдөх журмыг хэрэгжүүлэх зорилгоор бусад байгууллагуудтай хамтран ажиллах 15-р удирдамжийн зөвлөмжийг дагаж мөрдөнө.
- Удирдлага нь хувь хүмүүсийг тодорхойлох үр дүнтэй механизмыг ашиглаж, энэхүү багц удирдамжийн 9-р удирдамжийн Зорилтот бүлгийг тогтоох тогтолцоог бий болгох зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх ёстой.
- Шимтгэл төвлөрүүлэх явцыг хялбарчлахдаа энэхүү багц удирдамжийн А.5-д заасан удирдамж, түүнчлэн ОУНХХ-ын Шимтгэл төвлөрүүлэх, Нийцлийн Удирдамж-ийг дагаж мөрдөх ёстой.

Механизм

- Удирдлага нь шимтгэл төвлөрүүлэх үүрэг бүхий газруудад хялбаршуулсан явцыг хэрэгжүүлэх зааварчилгаа өгнө:
 - Хүртээмжтэй хэл, энгийн хэрэглэгчийн цэсийг ашиглан, хамрагдах хүн амд чиглэсэн зорилтот харилцагчийн үйлчилгээг хэрэгжүүлэх;
 - Бусад агентлагуудтай хамтран зорилтот хүн амын шимтгэлийг төвлөрүүлэх нийтлэг нэг цэгийн үйлчилгээг хөгжүүлэх;

- Бусад байгууллагуудаас ирүүлсэн болон өөрт байгаа мэдээллийг ашиглан шаардагдах мэдээллийг багасгах;
- Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай байгуулсан гэрээний үндсэн дээр энгийн бөгөөд хүртээмжтэй механизмуудаар, ялангуяа дижитал механизмаар дамжуулан шимтгэл төлөлтийг хөнгөвчилнө.
- Удирдлага нь шимтгэлийн төлж болох төрөл бүрийн арга хэрэгслийг сурталчлах төлөвлөгөө гаргахаас гадна зорилтот бүлэгт хамгийн тохиромжтой арга хэрэгслүүдэд үйл ажиллагаагаа хандуулна.
- Удирдлага нь энэхүү багц удирдамжийн Шимтгэл төлөх тохиромжтой арга, давтамжийг хэрэгжүүлэх 14-р удирдамжид дурдсан нийгмийн даатгалын шимтгэлийн төлөлтийг бусад үүрэг хариуцлагатай уялдуулах боломжуудад дүн шинжилгээ хийнэ.
- Удирдлага нь бусад байгууллагатай байгуулсан гэрээ болон тэдний хамруулах хүн амын онцлог шинжид төвлөрсөн дараагийн төлөвлөгөөнүүдийг хянаж, шимтгэл төвлөрүүлэхэд оролцож болох бусад байгууллауудыг тодорхойлно.
- Шимтгэл төвлөрүүлэх үүрэгтэй газрууд нь шимтгэл төвлөрүүлэх арга хэрэгслийн жагсаалтыг хөтөлж, хэрэглээ, ашиглалтын зэрэг, байгууллагаас гарах зардал болон аюулгүй байдлыг үнэлж, төлбөрийн шинэ хэрэгслийг тогтоох механизмыг тодорхойлох ёстой.
- Нийгмийн даатгалын байгууллага нь хэрэглэгчдийн санал хүсэлтийг харгалзан үзэж бусад байгууллагуудын бүртгэл болон шимтгэл төвлөрүүлэлтийн үр дүнг үнэлнэ.
- Удирдлага нь үйлчилгээний өөрчлөлттэй холбоогүйгээр шимтгэл төлөлтийн тасалдлыг хянах тогтолцоог бий болгоно.

Удирдамж 41. Захиргааны үйл явцыг хялбарчлах: Тэтгэмж хүртээх журам, арга хэрэгсэл

Нийгмийн даатгалын байгууллага нь тэтгэмж хүртээх зорилтот хүн амыг хамарсан үйлчилгээ, хөтөлбөрүүдийн энгийн журмыг боловсруулдаг.

Тэтгэмжийг хялбар аргаар хүртээх нь эерэг ойлголтыг бий болгох ба даатгуулах сонирхлыг нэмэгдүүлнэ гэдгийг Нийгмийн даатгалын байгууллага харгалзан үзэх ёстой.

Бүтэц

- Удирдлага нь зорилтот хүн амыг хамруулах зорилготой үйлчилгээ, хөтөлбөрийн гишүүд тэтгэмж авах хүсэлт гаргах, хүсэлтийн зөвшөөрөл, тэтгэмжийг олгох явцыг хөнгөвчлөх хялбар журмыг хэрэгжүүлэхийг хариуцах газруудад даалгана:
 - Тэтгэмж хүсэх үйл явц нь тодорхой, аюулгүй, хэрэглэгчдэд ээлтэй байх ёстой бөгөөд төрөл бүрийн хэрэгслээр дамжуулан хүсэлт гаргах боломж олгох олон сувгийн аргад суурилсан байх ёстой;
 - Хүсэлт гаргах, зөвшөөрсөн шийдвэрийг мэдээлэх, тэтгэмжийн олголт зэрэг явц хоорондын хугацааг багасгах хэрэгтэй.
- Нийгмийн даатгалын байгууллага нь тэтгэмж авах эрх бүрдэх нөхцөл, хүсэлтэд тавигдах шаардлага, хүсэлт гаргаснаас хойш тэтгэмжийг олгох явц хоорондын хүлээгдэх хугацааг тодорхой зааж өгөх ёстой.
- Удирдлага нь бусад байгууллагуудтай мэдээлэл солилцох, нийтлэг үйлчилгээг хэрэгжүүлэх гэрээ байгуулна. Бусад түншүүдээр дамжуулан олгогдож байгаа эсвэл олгосон тэтгэмжийг мөн хянах шаардлагатай.
- Удирдлагаас стандартын биелүүлэлтийг хангах, алдаа гаргахаас сэргийлэх, зайлсхийлт, залилангаас сэргийлэх үр дүнтэй хяналтуудыг хэрэгжүүлнэ.
- Удирдлага нь шинэ үйлчилгээний талаарх олон нийтийн үзэл бодлыг харгалзан үзэж, тэтгэмж олголтод чиглэсэн үйлчилгээний чанарыг үнэлэх шаардлагатай.
- Удирдлага нь ОУНХХ-ны Хамрах хүрээг нэмэгдүүлэх захиргааны шийдлийн талаар багц удирдамжийн А.6 дахь зөвлөмжийг дагаж мөрдөхөөс гадна энэхүү багц удирдамжийн Зорилтот бүлгийг тогтоох тогтолцоог бий болгох 9-р удирдамжаар санал болгож буй арга барилыг ашиглана.

Механизм

- Удирдлага нь тэтгэмж хүсэх, хүсэлтийг зөвшөөрөх, тэтгэмж олгох ажлыг хөнгөвчлөх зорилго бүхий хялбаршуулсан явцыг хэрэгжүүлэхийн тулд тэтгэмжийг зохицуулах үүрэг бүхий газруудад зааварчилгаа өгнө:
 - Зорилтот хүн амд зориулсан хэрэглэгчийн үйлчилгээг хүртээмжтэй хэл, энгийн хэрэглэгчийн цэсийг ашиглан хөгжүүлэх;
 - Зорилтот хүн амыг албан ёсны болгоход чухал үүрэг бүхий бусад агентлагуудтай хамтран нийтлэг нэг цэгийн үйлчилгээг хөгжүүлэх;

- Өөрт байгаа болон хуваалцсан мэдээллийг ашиглан шаардагдах мэдээллийг багасгана. Нийгмийн даатгалын байгууллага эсвэл бусад байгууллагаас аль хэдийн илгээсэн эсвэл үүсгэсэн мэдээллийг нэхэхээс зайлсхийх;
- Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллах байдлаар төлбөрийн цахим сувгийг ашиглан тэтгэмж олгох явцыг хөнгөвчилнө.
- Удирдлага нь олон сувагт нөхцөлд тэтгэмж олгох цахим үйлчилгээнүүдийн хүрэлцээг нэмэгдүүлэх зорилгоор үйлчлүүлэгчдийн цахим оролцоог дэмжих хэрэгтэй.
- Удирдлага нь тэтгэмж хүртэгчдийн ашигладаг арга хэрэгсэлтэй ижил арга хэрэгслийг ашиглан хамрагдсан хүн амд шууд болон шууд бус байдлаар туслалцаа үзүүлэх (жишээлбэл аппликейшнүүдийг холбох замаар) бусад байгууллагуудтай гэрээ байгуулна.
- Удирдлага нь дараах зүйлс дээр хяналтын тогтолцоог бий болгоно:
- Тэтгэмж хүссэн өргөдөл, нэхэмжлэл;
- Тэтгэмжийн хүсэлт гаргах, тэтгэмж авахад ашиглагдах сувгууд;
- Тэтгэмжийн хүртээмжтэй холбоотой үйлчилгээний чанар, хүсэлт гаргахаас олгох хүртэлх хугацааг тооцох, тэтгэмж олгосны дараах санал хүсэлт авах, мөн тэтгэмж авахад гарч болох бэрхшээлүүдийн талаар урьдчилан мэдээлэхэд туслах бусад үзүүлэлтүүд;
- Тэтгэмж хүсэхээс авхуулаад олгох хүртэлх явцад тогтоосон харилцаа холбоо.

